



МОНГОЛ УЛС

ОУВС-ГИЙН ДҮРМИЙН IV ЗААЛТЫН 2017 ОНЫ ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ӨРГӨДӨЛ— ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ; АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН; МОНГОЛ УЛСЫГ ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭДЭГДЭЛ

2017 оны 5
дугаар сар

ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах өргөдлийн хүрээнд дараах баримт бичгийг нийтэд түгээсэн бөгөөд энэхүү багцад хамруулсан болно. Үүнд:

- Дүрмийн VI заалтын зөвлөлдөх хэлэлцүүлэг болон ОУВС-гийн хөтөлбөртэй холбоотой асуудлаар ажлын хэсгийн тайлантай холбогдуулан Захирлуудын зөвлөлийн даргын хийсэн мэдэгдэл болон Захирлуудын зөвлөл 2017 оны 5 сарын 24-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн гаргасан саналыг нэгтгэсэн **хэвлэлийн мэдээнүүд**;
- ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн 2017 оны 5 сарын 24-ний өдрийн хуралд зориулан 2017 оны 2 дугаар сарын 19-нд дуусгавар болсон хэлэлцүүлгийн дүнгээр шинжээчдийн багаас боловсруулсан **Ажлын хэсгийн тайлан**. Эдгээр хэлэлцүүлгийг хийх үеийн мэдээлэлд үндэслэн ажлын хэсгийн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр бичиж дууссан болно.
- ОУВС-гийн мэргэжилтнүүдийн боловсруулсан **Мэдээллийн хавсралт**;
- Сүүлийн үеийн хөгжил, өөрчлөлтийг тусгасан **Хавсралт тайлан**;
- Монгол улсыг хариуцсан **гүйцэтгэх захирлын мэдэгдэл** зэргийг багтаасан болно.

ОУВС-гийн ил тод байдлын журам ёсоор зах зээлд нөлөөлөх мэдээлэл, эсвэл эрх баригчдын бодлогын төслийг олон нийтэд хэвлэн мэдээлж буй албан хэрэгцээний тайлан мэдээ болон бусад баримт бичгээс хасч болно.

Энэхүү тайлангийн хуулбарыг дор дурдсан хаягаар олон нийтэд нээлттэй түгээж байна.

Олон Улсын Валютын Сан □ Хэвлэлийн алба Шуудангийн хайрцаг 92780 □ Вашингтон, К.Т.
20090 Утас: (202) 623-7430 □ Факс: (202) 623-7201

Цахим шуудан: publications@IMF.org

Цахим хуудас: <http://www.IMF.org>

Үнэ: хэвлэмэл хувь тус бүр 18.00 ам.доллар

Олон Улсын Валютын Сан, Вашингтон, К.Т.



INTERNATIONAL MONETARY FUND



Хэвлэлийн мэдээ No. 17/193
ШУУД ТҮГЭЭХ
2017 оны 5 сарын 24

Олон Улсын Валютын Сан
Вашингтон, К.Т. 20431 АНУ

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл Монголд Улсад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг баталлаа

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Захирлуудын зөвлөл гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд зээл авах тухай Монгол Улсын хүсэлтийг өнөөдөр авч хэлэлцэн баталлаа. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 314.5054 зээлжих тусгай эрх (ЗТЭ) (ойролцоогоор 434.3 сая ам. доллар буюу Монгол Улсын квотын 435 хувьтай тэнцэх хэмжээ)-ийн санхүүжилтээр дэмжих юм. Бусад түншүүд, тэр дундаа Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Япон Улс, БНСУ төсвийн болоод төслийн дэмжлэг үзүүлэхээ амласан бол Хятадын Ардын Банк Монголбанктай байгуулсан своп шугамын хугацааг сунгахыг зөвшөөрсөн. Ингэснээр нийтдээ 5.5 тэрбум ам. долларын санхүүжилтийн багц бүрдэж байна. Захирлуудын зөвлөл хөтөлбөрийг баталснаар 27.9560 сая ЗТЭ (ойролцоогоор 38.6 сая ам. доллар)-ийн санхүүжилт нэн даруй олгогдох болно.

Эрх баригчдын боловсруулсан хөтөлбөрийн гол зорилго нь эдийн засгийг тогтворжуулж, итгэл найдварыг сэргээн, эдийн засгийг сэргээх орчин нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Төсвийн алдагдлыг бууруулах нь хөтөлбөрийн гол тулгуур бөгөөд энэ нь дотоодын санхүүгийн зах зээл дээрх дарамтыг бууруулах, гадаад секторын үзүүлэлтүүдийг тогтворжуулах, өрийн тогтвортой байдлыг сэргээх юм. Эдийн засагт тохиргоо хийгдэх явцад ядуу эмзэг бүлгийг хамгаалах нийгмийн халамжийн чухал арга хэмжээнүүдээс гадна төсвийн тохиргооны үр дүн урт удаан хугацаанд хадгалагдах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн институцийн шинэчлэлүүд мөн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих болно. Хөтөлбөрийн өөр нэг тулгуур нь банкны системийг сэргээн тогтворжуулж, Монголбанкийг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ юм. Бүтцийн шинэчлэлийн өргөн хүрээний арга хэмжээнүүд хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэх болно.

Монгол улстай хийсэн ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийг Захирлын зөвлөл өнөөдөр дуусгаж байна. Энэ тухайд хэвлэлийн тусгай мэдээ шууд түгээнэ.

Захирлуудын зөвлөлийн шийдвэр гарсантай холбогдуулан ОУВС-гийн дэд тэргүүн, Зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч ноён Мицүхиро Фурусава дараах мэдэгдлийг гаргав. Үүнд:

“Түүхий эдийн үнэ огцом унаж, экспортын гол зах зээл агшсанаас үүдэн Монголын эдийн засаг хүнд цохилтод өртөөд байна. Эдгээр цочир хүндрэлийг тэлэх бодлогоор сөрөх оролдлого үр дүнгүй болж, улмаар улсын өрийн тогтвортой байдал алдагдаж, гадаад валютын нөөц багасч, эдийн засгийн өсөлт буурсан.

“Ийм нөхцөлд Монгол улсын эрх баригчид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийг сэргээх орчин нөхцлийг бүрдүүлэх, эдийн засгийн тохиргооны явцад эмзэг бүлгийг хамгаалах хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Төсвийн алдагдлыг бууруулах нь энэхүү хөтөлбөрийн шийдвэрлэх ач холбогдол бүхий арга хэмжээ бөгөөд энэ хүрээнд тэвчиж болох зардлыг танаж, зарим төрлийн татварыг шатлалтай болгож, тэтгэврийн болон төрийн санхүүгийн удирдлагыг шинэчлэн, нийгмийн халамжийн тогтолцоог бэхжүүлж, зорилтот бүлэгт илүү сайн чиглүүлэх болно. Төсвийн чиглэлээр хэд хэдэн бүтцийн шинэчлэл төлөвлөгдсөний нэг нь хараат бус бие даасан төсвийн зөвлөл байгуулах явдал бөгөөд энэ нь төсвийн сахилга батыг бэхжүүлэхэд нэн ач холбогдолтой юм. Төсвийн хүрээнд томоохон тохиргоо хийгдэж, хөгжлийн түншүүдийн хөнгөлөлттэй санхүүжилт харилцан уялдаатай олгогдож, засгийн газрын бонд эзэмшигчидтэй тогтоосон харилцаа хадгалагдснаар өрийн тогтвортой байдал хангагдаж, гадаад валютын нөөц эргэж нөхөгдөх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Валютын ханш зах зээлийн зарчмаар тогтох нь зүйтэй гэсэн тууштай байр суурь баримталж байгаа нь эдийн засгийн гадаад цочролыг даах чадварыг бэхжүүлж өгөх юм. Үүнтэй зэрэгцээд мөнгөний зохистой бодлого, хөтөлбөр батлагдсантай холбоотойгоор сэргэх итгэл найдвар, хувийн хэвшлийн нэмэгдэх хөрөнгийн урсгал эерэг нөлөөлөл үзүүлнэ. Монголбанкны засаглал, хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх үүднээс Төв банкны тухай хуулийг шинэчлэн батлуулахаар төлөвлөж байна.

Иж бүрэн стратегийн хүрээнд банкны салбарыг эрүүлжүүлж, хяналт шалгалт, зохицуулалтын чадавхийг бэхжүүлэн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх болно. Хөтөлбөрийн хүрээнд тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход чиглэсэн бүтцийн шинэчлэлийн арга хэмжээнүүд мөн тусгагдсан бөгөөд эдгээр нь бизнесийн орчинг сайжруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой юм.

“Амжилтанд хүрэхийн тулд хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх явдал маш чухал. ОУВС, Монгол Улсын хөгжлийн түншүүдийн хамтаар Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой туслалцаа дэмжлэгийг эрх баригчдад үзүүлэн ажиллахад бэлэн байна.”

ХАВСРАЛТ

Эдийн засагт сүүлийн үед гарсан өөрчлөлтүүд

Нийт экспортын 90 орчим хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзэлдэг тул 2011 оноос эхэлсэн түүхий эдийн үнэ огцом унаснаар төлбөрийн тэнцэл, төсөв санхүүгийн байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн байна. Эдийн засгийг гадаад цочролоос хамгаалах үүднээс макро эдийн засгийн бодлогыг зөөлрүүлсэн нь эдийн засгийн өсөлтийг хэсэг хугацаанд дэмжсэн боловч үүний үр дүнд улсын өр нэмэгдэж, төлбөрийн тэнцэл доройтож, банкны активын чанар муудсан. Төсвийн алдагдал үлэмж нэмэгдэж, төгрөгийн ханш суларсны улмаас 2016 оны эцэст улсын өр ДНБ-ий 90 хувьд дөхөж очив.

Эрх баригчид эдийн засгийн хүндрэлийг хүлээн зөвшөөрч, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр боловсруулан, өнгөрсөн хугацаанд баримталсан бодлогоос үндсэндээ татгалзаж, ОУВС-д хандан дэмжлэг хүссэн.

Хөтөлбөрийн хураангуй

Өргөтгөсөн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр хэрэгжих хөтөлбөрийн зорилт нь эдийн засгийг тогтворжуулж, итгэл найдварыг сэргээн, эдийн засгийг сэргээх орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Хөтөлбөрийн гол тулгуур нь төсвийн алдагдлыг бууруулах явдал бөгөөд ингэснээр дотоодын санхүүгийн зах зээл дээрх дарамтыг бууруулж, гадаад секторын үзүүлэлтүүдийг тогтворжуулан, өрийн тогтвортой байдлыг сэргээх юм.

Хөтөлбөрийн хүрээнд цаашид тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох үндэс суурь тавигдах болно. Өнгөрсөн хугацааны өндөр өсөлт, уналтын мөчлөгийг таслан зогсоох зорилгоор

шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд: (i) төсвийн бодлогыг сахилга баттай болгох; (ii) төв банкны хараат бус бие даасан байдал, засаглалыг бэхжүүлж, үйл ажиллагааг үндсэн чиг үүрэгт төвлөрүүлэх; (iii) санхүүгийн салбарыг бэхжүүлэх; (iv) эдийн засгийг төрөлжүүлэх, хүртээмжтэй өсөлтийг дэмжих; (v) нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах.

Төсвийн бодлого. Төсвийн орлого, зарлагын тохиргоо хийгдэж, эдийн засгийн өсөлт төсөөлж байгаа хэмжээнд хүрч сэргэн, дотоод бондын хүү аажмаар хэвийн түвшинд очиж, хөтөлбөрийн хүрээнд эрх баригчид хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилт авч ашигласнаар өрийн тогтвортой байдал нөхөн хангагдана гэж тооцож байна.

Мөнгөний болон ханшийн бодлого. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг шинэчлэн баталж, Монголбанкны эрх үүргийг тодотгон, засаглал, бие даасан байдлыг бэхжүүлэх болно. Мөнгөний бодлого ойрын үед хатуу хэвээр хадгалагдаж, ханш уян хатан байх шаардлагатай.

Санхүүгийн салбарын шинэчлэл. Эрх баригчид эхний ээлжинд банкны системийн иж бүрэн үнэлгээ хийж, банкуудын санхүүгийн байдал, эрсдэл даах чадварын түвшинг тогтооно. Дараагийн алхамд шаардлагатай бол дахин хөрөнгөжүүлэлт, бүтцийн өөрчлөлт хийгдэнэ. Зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлнэ.

Өсөлтийг дэмжсэн бүтцийн өөрчлөлт. Монгол Улс эрдэс баялгийн арвин их нөөцтэй учраас тус улсын эдийн засагт уул уурхай хэзээд гол салбар байх болно. Гэхдээ хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг хөгжүүлэх асар их нөөц бололцоо харагдаж байна. Хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийг солонгоруулах бодлогыг дэмжих, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн бүтцийн шинэчлэлийн арга хэмжээнүүд хэрэгжих болно.

Нийгмийн хамгаалал. Хөтөлбөрийн хүрээнд нийгмийн эмзэг бүлгийг хамгаалахад чиглэсэн халамжийн чухал арга хэмжээнүүд багтсан бөгөөд эрүүл мэнд, боловсролын салбарт түлхүү ач холбогдол өгсөн. Тухайлбал, хүүхдийн мөнгө хөтөлбөрийг зорилтот бүлэгт илүү сайн чиглүүлснээр хэмнэгдэх хөрөнгийг бүхэлд нь ядуу эмзэг бүлэгт зориулсан хүнсний талон хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд ашиглах болно.

Хөтөлбөрийн санхүүжилт. Засгийн газрын хөтөлбөрийг бусад олон улсын түншүүд мөн дэмжин ажиллахаар төлөвлөж байна. Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, хоёр талт түншүүд, тэр дундаа, Япон Улс болон БНСУ төсвийн болон төслийн дэмжлэгээр нийтдээ 3 хүртэл тэрбум ам. долларын санхүүжилт олгохоор хүлээгдэж байна. Түүнчлэн, Хятадын Ардын Банк Монголбанкинд нээсэн 15 тэрбум юанийн своп шугамын хугацааг хамгийн багадаа гурван жилээр сунгахаар тооцоолж байна.



Хэвлэлийн мэдээ No. 17/198
ШУУД ТҮГЭЭХ
2017 оны 5 дугаар сарын 31

Олон Улсын Валютын Сан 700 19-р
гудамж, БХ Вашингтон, К.Т. 20431
АНУ

ОУВС-гийн Захирлуудын зөвлөл Монгол улстай хийсэн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийг дүгнэв

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн Захирлуудын зөвлөл 2017 оны 5 сарын 24-ны өдөр Монгол улстай хийсэн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийг дүгнэв.

Монгол улс байгалийн асар их баялагтай учраас урт хугацааны хэтийн төлөв нь гэрэл гэгээтэй харагдаж байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд гадаад шок, төсвийн болон мөнгөний тэлэх бодлого бүтцийн доголдолд нэрмээс болсны уршгаар эдийн засаг ихээхэн сорилт бэрхшээлтэй тулгарч байна. 2016 онд бүрэлдсэн шинэ Засгийн газар макро эдийн засгийн бодлогыг чангатгах, эдийн засгийг тогтворжуулах, цаашид тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн үндэс суурийг тавих үүднээс бүтцийн шинэчлэл хэрэгжүүлэхээ тууштай илэрхийлж байна.

Экспортынхоо бүтцээс хамааран Монгол улс гэнэтийн гадаад шокт өртөмтгий хэвээр байна. Үүнтэй холбоотойгоор үндсэн зорилго бол өмнөх жилүүдийн тэлэлт, агшилтын мөчлөгөөс зайлсхийх явдал юм. Төсөв, санхүүгийн тогтолцоо, бодлогын сахилга батыг чангатгах, эдийн засгийг төрөлжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс бүтцийн шинэчлэлийн хамт нийгмийн хамгааллын сүлжээг бэхжүүлэн илүү зорилтот бүлэгт чиглүүлэх асуудлуудад хэлэлцүүлгийн үеэр анхаарлаа хандуулсан болно.

Захирлуудын зөвлөлийн үнэлгээ²

Монгол улсын эдийн засаг түүхий эдийн үнийн уналт болон экспортын гол зах зээл хумигдсанаас шалтгаалан хүнд цохилтод өртсөн болохыг Гүйцэтгэх захирлууд цохон тэмдэглэжээ. Эдгээр гадаад шокийн нөлөөллийг тэлэх бодлогоор дамжуулан гэтлэн давах гэсэн хүчин чармайлт амжилтанд хүргээгүй, харин эсрэгээрээ төсвийн алдагдал, улсын өрийг их хэмжээгээр өсгөн, гадаад валютын нөөц огцом буурахад хүргэсэн байна. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусгасанчлан тогтвортой байдлыг сэргээх, макро эдийн засгийн зохистой бодлого, бүтцийн шинэчлэл хийх замаар тогтвортой, хурдацтай болон хүртээмжтэй өсөлтийн үндэс суурийг тавихаар зорьж буй шинэ Засгийн газрын тууштай бодлогыг Захирлууд сайшаан дэмжлээ. ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн хүрээнд томоохон тохиргоо хийгдэж, хөгжлийн түншүүдийн хөнгөлөлттэй санхүүжилт харилцан уялдаатай олгогдож, засгийн газрын бонд эзэмшигчидтэй тогтоосон харилцаа хадгалагдснаар өрийн тогтвортой байдал хангагдахад дэмжлэг болно.

Захирлууд, төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн сахилга батыг хангах явдал бол өрийн тогтвортой байдлыг урт хугацаанд хангахад шийдвэрлэх ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэв. Тэд тэвчиж болох зардлыг танах, татварын орлого болон тэтгэврийн шимтгэлийг нэмэгдүүлэх

¹ ОУВС-гийн Дүрмийн 4-р заалтын дагуу ОУВС гишүүн орнуудтайгаа хоёр талын зөвлөлдөх хэлэлцүүлгийг гол төлөв нэг жилийн давтамжтай хийдэг. ОУВС-гийн ажлын хэсэг гишүүн оронд очиж, эдийн засаг, санхүүгийн мэдээ мэдээллийг цуглуулан, тус улсын эдийн засагт гарсан өөрчлөлт дэвшил, хэрэгжүүлж буй бодлогын талаар албаны хүмүүстэй уулзаж санал солилцдог. Хэлэлцүүлгийг дүгнэн, ажлын хэсэг тайлан гаргаж, Захирлуудын зөвлөлд танилцуулдаг.

² Захирлуудын зөвлөл тайланг хэлэлцсэний дараагаар Захирлуудын зөвлөлийн дарга буюу ОУВС-гийн Гүйцэтгэх захирал зөвлөлийн гишүүдийн байр суурийг тоймлон танилцуулдаг. Гүйцэтгэх захирлын энэхүү тойм танилцуулгыг гишүүн орны эрх баригчдад хүргүүлдэг. Тойм танилцуулгыг бэлтгэхэд тавьдаг шалгуурын тайлбарыг доорх хаягаар үзэж болно: <http://www.imf.org/external/np/sec/misc/qualifiers.htm>.

төлөвлөгөөг дэмжив. Монголбанкны болон Монгол улсын Хөгжлийн банкны төсвийн шинжтэй үйл ажиллагааг эцэс болгох, хууль дүрэмд суурилсан төсвийн тогтолцоо, санхүүгийн хараат бус зөвлөл байгуулах зэрэг үүрэг, амлалт авч байгааг Захирлууд сайшаан дэмжив. Мөн Захирлууд төрийн санхүүгийн удирдлага, татварын удирдлагыг бэхжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээг чангатгах төлөвлөгөөг талархан хүлээж авав. Мөн нийгмийн хамгааллын сүлжээг сайжруулах, тэтгэврийн тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн хамгийн эмзэг бүлгийг хамгаалах зорилгоор нийгмийн хамгааллын төсөл, хөтөлбөрүүдийг зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэв.

Захирлууд инфляци нам төвшинд хэвээр байгаа бөгөөд итгэх итгэл сэргэсэн нөхцөлд бодлогын хүүг өнөөгийн өндөр түвшингээс бууруулах орой зай гарч ирсэн ч гэсэн инфляцийн дарамтаас сэргийлэхийн тулд мөнгөний бодлого зохих ёсоор хатуу байх ёстой гэдгийг онцлон тэмдэглэв. Валютын ханш уян хатан байж зах зээлээр зарчмаар тодорхойлогдох шаардлагатай ба гадаад валютын интервенцийг хязгаартайгаар, зах зээл дээр тогтворгүй байдал үүсэхээс сэргийлэх зорилгоор зөвхөн хийнэ.

Тусгай аудит хийх, банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, түүнчлэн зохицуулалтын болон хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэх замаар банкны системийг бэхжүүлэх шаардлагатайг Захирлууд онцлон тэмдэглэсэн байна. Монголбанкны тухай шинэ хууль зэрэг төв банкны хараат бус байдал, засаглалыг бэхжүүлэх чиглэлийн арга хэмжээг Захирлууд талархан хүлээж авав. Мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэхэд дахин анхаарал хандуулж ажилласнаар гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг болно. Захирлууд, тогтвортой уул уурхай, эдийн засгийг төрөлжүүлэх, цаашид бүс нутгийн интеграцад анхаарал хандуулах замаар хүртээмжтэй өсөлтийг дэмжих хэрэгцээ шаардлага байгааг онцлон тэмдэглэв. Үүний зэрэгцээ бүтцийн шинэчлэл нь бизнесийн орчныг сайжруулах, нийлүүлэлтийн талын саад бэрхшээлийг арилгах, санхүүгийн хүртээмжийг гүнзгийрүүлэхэд чиглэгдэх ёстойг дурдлаа.

Хүснэгт 1. Монгол Улс: Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2013-2022

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
	урьдч тооц.									
Бодит салбар										
ДНБ оны үнээр (тэрбум төгрөг)	19,174	22,227	23,134	23,886	26,048	27,688	31,390	35,023	39,306	45,181
ДНБ-ий бодит өсөлт (өөрчлөлт хувиар)	11.6	7.9	2.4	1.0	-0.2	1.8	8.1	5.3	6.1	8.5
Эрдэс баялгийн ДНБ-ий бодит өсөлт	18.5	19.4	14.1	0.7	0.5	4.5	13.6	15.1	13.7	18.9
Эрдэс баялгийн бус ДНБ-ий бодит өсөлт	10.0	5.0	-1.0	1.1	-0.5	0.9	6.1	1.7	2.9	3.7
ДНБ-ий дефлятор (өөрчлөлт хувиар)	2.9	7.4	1.7	2.3	9.3	4.4	4.9	5.9	5.8	5.9
Хэрэглээний үнэ	11.2	10.7	1.1	0.5	6.1	6.1	6.9	6.5	6.5	6.5
(хугацааны эцэст; өөрчлөлт хувиар)										
Нийт үндэсний хуримтлал	26.3	23.4	21.1	26.5	30.3	30.1	32.4	36.4	38.2	41.4
Улсын	7.4	3.7	0.4	-4.6	-3.4	-1.5	1.3	3.7	5.5	6.1
Хувийн	18.9	19.7	20.7	31.1	33.8	31.6	31.2	32.7	32.7	35.3
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	51.7	34.9	25.1	30.6	34.8	39.6	46.1	46.9	46.6	47.6
Улсын	16.4	15.0	9.2	12.8	7.7	7.5	7.6	8.0	8.0	8.0
Хувийн	35.3	19.9	15.9	17.8	27.1	32.2	38.5	38.9	38.6	39.6
Засгийн газрын нэгдсэн данснууд										
Нийт орлого, буцалтгүй тусламж	31.2	27.8	25.1	23.7	24.7	26.3	26.8	27.0	27.1	27.2
Нийт зарлага, цэвэр зээл 1/	40.1	39.1	33.6	40.7	35.3	34.8	32.7	31.0	29.1	28.7
Нийт тэнцэл (ОУВС-гийн тодорхойлолтоор) 2/	-8.9	-11.3	-8.5	-17.0	-10.6	-8.5	-5.9	-4.0	-2.0	-1.5
Үндсэн тэнцэл (ОУВС-гийн тодорхойлолтоор)	-7.5	-8.8	-5.6	-13.1	-5.5	-3.1	-1.0	0.3	1.5	1.6
Мөнгөний салбар										
Зээлийн өсөлт (өөрчлөлт хувиар)	57.9	23.5	0.5	8.5	9.0	10.3	10.6	11.1	11.9	15.6
Нөөц мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	54.0	2.7	-28.2	24.6	21.8	19.3	16.0	15.3	15.1	16.1
Урсгал дансны тэнцэл	-25.4	-11.5	-4.0	-4.1	-4.4	-9.5	-13.6	-10.6	-8.4	-6.2
Гадаад валютын нийт нөөц (сая ам. доллар) 3/	2,242	1,648	1,324	1,297	1,692	2,515	3,583	4,032	4,257	4,304
(импортын сараар)	3.9	4.0	2.9	2.9	3.4	4.4	6.1	6.5	6.8	7.2
Өрийн үзүүлэлтүүд 4/										
Засгийн газрын өр	46.0	57.1	59.5	87.6	94.9	101.3	100.0	97.5	92.3	84.7
Дотоод	13.5	14.7	14.6	19.8	21.4	19.4	15.1	11.7	12.9	11.6
Гадаад	32.5	42.3	44.9	67.8	73.4	81.9	84.9	85.7	79.5	73.1
Засгийн газрын өр, өнөөгийн үнэ цэнээр	55.0	69.1	86.3	89.6	86.5	84.0	79.6	74.3
Нийт санхүүжилтийн хэрэгцээ	9.8	13.3	10.7	18.1	22.4	21.5	18.5	13.8	13.9	17.5
Суурь үзүүлэлтүүд:										
Зэсийн үнэ (ам. доллар, нэг тонн)	7331	6,863	5,510	4,868	5,722	5,733	5,721	5,708	5,704	5,704
Алтны үнэ (ам. доллар, нэг унци)	1411	1,266	1,160	1,248	1,212	1,225	1,251	1,274	1,299	1,325

Эх сурвалж: Монголын эрх баригчид; ОУВС-гийн мэргэжилтнүүдийн төсөөлөл.

1/ Хөгжлийн банкны зээл санхүүжилтийг оруулсан.

2/ Өмч хувьчлалын орлого ороогүй; Хөгжлийн банкны арилжааны зээл, 2017 оноос хойш ипотекийн зээлийн хүүгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн

3/ Валютын нийт нөөцөд своп шугамын хүрээнд авсан эх үүсвэрийг оруулсан.

4/ Засгийн газрын өрийн мэдээнд ТӨААН-үүдийн өр болон төв банкны Хятадын Ардын Банктай байгуулсан своп шугамын хүрээнд хүлээсэн үүргийг оруулаагүй.



МОНГОЛ УЛС

**ОУВС-ГИЙН ДҮРМИЙН IV ЗААЛТЫН 2017 ОНЫ ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ,
ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ХҮСЭЛТИЙН ТАЛААРХ
АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН**

ҮНДСЭН АСУУДАЛ

Нөхцөл байдал. Монгол Улс байгалийн асар их баялагтай учраас урт хугацааны хэтийн төлөв нь гэрэл гэгээтэй харагдаж байна. Гэсэн хэдий ч, сүүлийн жилүүдэд гадаад шок, төсөв, мөнгөний тэлэх бодлого бүтцийн доголдолд нэрмээс болсны уршгаар эдийн засаг томоохон сорилт, бэрхшээлтэй тулгарч байна. 2016 онд шинээр эмхлэн зохион байгуулагдсан Засгийн газар макро эдийн засгийн бодлогыг чангатгах, эдийн засгийг тогтворжуулах, цаашид тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн үндэс суурийг тавих үүднээс бүтцийн шинэчлэл хэрэгжүүлэхээ тууштай илэрхийлж байна.

Сүүлийн үед гарсан өөрчлөлт, цаашидын төлөв. Өнгөрсөн онд төсвийн бодлогыг үлэмж сулруулснаар төсвийн алдагдал ДНБ-ий 17 хувьд хүрч өслөө. Гэсэн хэдий ч, эдийн засаг тамирдсан хэвээр үлдэж, эдийн засгийн өсөлт дөнгөж 1 хувьтай гарч, инфляци түүхэн доод түвшин буюу 1 хувиас доош орсон байна. Эдийн засгийн идэвхи сул байсан нь импортыг бууруулсан ч, төлбөрийн тэнцлийн дарамт арилаагүй үлдлээ. Банкуудын хувьд активын чанар муудах зэрэг хэд хэдэн сорилттой тулгарч байна. Цаашид зарим томоохон уул уурхайн бүтээн байгуулалт хийгдсэнээр эдийн засгийн өсөлт сэргэж, хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бодлогын тохиргоо, санхүүжилт өрийн тогтвортой байдлыг сэргээн гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх ёстой.

Дүрмийн IV заалтын зөвлөлдөх хэлэлцүүлэг. Экспортын бүтцээс хамааран Монгол улс гэнэтийн гадаад шокт их эмзэг, өртөмтгий байгаа бөгөөд өнгөрсөн жилүүдэд үүсч байсан өндөр өсөлт, огцом уналтын мөчлөгөөс зайлсхийх явдал бол гол үндсэн сорилт мөн. Иймд төсөв, санхүүгийн тогтолцоо, бодлогын сахилга батыг бэхжүүлэх, мөн эдийн засгийг солонгоруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс бүтцийн шинэчлэлийн хамт нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулан илүү зорилтот бүлэгт чиглүүлэх хүчин чармайлт гаргах зэрэг асуудалд хэлэлцүүлгийн үеэр анхаарлаа хандуулсан байна.

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр. Эрх баригчдын хөтөлбөрийг дэмжих зорилгоор Монгол улсын квотын 435 хувьтай тэнцэх хэмжээний (314,5054 сая ЗТЭ буюу 425 сая орчим ам.доллар) 3 жилийн хугацаатай, нийтдээ 5.5 тэрбум ам.долларын хандивлагчдын дэмжлэгийг санал болгож байна.

Санал болгож буй хөтөлбөр нь Дүрмийн VI заалтын зөвлөлдөх хэлэлцүүлгээр авч хэлэлцсэн үндсэн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэж байгаа юм. Бодлогын гол тулгуурууд нь дараах асуудлуудыг хамарч байна. Үүнд: төсвийн сахилга батыг бэхжүүлэх үүднээс томоохон

шинэчлэлд тулгуурласан төсвийн бодлогын дорвитой тохируулга; мөнгөний зохистой бодлого, төв банкны хараат бус байдал, засаглалыг бэхжүүлэх Төв банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга; валютын ханшны уян хатан систем, активын чанарын хараат бус үнэлгээгээр эхлэх банкны салбарыг бэхжүүлэх цогц стратеги; болон хүн амын эмзэг давхаргыг хамгаалах, эдийн засгийг солонгоруулах зэрэг арга хэмжээнүүд юм.

Баталсан
Маркус Родлауер (Ази, Номхон далайн газар), Дарья Захарова (Стратеги, бодлого хяналтын газар)

Хэлэлцүүлгийг 2016 оны 10 дугаар сарын 24–ны өдрөөс 11 дүгээр сарын 5-ны хооронд хийсэн болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Коши Матай (ахлагч), Нейл Сакер (суурин төлөөлөгч), Озгур Демиркол, Манук Газанчян, Руй Мано (Ази, Номхон далайн газар), Кэйко Уцуномия (Олон нийттэй харилцах хэлтэс), Баопинг Шанг (Төсвийн удирдлагын газар), Лацло Батт, Пьерпаоло Гриппа, Питер Лохмус, Гилхэрмэ Пэдрас (Мөнгө, хөрөнгийн зах зээлийн газар), Итай Агур, Прагиан Дэб болон И Сионг (Стратеги, бодлого, хяналтын газар) нар багтсан болно. Ажлын хэсэгт суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч С. Сэлэнгэ, Б. Ардак, Б. Хулан нар туслалцаа үзүүлсэн бөгөөд Ази, Номхон далайн газрын ноён Пароуцоглоу, хатагтай Толентино, ноён Х.Чой, К.Чой, Парк, Х. Ганцогт нар, мөн Ази, Номхон далайн газрын н.Родлауер уулзалт хэлэлцүүлэгт оролцсон болно. ОУВС-гийн ажлын хэсэг УИХ-ын дарга М.Энхболд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан болон бусад өндөр албан тушаалтантай уулзалт хийсэн болно.

ГАРЧИГ

НӨХЦӨЛ БАЙДАЛ	4
СҮҮЛИЙН ҮЕД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД, ЦААШДЫН ТӨЛӨВ	5
ДҮРМИЙН IV ЗААЛТЫН ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	7
ХӨТӨЛБӨР	16
А. Стратеги	16
Б. Төсвийн бодлого	18
В. Мөнгөний болон валютын ханшийн бодлого	20
Г. Санхүүгийн салбарын бодлого	21
Д. Нийгмийн хамгаалал, өрсөлдөх чадвар, эдийн засгийн төрөлжилт	23
Е. Хөтөлбөрийн санхүүжилт, хэлбэрүүд, эрсдэлүүд	24
АЖЛЫН ХЭСГИЙН ҮНЭЛГЭЭ	27
ШИГТГЭЭ	
1. Монгол Улсын эрдэс баялаг	9
2. ОУВС-гийн бодлогын зөвлөмжүүдийн хэрэгжилт	12
3. Гадаад сектор, валютын ханшийн үнэлгээ	14

ГРАФИК

1. Монгол улсын эрдэс баялгийн орд газруудын тогтоодсон нөөц	11
2. Бодит секторт гарсан өөрчлөлт хөгжил	29
3. Төсөв, мөнгөний секторт гарсан өөрчлөлт хөгжил	30
4. Гадаад секторт гарсан өөрчлөлт хөгжил	31

ХҮСНЭГТ

1. Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2013–2022	32
2а. Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд, 2014–2022 (Тэрбум төгрөгөөр)	32
2б. Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд, 2014–2022 (ДНБ-д эзлэх хувийн жингээр)	34
3. Төлбөрийн тэнцэл, 2013–2022	35
4. Мөнгөний секторын үзүүлэлтүүд, 2013–2022	36
5. Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн нэгтгэл	37
6. Гадаад санхүүжилтийн хэрэгцээ, эх үүсвэр, 2015–2022	38
7. Эргүүлэн төлөх чадварын үзүүлэлт, 2017–2022	39
8. ОУВС-гаас авсан зээлийн үзүүлэлтүүд, 2017–2022	40
9. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт олгох товлал	41
10. Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлт	42

ХАВСРАЛТУУД

I. Дэлхийн хэмжээний эрсдэлийн үнэлгээний матриц	44
II. Өрийн тогтвортой байдлын шинжилгээ	46

ДАГАЛДАХ МАТЕРИАЛ

I. Хөтөлбөр хэрэгжүүлэх албан хүсэлтийн захидал	51
Хавсралт I. Эдийн засаг, санхүүгийн бодлогын санамж бичиг	53
Хавсралт II. Техникийн санамж бичиг	70

НӨХЦӨЛ БАЙДАЛ

- 1. Монгол улсын ирээдүй гэгээтэй хэдий ч эдийн засгийн хүндхэн сорилттой тулгараад байна.** Монгол улс зэс, алт, нүүрс, бусад эрдэс баялгийн томоохон ордуудтай бөгөөд тэдгээрийн ихэнхийг ашиглаж эхлэх бүтээн байгуулалт эсвэл олборлолт явагдаж байгаа юм. Хөдөө аж ахуй, нэн ялангуяа сүү, мах, ноолуур болон аялал жуулчлалын салбаруудыг хөгжүүлснээр эдийн засгаа төрөлжүүлж солонгоруулах нөөц бололцоо байна. Эцэст нь, тус бүс нутгийн улс орнууд илүү нягт интеграцид ороход Монгол Улс стратегийн байршлаа ашиглан эдийн засгийн үр өгөөж авах боломжтой юм. Энэ утгаараа эдийн засгийн цаашдын төлөв таатай харагдаж байна. Харин өнөөгийн байдлаар бол эдийн засгийн өсөлт удааширч, гадаад валютын нөөц хомсдон төсвийн алдагдал нэмэгдсэн, өрийн хэмжээ өссөн, мөн банкны систем эмзэг болсон дүр зураг харагдаж байна.
- 2. Эмзэг эдийн засагт гадаад шок хүндхэн тусч байна.** Экспортын орлогын 90 хүртэл хувийг эрдэс баялаг эзэлж байгаагаас 2011 оноос хойш түүхий эдийн үнэ огцом унаж, төлбөрийн тэнцэл болон төсөв, санхүүг хүндхэн байдалд оруулав. Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширсан, Хятадын эдийн засгийн дахин тэнцвэржилт, экспортын орлого бууралт ч мөн нөлөөлсөн билээ. Үүний зэрэгцээ, Оюу толгойн зэс, алтны уурхайн бүтээн байгуулалтын эхний үе шат дуусч, хувь нийлүүлэгчдийн маргаанаас шалтгаалан хоёр дахь үе шат нь хойшилсноор гадаадын шууд хөрөнгө оруулалт 2015 онд бараг үгүй болов.
- 3. Тэлэх бодлого гадаад шокт нэрмээс болов.** Гадаад шокоос эдийн засгаа хамгаалах зорилгоор макро эдийн засгийн бодлогоо сулруулсан нь нэг хэсэгтээ өсөлтийг дэмжсэн боловч улсын өрийг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцлийг сулруулан банкуудын активын чанарыг доройтуулсан байна. Төсөвт тусгагдсан алдагдал 2016 оныг хүртэл ерөнхийдөө хяналтанд байсан боловч 2012 оноос хойш Хөгжлийн банк болон Монголбанкаар дамжуулан дэд бүтцийн төслүүд болон хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдэд ихээхэн хэмжээний нэмэлт санхүүжилтийг төсвөөс гадуур гаргасан байна. Ингэснээр төсвийн ерөнхий төлөв тэлэх шинжтэй байсан бөгөөд зах зээлийн тааламжтай нөхцөлд хуримтлуулсан /хэдий тоо хэмжээний хувьд хангалтгүй ч/ нөөцөө Монгол улс шавхаж дууссан байна. Мөнгөний тэлэх бодлого зээлийн хэт өсөлтийг бий болгож, импортыг дэмжсэн нь валютын нөөц үлэмж хэмжээгээр хорогдоход хүргэж, төгрөгийн ханшийг огцом унагаж, үнийн өсөлтийг нөхцөлдүүлэв. Санхүүгийн салбарын хяналт зохицуулалт бүх түвшинд суларч, ингэснээр банкны хүндрэл газар авахад нөлөөлсөн байна.
- 4. Ийм нөхцөлд тухайн үеийн сөрөг хүчин Монголын Ардын Нам (МАН) 2016 оны 6 дугаар сарын УИХ-ын сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулав.** УИХ дахь 76 суудлаас МАН 65 суудал авч, эвслийн засгийн газрын урт удаан үеийг дуусгавар болгов. Сангийн шинэ сайд, Монголбанкны шинэ ерөнхийлөгчийн хамт 7 дугаар сарын сүүлээр томилогдов. Эрх баригчид Монгол улсын эдийн засгийн хүндрэлийг нээлттэй хүлээн зөвшөөрч, өмнө хэрэгжүүлж байсан бодлогыг үндсээр нь өөрчилсөн “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” боловсруулж, ОУВС-гаас тусламж хүссэн юм.

СҮҮЛИЙН ҮЕД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ ХӨГЖИЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ

5. Эдийн засгийн идэвх сул байв. Эдийн засгийн өсөлт 2014 онд бараг 8 хувь байсан бол 2016 онд 1 хувь болж буурлаа. Оюу толгойн эхний үе шатны бүтээгдэхүүний олборлолт удааширсан цаг зуурын геологийн хүчин зүйлээс шалтгаалан уул уурхайн өсөлт 2016 онд бараг бүхэлдээ харьцангуй сул байсан боловч 4 дүгээр улиралд Хятадын нүүрсний нийлүүлэлт тасарч, Хятад улс бодлогын хувьд нүүрс олборлохоос татгалзсан зэргээс хамааран нүүрсний үйлдвэрлэл, үнэд нэлээд хэмжээний өсөлт гарсан байна. 2016 оны 2 дугаар хагаст Оюу толгойн 2 дахь шатны бүтээн байгуулалт (ОТ-2) идэвхжиж, төсвийн зарлага санхүүжилт огцом өссөнөөр уул уурхайн бус өсөлт нэмэгдсэн байна. Гэсэн хэдий ч, хувийн хэрэглээ суларсан учраас эдийн засгийн нийт өсөлтөд дорвитой нөлөө үзүүлж чадсангүй. Эдийн засгийн өсөлт сул байснаас инфляци 2015 онд огцом буурч, жилийн хоёрдугаар хагаст төгрөгийн ханш ихээхэн суларсан боловч, 2016 онд инфляци түүхэн доод түвшинд очиж буурсан юм.

6. Төсвийн нөхцөл байдал 2016 онд ихээхэн муудлаа. ОУВС-гийн тодорхойлолтоор төсвийн алдагдал ДНБ-ний 17% буюу 2015 оны түвшингөөс хоёр дахин нэмэгдэж, түүхэн дээд хэмжээнд хүрсэн байна. Үүнд орлого огцом буурч, зээлийн хүүгийн төлбөр нэмэгдсэн, сонгуулийн өмнөх зардлын хөтөлбөрүүд, дэд бүтцийн санхүүжилтийн зарим өр авлагыг барагдуулсан болон шүүхийн шийдвэрээр уул уурхайн компанид төлбөр гүйцэтгэсэн зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна. Төсвийн их хэмжээний алдагдал, төгрөгийн ханш суларсан зэргээс шалтгаалан улсын өрийн ДНБ-нд эзлэх хувийн жин (ОУВС-гийн тодорхойлолт болон өнөөгийн өртгөөр тооцвол) 2015 онд 55% байснаа жилийн дараа бараг 70%-д хүрсэн байна.

7. Төлбөрийн тэнцэл хүндрэв.

Түүхий эдийн үнэ хүлээгдэж байснаас илүү гарсан, мөн жилийн эцсээр нүүрсний экспорт огцом нэмэгдсэний үр дүнд экспорт сэргэсэн билээ. Нөгөө талаар эдийн засгийн байдал сул байгааг илтгэн импортын хэмжээ бага байснаас шалтгаалан худалдааны тэнцэл ашигтай гарлаа. Хэдий тийм ч, нийт урсгал дансны тэнцэл ДНБ-ний 4 орчим хувь гарч байна. Эдийн засгийн нөхцөл байдал, бондын хүлээгдэж буй төлбөр, 6

Төсвийн дансд, 2015-26 (ДНБ-д эзлэх хувиар)

	2011-2015 дундаж	2015	2016
Орлого	29.6	25.1	23.7
Зарлага	37.9	33.6	40.7
Урсгал	24.7	24.4	27.9
Хөрөнгийн	13.3	9.2	12.8
Нийт тэнцэл	-8.4	-8.5	-17
Улсын өр			
Нэрлэсэн үнээр	...	59.5	87.6
Өнөөгийн үнэ цэнэ	...	55	69.1
<i>Меморандум үзүүлэлтүүд:</i>			
Анхдагч зардал	36.4	30.7	36.8
Сонгуулийн өмнөх хөтөлбөр	2.3
Шүүхийн шийдвэр	0.6
өр төлбөр барагдуулсан	1.2
Суурь анхдагч зардал	36.4	30.7	32.7
Анхдагч тэнцэл /АТ/	-6.8	-5.6	-13.1
АТ, нэг удаагийн зарлыг хассан	-6.8	-5.6	-9
АТ, нэг удаагийн зардал болон 2011-15 оны орлогын дутагдлыг хассан	-6.8	-1.2	-3.1
АТ, мөчлөгийн тохиргоотой - Cyclically adjusted primary balance /САРВ/	-7.6	-6.5	-12.8
САРВ нэг удаагийн зардлыг хассан	-7.6	-6.5	-8.7
Эрдсийн бус анхдагч тэнцэл	-12.2	-10	-15.6

дугаар сард хийгдсэн нэг удаагийн их хэмжээний валютын гүйлгээ¹ зэргийн тухайд зах зээлийн тодорхойгүй байдлаас шалтгаалан төгрөгийн ханш нэлээд сулран 2016 оны сүүлийн хагаст 25%-иас их хэмжээгээр унав. Нийт валютын нөөц харьцангуй тогтвортой 1,3 тэрбум ам.доллар буюу 3 сарын импорттой тэнцэх хэмжээнд байсан нь 500 сая ам.долларын өндөр өгөөж бүхий Засгийн газрын бондыг олон улсын зах дээр гаргасан, 250 сая ам.долларын олон улсын синдикат зээл авсан, мөн БНХАУ-ын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн шугамыг ашиглаж байгаатай холбоотой юм. Монгол улсын зээлжих зэрэглэлийг жилийн эцсээр хоёр ч удаа бууруулсан байна (Мүүдиз Саа1 зэрэглэлд шилжүүлэв).

8. Мөнгөний захын нөхцөл байдал дарамтад байв. Зээлийн өсөлт буурсан бөгөөд энэ өсөлтийг голлон хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд хангасан байна. Инфляци маш бага, нам түвшинд байгаа боловч тухайлбал төсвийн дарамт, эрсдэлтэй орчин зэргийн тусгал болон зээлийн жигнэсэн дундаж хүү 20 орчим хувьтай байна. Төгрөгийн ханшийг дэмжих зорилгоор 2016 оны 8 дугаар сард Монголбанк бодлогын хүүгээ 4,5 нэгж хувиар нэмэгдүүлсэн боловч эдийн засгийн үйл ажиллагаа сул, инфляци нам түвшинд байгаатай уялдуулан 12 дугаар сард 1 нэгж хувиар бууруулж 14 хувь болгосон байна. Түүнчлэн, 2016 оны 2 дугаар хагас жилд Монголбанк засгийн газарт зээл олгохоо зогсоож, орон сууцны ипотекийн зээлийн шинэ санхүүжилтийг одоо байгаа зээлийн багцын үндсэн төлбөрийн эргэн төлөлт, хүүгийн төлбөрийн дүнгийн хэмжээнд хязгаарлав.

9. Банкны сектор хүнд сорилттой тулгарлаа. Банкны салбар харьцангуй жижиг: нийт актив нь ДНБ-ний 90% бөгөөд зээл нь ДНБ-ний дөнгөж 50 хувьтай тэнцэнэ. Эдийн засгийн байдал сул, төгрөгийн ханшны уналт зэргээс хамааран активын чанар муудаж, чанаргүй зээлийн харьцаа 7% (хугацаа сунгасан болон хугацаа хэтэрсэн зээлийг оруулаагүй) болсон гэж мэдээлж байна. Энэ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаанд нөлөөлж байна. Ханшны эрсдэлээс хамгаалаагүй зээлдэгчдэд төгрөгийн ханшны уналтын нөлөө болон уул уурхайн салбарын үйл ажиллагаа сул байгаагийн тусгал болон гадаад валютын зээлийн хувьд чанаргүй зээлийн хэмжээ илүү их байна. Эрх бүхий байгууллагаас зохих арга хэмжээг авахгүй хэвээр байгаа нь банкны салбар дахь эмзэг байдал нуун дарагдуулсаар байна. Монголбанк хяналт шалгалтын илүү эрсдэлд суурилсан арга барилд удаан боловч шилжиж байгаа бөгөөд чадавхаа сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

10. Эрх баригчид бодлогын сахилга батаа хангаж чадвал Монгол улсын дунд хугацааны төлөв таатай харагдаж байна. Сүүлийн хэдэн жилд явуулсан бодлогыг цаашид хэрэгжүүлбэл эдийн засгийн зогсонги байдал үргэлжилж, өр тогтворгүй байдлаар хуримтлагдан, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдсээр, банкны хүндрэл улам даамжрах байсан. Харин ОУВС-гийн дэмжлэгтэй хөтөлбөрт хамрагдан шинэ эрх баригчдын дэвшүүлж буй бодлогыг хэрэгжүүлснээр хэтийн төлөв илүү нааштай болно гэж үзэж байна. Тухайлбал:

- Төсвийн алдагдлыг бууруулснаар² эдийн засгийн өсөлт 2017 онд бага зэрэг сөрөг гарах

¹ Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн ОХУ-ын эзэмшлийн хувийг дотоодын компани худалдан авахад хэдэн зуун сая ам.доллар шаардлагатай болсноор төгрөгийн ханшинд дарамт үзүүлэв.

² Төсвийн алдагдлыг ихээхэн хэмжээгээр бууруулсан ч хурц агшилт болохгүй гэсэн төсөөлөлтэй байгааг хэд хэдэн хүчин зүйлээр тайлбарлаж болно. Хамгийн чухал нь, төсвийн нэгдмэл байдлыг хангахгүй бол Оюу толгойн 2 дахь үе шатны бүтээн байгуулалтын барилга, аж үйлвэрын салбарт үзүүлэх эерэг нөлөөлөл, түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд хийгдэх

төлөвтэй байгаа боловч 2018 онд сэргэж, харин 2019 онд Таван толгойн нүүрсний уурхайн бүтээн байгуулалт/нөхөн сэргээлт эхэлснээр 8 хувьд хүрнэ гэж тооцож байна. Үүний зэрэгцээ, Оюу толгойн хоёр дахь үе шатны бүтээн байгуулалттай холбоотой гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал ирэх хэдэн жилийн хугацаанд жилд 1 тэрбум орчим ам.доллар байх болно. Уул уурхайн эдгээр томоохон хөрөнгө оруулалтын нөлөөлөл хийгээд өсөн нэмэгдэж буй хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дунд хугацаанд уул уурхайн бус өсөлтийг дэмжих төлөвтэй байна.

- Валютын ханшны 2016 оны уналтын жил дамнасан нөлөөлөл, мөн хөтөлбөрийн дагуу онцгой албан татвар өссөний тусгал болж инфляци 2017 оны эцсээр эргээд 6 хувь болох бөгөөд эдийн засаг хэвийн гольдролдоо эргэн ороход 6½ хувь орчимд тогтворжино гэж тооцож байна.
- Төлөвлөж байгаагаар төсвийн алдагдлыг бууруулж, томоохон хэмжээний хөнгөлөлттэй гадаад санхүүжилт авсны үр дүнд засгийн газрын өрийн хэмжээ 2019 оноос эхлэн буурч, өрийн тогтвортой байдал сэргэж, гадаад валютын нөөц 2020 он гэхэд 4 тэрбум ам.доллар буюу 6½ сарын импорттой тэнцэх хэмжээнд хүрч эрүүлжинэ³.

Эрх баригчдын байр суурь

11. Эрх баригчид бодлогын чиглэлийг өөрчлөх зайлшгүй шаардлага байгааг хүлээн зөвшөөрч, цаашдын төлөвийн хувьд ч ижил байр суурьтай байна. Тэд өмнөх Засгийн газрын эдийн засгийн олон бодлогыг эсэргүүцэж байсан бөгөөд ийм өөрчлөлт хийх сонгуулийн мөрийн хөтөлбөртэй засгийн эрхэнд гарч ирсэн болохоо онцлон тэмдэглэв. Эрх баригчид ОУВС-гийн мэргэжилтнүүдийн эдийн засгийн хэтийн тооцоотой санал нийлсэн боловч өсөлтөд хүчтэй зэрэг нөлөө үзүүлэх хүчин зүйлс байгааг, тухайлбал, Таван толгой Засгийн газрын хувьд өндөр ач холбогдолтой байгаа учраас түүний бүтээн байгуулалт 2019 оноос өмнө эхэлнэ гэсэн хүлээлттэй байгаа тэмдэглэв.

ДҮРМИЙН IV ЗААЛТЫН ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

12. Монгол улсад хэд хэдэн ноцтой эрсдэл тулгараад байна. Дэлхийн түүхий эдийн зах зээлийн эрсдэлд хэт өртөмтгий байна. Цаашилбал, бүс нутгийн хэмжээний эрсдэл ч байна. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашрах эсвэл нүүрс шатаах замаар гаргаж авдаг эрчим хүчнээс татгалзах бол Монголын түүхий эдийн эрэлт буурна гэсэн үг юм. Гэсэн хэдий ч, эдгээр нөлөөллийг тэнцвэржүүлэх хүчин зүйлс байж болох юм. Тухайлбал, Хятад улс байгаль орчны шалтгаанаар нүүрсний уурхайнуудаа хаах замаар өөрийн нүүрсний нийлүүлэлтээ бууруулах үйл явц үргэлжилсээр байх хэмжээнд цаашилбал Хятадын өрхийн орлого, хэрэглээ өсөн нэмэгдсэнээр Монгол улсын аялал жуулчлал, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах болон ноолуурын эрэлтийг дэмжиж болох юм. (Эдийн засагт тулгарч буй дэлхийн хэмжээний болон дотоод эрсдэлүүдийг Хавсралт I-д дэлгэрэнгүй авч үзнэ.)

бодлогын тохиргоо, орж ирэх санхүүжилтийн тусгал болон итгэл ерөнхийдөө сэргэсэнээр өсөлт нэлээд дорвитой нэмэгдэх байсан. Үүний зэрэгцээ, алдагдал бууруулах нь шүүхийн шийдвэрээр гадаадын аж ахуйн нэгжид төлбөр барагдуулах зэрэг эдийн засгийг боймилж байсан зарим нэг удаагийн зүйлээс ангижирсны ямар нэгэн байдлаар тусгал болж байгаа учраас энэхүү хумих түрлэгийг илүү илэрхийлж байгаа юм.

³ Нөөцийг энэ хэмжээнд хүргэсэнээр шаардлагатай бол Хятадын Ардын банкны своп хэлцлийн шугамын өрийг төлөөд цаана нь Монгол улс нөөцийн зохистой түвшинд үлдэх хэмжээний хангалттай юм.

13. Монгол улсын эдийн засгийн суурь асуудал бол төрөлжилт дутмаг, тэлэлт-

агшилтын мөчлөгт өртөх хандлагатай байдал мөн. Эдийн засгийг төрөлжүүлж, солонгоруулна гэж эртнээс зорьж ирсэн. Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт ихээхэн боломж бий. Гэхдээ байгалиас өгөгдсөн ашигт малтмалын баялаг нөөцдөө тулгуурлан Монгол улс олон арван жилийн турш уул уурхайн эдийн засагтай хэвээр байх болно. (Шигтгээ 1-ээс Монгол улсын эрдэс баялгийн талаарх тайлбарыг үзнэ үү.) Түүхий эдийн экспортлогч бусад олон орны нэгэн адил, үнэ өндөр байгаа сайн цагт хэт зарцуулах хандлагатай, үнэ буурсан муу цаг ирэхэд хангалттай хуримтлал үүсгэж чадаагүйгээс зардлаа эрс бууруулах болж, шаардлагатай бэлтгэл, хамгаалалт хангалтгүй байдаг. Монгол улс төсвийн тогтолцоо нь мөчлөгөөс хамаарсан энэхүү байдлыг урьдчилан сэргийлэх зорилготой боловч үүнийгээ сүүлийн жилүүдэд үндсэндээ умартсан байна. Одоо яг юу хэрэгтэй байна вэ гэвэл улс орны нөөц бололцоог бодит зүйл болгох стратеги хэрэгтэй байна. Үүнд: шинэчлэлийг зөв шат дараалал, тэргүүлэх чиглэлээр хийх, төсвийн эрүүл тогтолцоо чухал ач холбогдолтой, мөн бодлого санаачлагаа тууштай хэрэгжүүлэх бодлогын тогтвортой байдал чухал байна. Эдгээр асуудлын ихэнхийг ОУВС-гийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн сүүлийн (2009 онд авсан Стэндбай) хөтөлбөр, Дүрмийн IV заалтын хүрээнд сүүлийн үед хийгдсэн зөвлөлдөх хэлэлцүүлэг (Шигтгээ 2-ыг үзнэ үү)-ээр авч үзэж байсан. Хамгийн сүүлд хэрэгжсэн хөтөлбөр нь ерөнхийдөө эдийн засгийг тогтворжуулж чадсан боловч хөтөлбөрийн хүрээнд хийсэн шинэчлэлийн цаашдын тогтвортой хэрэгжилтийг хангах тал дээр үр дүн тааруу байлаа.⁴

⁴“Монгол улс: 2009 оны Стэнд-бай хөтөлбөрийн хэрэгжилтийн дараах үнэлгээ,” 2011 оны 3 дугаар сар, ОУВС-гийн гишүүн улсын тайлан 11/77-г харна уу.

Шигтгээ 1. Монгол улсын эрдэс баялаг

Монгол улс эрдэс баялгийн арвин их нөөцтэй бөгөөд үүнийгээ амжилттай ашиглаж чадвал дунд болон урт хугацааны туршид тогтвортой, хурдацтай өсөлтийг хангах хэтийн төлөв байна.

- Монгол Улс нь олон гол нэрийн түүхий эдийн асар их нөөцтэй (газрын зургийг үзнэ үү) бөгөөд дэлхийн хэмжээнд хамгийн бага зардалтай олборлогчдын нэг юм. Энд дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайн нэг Оюу Толгой (үйлдвэрлэлийн эхний үе шат нь аль хэдийн эхэлсэн бөгөөд хоёр дахь үе шат нь 2018 онд үйлдвэрлэлээ эхлэх болно), мөн нүүрсний хамгийн том ордуудын нэг Таван Толгой (дахин бүтээн байгуулалт нь 2019 онд эхлэх төлөвтэй байна) байна. Дүгнээд хэлэхэд, одоогоор батлагдсан нөөцийг ойролцоогоор 1 их наяд ам.долларын үнэлгээтэй гэж тооцсон бөгөөд бодит үнэ цэнэ үүнээс хавьгүй илүү гарч болох юм. Бас нутаг дэвсгэрийн ихэнх хэсэгт эрэл хайгуулын судалгаа хийгдээгүй байгаа юм. Энэ боломжийг ашиглах түлхүүр хөшүүрэг бол дэд бүтцийг хөгжүүлж, зах зээлд ээлтэй хөрөнгө оруулалтын орчин бүрдүүлэх явдал юм. Өнөөгийн байдлаар хэдий ийм хязгаарлалт байгаа боловч, Засгийн газар шинэ төмөр зам, цахилгаан станц зэрэг мега-төслүүдийг хурдасгах хэд хэдэн арга хэмжээг зарласан бөгөөд эдгээр нь дэлхийн тодорхой бүс нөхцөлд ч, ирэх жилүүдэд түүхий эдийн салбарыг чиглүүлэхэд дэмжлэг болох ёстой. Үр дүнд нь, ДНБ-ий өсөлт хурдсан, экспорт хоёроос илүү дахин өсөх юм.
- Хятад дахь гол зах зээлтэйгээ илүү холбогдвол ялангуяа далайн эргээс алслагдсан нутагт БНХАУ-ын эдийн засгийн орон зайн дахин тэнцвэржүүлэлтийн үр шимийг Монгол улс хүртэх боломж гарч ирэх ач холбогдолтой юм. Монголын чулуун нүүрс болон бусад эрчим хүчний үйлдвэрлэл Хятадын баруун мужуудын өсөлтөд түлхэц болж болох юм. Учир нь энэ бүс нутагт Австралийн хямд нүүрс зэрэг далайн тээврээр ирдэг бусад импортын өрсөлдөөн бага байх юм. Үүний зэрэгцээ, Монгол улс органик хүнсний бүтээгдэхүүн, элит аялал жуулчлал зэрэг өндөр орлогод мэдрэмж бүхий бараа, ажил, үйлчилгээний салбаруудаар өрсөлдөх давуу талтай юм. Ингэснээр БНХАУ-ын өсөн нэмэгдэж буй хэрэглээнээс ашиг хүртэж болох юм.

Зэс

- Оюу Толгой бол дэлхийн шилдэг зэсийн уурхайн нэг юм. Уурхайг ашиглагч группын толгой Рио Тинто компани хамгийн шилдэг технологи ашиглаж байгаа бөгөөд олборлолт 100 хүртэл жилийн турш үргэлжлэн гэсэн тооцоотой байгаа. Одоогийн Оюу Толгой уурхай нь хуучин галт уулын хяраар агуулагдах боломжит зэсийн ордын зөвхөн нэг хэсгийг хамарч байгааг судалгаа харуулж байна. Хүдэр агуулсан байх боломжит нутаг дэвсгэрийн үлдсэн хэсэгт эрэл хайгуулын судалгаа хийх бөгөөд зарим ажиглагчдын үзэж байгаагаар зөвхөн энэ чиглэлд арван Оюу толгой байж болох юм. Үүний зэрэгцээ 40 орчим жилийн турш үйлдвэрлэл явуулж ирсэн Эрдэнэтийн уурхай нэмэлт хөрөнгө оруулалт хийж, менежментээ сайжруулснаар үр ашгаа мэдэгдэм дээшлүүлэх боломжтой юм.
- Зэсийн үнэ 2020-иод онд дараах хоёр хүчин зүйлээс шалтгаалан өсөх учраас анхаарвал зохих эрдэс мөн. Үүнд: (i) Латин Америкийн нийлүүлэлтийн асуудал; ба (ii) цахилгаан хөдөлгүүртэй машины хэрэглээ нэмэгдэж, Азийн тухайлбал, Мянмар, Энэтхэг зэрэг улсад цахилгаан үйлдвэрлэл, түгээлт үргэлжилсээр байгаа гэх мэт хүчин зүйлийн улмаас эрэлт өсөх юм.

Нүүрс

- Монгол улс дэлхийн хамгийн том нүүрсний ордуудтай. Хятадын гангийн зах зээлд ашиглах өндөр агуулгатай коксжих нүүрс хийгээд дотоодын болон экспортын эрчим хүчний нүүрсний аль аль нь байна. Таван Толгойн (ТТ) бол дэлхийн мэдэгдэж байгаа хамгийн том ганц орд (7½ орчим тэрбум тонн гэж тооцоолсон)-ын нэг бөгөөд жижиг хувийн хэвшлийн хэд хэдэн уурхай бас гарч ирж байна.
- Нүүрсний салбарын ирээдүй БНХАУ-ын хөгжилтэй нягт холбоотой юм. Хятад улс хүрээлэн буй орчны шалтгаанаар өөрийн нүүрсний аж үйлдвэрээ хумин, нүүрс, эсвэл нүүрснээс гаргаж авсан цахилгаан эрчим хүчийг Монгол улсаас импортлох нэг хувилбар байж болох юм.
- Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх түлхүүр бол зохистой дэд бүтэц, ялангуяа төмөр зам хөгжүүлэх явдал мөн. Энд одоогоор хэсэг хугацаанд зогсонги байдалд орсон БНХАУ-ын сүлжээнд холбох Таван толгойн төмөр зам болон Эрдэнэтээр дамжуулан Овоотын ордыг ОХУ-ын сүлжээнд холбох зорилготой Аспайрын Хойд төмөр зам орно. Хятадын Хөгжлийн банк энэ төсөлд Сибирь, Хятадын боомтуудыг холбох Хойд төмөр замын коридорын нэг хэсэг болохын хувьд тухай яриа хэлэлцээнд оролцож байна.
- Шинээр нүүрсний цахилгаан станц барьж байгуулах нь Хятадын болон дотоод зах зээлд нийлүүлэх өөр нэг сонголт юм. Засгийн газар Таван толгойн цахилгаан станц зэрэг шинэ цахилгаан станцын барилгын явцыг хурдасгах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Шигтгээ 1. Монгол Улсын эрдэс баялаг (үргэлжлэл)

Алт

- Монгол улс Төв Азиар дайран өнгөрсөн хүдэр агуулсан чухал бүсэд байршдаг онцлогтой юм. Энэ нь дэлхийн хэмжээнд газрын гадаргууд хамгийн ойрхон (500-аас бага метр, Өмнөд Африкт 3 км-ийн эсрэг) байдаг томоохон ордуудтай учраас уул уурхайн зардал харьцангуй бага.
- Тус улсын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэгт хайгуул хийгдээгүй болохыг салбарын мэргэжилтнүүд онцлон тэмдэглэж байна. Гэсэн хэдий ч, Оюу толгойн их хэмжээний зэс ордын олборлолт хийгдэж эхлээд байна. Үүний зэрэгцээ, Гацууртын уурхайн 1.6 сая унцын магадлалтай нөөцийг энэ жил эцэслэн баталгаажуулах төлөвлөгөөтэй байна.

Уран болон газрын бусад ховор элемент

- Монгол улс мөн ураны нэлээд том ордуудтай. Дэлхийн цөмийн салбарын сэргэн мандалттай холбогдон ураны эрэлт хэрэгцээ ч өсөн нэмэгдэж байна.

Сэргээгдэх эрчим хүч

- Монгол улс газар нутгийнхаа онцлогоос хамааран нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэлийн хувьд асар их нөөц боломжтой. Гадаадын шууд хөрөнгө оруулалт биеллээ олж эхэлснээр энэ салбарыг сонирхох сонирхол улам өсөн нэмэгдэж байна (саяхан Softbank-аас 50 сая ам.доллар хөрөнгө оруулсан бол ЕСБХБ, ОУСК мөн төслүүдэд хөрөнгө оруулалт хийж байна). Усан цахилгаан эрчим хүчний хувьд ч 1 тэрбум ам.долларын далангийн төслийг Хятадтай хамтран судалж байна.

Бусад түүхийд эдэд төрөлжүүлэхүй


- Монгол улс мөн 60 сая мал бүхий томоохон хөдөө аж ахуйн салбартай бөгөөд Хятад, Орос, мөн Ойрхи Дорнод дахь том зах зээлд гарах боломж байна. Дэвшилтэт технологи нэвтрүүлж, мал эмнэлгийн хяналтыг сайжруулснаар ялангуяа хойд Хятад руу хийх мах, сүү, сүүн бүтээгдэхүүний экспортод ихээхэн түлхэц өгөх юм. Хатуу ширүүн өвөл болдог ч, газар тариалангийн орчин үеийн техник технологи ашигласнаар үр тариа, хүнсний ногооны үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх боломж байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой аялал жуулчлалтай хослуулбал хөдөө орон нутагт орлогын эх үүсвэр болох юм.

Саад бэрхшээлийг даван туулах

- Монгол улс уул уурхайн орд газруудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах тал дээр Мозамбик, Перу зэрэг бусад ижил түвшний улс орныг бодвол идэвхи муутай байна. 2012 оноос хойш ямар ч хайгуулын лицензи олгоогүй учраас энэ салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт Оюу толгойг эс тооцвол огцом буурсан гэсэн үг. Гэсэн хэдий ч, Оюу Толгойн II ээлжийн бүтээн байгуулалт эхэлснээр хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, уул уурхайн жижиг компаниуд эргэн ирж байна. Канадын уул уурхайн компанийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлсэн нь хөрөнгө оруулагчдын итгэлийг мөн нэмэгдүүлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах шинэ гэрээнд Канад улстай гарын үсэг зурсан явдал урам зориг өгч, хөрөнгө оруулагчдын итгэлийг улам бүр нэмэгдүүлэх болно. Мөнгө угаахтай тэмцэх болон авлигын эсрэг орчинг сайжруулах нь мөн эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх юм. Тухайлбал, мөнгө угаахтай тэмцэх асуудлаар ахиц гарвал уул уурхайн болон үндэстэн дамнасан бусад корпорацад зээл авахад нь дэмжлэг болж, улмаар Монгол улсад хөрөнгө оруулахтай холбоотойгоор дагаж мөрдөх ёстой журам зааврын зардлыг бууруулах юм.
- Уул уурхайн татварын зохистой тогтолцоо чухал юм. Гол зорилго нь нарийн мэргэшсэн туршлагатай гадаадын компаниудын оролцоог урамшуулахын зэрэгцээ Монгол улс газрын хэвлийн баялгаасаа ашиг өгөөж хүртэх боломж олгох явдал мөн. Уул уурхай бол харьцангуй машин технологийн зарцуулалт ихтэй, бусад салбарт үзүүлэх эерэг нөлөө хязгаарлагдмал салбар юм. Тэр нь уул уурхайгаас орсон татварын орлогыг эдийн засгийн бусад салбарт чиглүүлснээр л зарчмын хувьд улс оронд ахиц дэвшлийн боломж гарах болно. Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээ, хэлэлцээрийг хүндэтгэн үзэх ч, ирээдүйн төслүүдийн уул уурхайн татварын дэглэмийг хэрэгжүүлж буй татварын тогтолцоог цогцоор эргэн хянах ажлыг нэг бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзнэ.
- Татварын болон эрхзүйн зөв орчин бүрдүүлж, тээвэр, эрчим хүч зэргээр дэд бүтцээ сайжруулсан нөхцөлд Монгол улс эрдэс түүхий эдийнхээ баялаг нөөцийг ирэх хэдэн арван жилийн турш ашиглах өргөн дэлгэр нөөц бололцоо байна.

Зураг 1. Монгол улсын мэдэгдэж буй ашигт малтмалын орд газрууд

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН



Сурвалж: Уул, уурхайн яам.

Шигтгээ 2. ОУВС-гийн өмнөх бодлогын зөвлөмжийн хэрэгжилт

Эрх баригчид бодлогын тохиргоо шаардлагатай байгааг ерөнхийдөө хүлээн зөвшөөрч Дүрмийн IV заалтын зөвлөлдөх хэлэлцүүлгийн үеэр өгч байсан зөвлөмжийн заримыг нь биелүүлсэн байна. Харин 2016 оны дундуур болсон УИХ-ын сонгуулийн өмнө хэрэгжилт сулран, улмаар байдал улам бүр дордсон байна.

Түлхүүр зөвлөмж	Хэрэгжилт
Төсвийн бодлого	
<p>Төсвийн алдагдал, өрийн хэмжээг үе шаттайгаар бууруулан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Өрийн тухай хуульд заасан түвшинд хүргэх үүднээс төсвийн</p>	<p>Муу. Төсвийн зохих зорилт тусгагдсан хэдий ч хэрэгжилт нь сул байсан бөгөөд УИХ-ын сонгуулийн өмнө улам муудсан. Орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, зарцуулалтын хяналт нэлээд суларсан. Мөн улсын өр огцом өссөн байна.</p>
<p>Хөгжлийн банк, Монголбанк зэрэг төрийн байгууллагуудын зарлага санхүүжилтийг жил бүрийн төсөвт нэгтгэн төсвийн нэгдмэл байдлыг хангах.</p>	<p>Тодорхой хэмжээнд хэрэгжүүлсэн. Монголбанк одоохондоо ипотекийн зээлийн татаасын хөтөлбөрөө үргэлжлүүлсээр байх болно. Хэдий тийм ч, зарцуулалтыг олгосон байгаа ипотекийн зээлийн үндсэн өрийн болон хүүгийн төлбөрийн дүнгээр хязгаарлагдаж байгаа. Хөгжлийн банкны арилжааны зээл санхүүжилтийг төсөвт хараахан нэгтгээгүй боловч хөтөлбөрийн хүрээнд хангах ёстой төсвийн зорилтуудад тусгасан болно.</p>
Мөнгөний бодлого	
<p>Мөнгөний бодлогыг чангатгах</p>	<p>Бодлого тууштай байсангүй. ОУВС-гийн зөвлөмжийн эсрэг төсвийн шинжтэй ажиллагааг оролцуулан их хэмжээний тэлэлт хийсэн. Инфляцийн дарамт маш бага байна хэмээн Монголбанк бодлогын хүүгээ хоёр ч удаа бууруулсан. Арилжааны банкны хүү дагаж буурсангүй, эх үүсвэр илүүдэлтэй, зах зээлд итгэх итгэл муу байснаас эцсийн дүндээ валютын ханшийг сулруулсан юм. Бодлогын хүүг 4,5 нэгж хувиар нэмэгдүүлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын удирдлагын дэвшилтэт арга хэрэгсэл нэвтрүүлснээр саяхнаас мөнгөний бодлогыг чангатгаснаар нэг хэсэгтээ зах зээлийг тогтворжуулав.</p>

Валютын ханшны уян хатан байдлыг хадгалах	Зарим дэвшил гарсан ч Монголбанкны оролцоо заримдаа зах зээлийн цаг үеийн эмх замбараагүй нөхцөл байдлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлагаас илүү их байсан.
---	--

Санхүүгийн бодлого

Банкны хяналт шалгалтыг бэхжүүлэх, эрх зүйн болон үйл ажиллагааны өөрчлөлт хийх зэргээр хямралын удирдлагын тогтолцоог сайжруулах, өршөөлийг дуусгавар болгох.	Ахиц хязгаарлагдмал. ОУВС-гийн Банкны хяналт шалгалтын техник туслалцааны төслөөс банкны хяналт шалгалтын талаар тодорхой зөвлөмж өгсөнийг Монголбанк хүлээж авсан. Нөөц сан байгуулах асуудлаар шинэ журам нэвтрүүлсэн боловч сайжруулах хэрэгтэй байна. Хямралын удирдлагын тогтолцоог сайжруулах талаар дорвитой ахиц гарсангүй. Зохицуулалтын зохих арга хэмжээг авахгүй байх явдал үргэлжилсээр байна.
--	---

14. Эдийн засгийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ боломжит түвшинд хүрэхгүй байгаа ч эн тэргүүний тэргүүлэх чиглэл бол макро эдийн засгийн бодлогоо чангатгах явдал юм. Энд алдагдлыг бууруулах үүднээс их хэмжээний орлогын, мөн ялангуяа зарлагын арга хэмжээг өрийн байдлыг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бэхжүүлэхэд чиглэсэн төсвийн бүтцийн шинэчлэлтэй хослуулах ёстой. (Хавсралт II. Өрийн тогтвортой байдлын шинжилгээ, түүнчлэн дараагийн хэсэгт бүтцийн арга хэмжээний талаарх хэлэлцүүлгийг үзнэ үү.) Мөнгөний бодлогыг зохистой хэвээр байлгавал зохино. Тухайлбал, эдийн засаг тогтворжихын хэрээр бодлогын хүүг бууруулах асуудлыг болгоомжтой авч үзэх бөгөөд одоохондоо зохих хэмжээнд хатуу байр суурьтай байвал зохино. Мөн төв банк төсөвтэй адилтгах үйл ажиллагаанаас зайлсхийх хэрэгтэй. Гадаад бодлого валютын нөөцийг нэмэгдүүлэх талаар голлон анхаарах хэрэгтэй. Валютын ханш бага зэрэг үнэлгээ багатай байна гэсэн дүгнэлтийг харгалзан үзэж (Шигтгээ 3-ыг үзнэ үү), ханшийн уян хатан хөдөлгөөнийг хангах ёстой бөгөөд төв банкны интервенцийг зөвхөн зах зээлийн огцом савалгааг шийдвэрлэх төдийгөөр хязгаарлах ёстой. Эцэст нь, санхүүгийн салбарын бодлого тогтвортой байдлыг хангах, банкны салбарын зохистой үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэх ёстой бөгөөд Монголбанк зохих арга хэмжээ авахгүй байх явдлаа зогсоож, албадлагын арга хэмжээг үе шаттайгаар урьдчилан авч хэрэгжүүлэх, сайтар тодорхойлсон тогтолцоог нэвтрүүлэх бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд хангахгүй байгаа банкуудын хувьд арга хэмжээг урьтач байдлаар авах шаардлагатай байна. Энэ бүх асуудлыг эрх баригчдын хөтөлбөрт тусгасан байгаа (доороос харна уу).

15. Эрх баригчид урт хугацааны өсөлтийн төлөвийг нэмэгдүүлэх бүтцийн асуудлаар ахиц гаргах ёстой. Үүнд засаглал, институцийг бэхжүүлэх, бизнесийн орчинг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг, ялангуяа уул уурхай, хөдөө аж ахуй болон санхүүгийн салбарт дэмжих бусад шинэчлэл багтана. Эдгээр бодлого хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг Монгол улсын бодит өрсөлдөх давуу тал бүхий салбарыг дэмжих байгууллагын болон үйл ажиллагааны шинэчлэлд төвлөрсөн эдийн засгийг төрөлжүүлэх стратегид тусгалаа олох ёстой юм. Эдгээр шинэчлэлийг мөн хөтөлбөрт тусгасан байгаа.

16. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бодлогын тохиргоо, бүтцийн шинэчлэлийн зэрэгцээ

нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах, хүртээмжтэй өсөлтийг дэмжих асуудал чухал ач холбогдолтой юм.

Монгол улс нийгмийн халамжийн олон хөтөлбөртэй боловч эдгээр хөтөлбөрүүдийн үр ашгийг сайжруулах орон зай их байна. Энэ бол нийгмийн хамгааллын одоогийн тогтолцоог шинэлэг байдлаар эргэн харж 8 хүн амын нэн эмзэг давхаргад илүү чиглүүлэх асуудал юм. Энэ боломжийг ашиглан эрх баригчид орлогын их хэмжээний тэгш бус байдлыг шийдвэрлэх, илүү хүртээмжтэй өсөлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж болох юм.

Эрх баригчдын байр суурь

17. Эрх баригчид ОУВС-гийн ажлын хэсгийн зөвлөмжүүдийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрч, тэдгээрийг Засгийн газрын хөтөлбөртөө тусгасан болохыг онцлон тэмдэглэв.

"Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-т тогтворжуулах шуурхай арга хэмжээ, мөн эдийн засгийг төрөлжүүлэх, улмаар тогтвортой өсөлтийн үндэс суурийг тавих бүтцийн шинэчлэл хийхээр төлөвлөж байгаагаар онцлон тэмдэглэв. Эрх баригчид засгийн эрхийг авсан даруйдаа мөнгөний бодлогыг чангатгаж, Монголбанк болон Хөгжлийн банкны төсөвтэй адилтгах үйл ажиллагааг зогсоох зэргээр эдийн засгийн зохистой бодлогыг тууштай хэрэгжүүлэхээ онцлон тэмдэглэсэн. Мөн тэд өсөлтийг дэмжихийн тулд банкны салбарт шинэчлэл хийх шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрсөн. Цаашилбал нийгмийн нэн эмзэг хэсгийг хамгааллахын зэрэгцээ нийгмийн халамжийн тогтолцооны шинэчлэл хийх үүрэг амлалт аваад байна.


Шигтгээ 3. Гадаад сектор болон валютын ханшийн үнэлгээ

Монгол улсын төлбөрийн тэнцлийн байдал сул дорой хэвээр байгаа боловч хөтөлбөр хэрэгжсэнээр тогтвортой гольдролд орох төлөвтэй байна. Оны эхний хагас жилд явуулсан тэлэх бодлого хийгээд эдийн засгийн нөхцөл байдал тодорхойгүйн уршгаар төгрөгийн ханш 2016 онд мэдэгдэхүйц хэмжээгээр сулрав.

БНХАУ-ын нүүрсний эрэлт нэмэгдсэн, экспорт сэргэсэн, мөн оны эцсээр түүхий эдийн үнэ өссөн зэргээс шалтгаалан гадаад худалдааны тэнцэл 2016 онд сайжирсан байна. Эдийн засгийн идэвхжил сул байснаас импорт бага байлаа. Урсгал дансны алдагдал 2016 онд бага зэрэг багассан. Нийт гадаад албан нөөцийн хэмжээ 2015 оны эцсийн түвшингээс өөрчлөгдөөгүй байна. Үүнд оны эхний хагаст их хэмжээний гадаад зээл авсан нь нөлөөлсөн байна. Валютын үйлчилж буй бодит ханш 2014 оны эцсээс 2016 оны дунд үе хүртэл харьцангуй тогтвортой байж байгаад түүнээс хойш зах зээлийн тодорхой бус байдлын тусгал болон илт суларч эхэлсэн байна.

Асар их эрдэс баялагтай учраас Монгол улсын гадаад худалдааны хэтийн төлөв гэрэл гэгээтэй байдаг. Гэхдээ эдийн засаг нь цөөн салбартай, төрөлжилт дутмагаас цочролд өртөмтгий байгаа юм. Нийт экспортод ашигт малтмалын эзлэх хувийн жин 2005 онд ойролцоогоор 40 хувь байсан бол өнөөгийн байдлаар 70 гаруй хувь (сүүлийн зарим жилд 90 хувьд ч хүрч байсан) хүрч өссөн явдал Монгол улсыг түүхий эдийн үнийн өөрчлөлтийн эрсдэлд эрс мэдрэмтгий, эмзэг болгож байгаа юм. Үүнийг нэг талаас уул уурхайн шинэ төсөл хэрэгжин, хүчин чадлаа нэмэгдүүлэхтэй холбон тайлбарлаж болох ч, нөгөө талаар Монголын давуу тал болох ноолуур, нэхмэл эдлэл, түүнчлэн арьс, шир, ангийн үс зэрэг уламжлалт салбарын өсөлт эрчимтэй бус байгаагийн тусгал болж байна. Экспортын газарзүйн төвлөрөл энэхүү эмзэг байдалд улам бүр нэрмээс болдог. Цаашид Монгол улс бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд ч, түүнчлэн газар зүйн хувьд ч экспортоо төрөлжүүлэх явдал чухал ач холбогдолтой юм.

Монгол Улс: Экспорт түүхий эдийн бүлгээр




Сурвалж: Монгол улсын Үндэсний Статистикийн Хороо; болон ОУВС-гийн шинжээчдийн тооцоо.

Бүх шалгуур үзүүлэлтээр нийт гадаад албан нөөц шаардлагатай түвшингээс доогуур байна. 3 сарын импортын хэмжээ болох уламжлалт шалгуурын доох нь, Грийнспан-Гидоттигийн дүрэм болох богино хугацаат өрийн 100%-ийг хангаж чадахгүй, мөнгөний нийлүүлэлтийн 20 хувиас ялимгүй дээх нь байгаа юм. Графикт харуулсан үзүүлэлтүүдээс 3-6 сарын импорттой тэнцэх хэмжээ хамгийн зохистой байна.

Эдийн засгийн шокт өртөмтгий байдал, хадгаламжийн их хэмжээний долларжилт, түүнчлэн банкнаас хадгаламж гадагшлах үйл явцаас хамгаалах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан энэхүү интервалын дээд талаар нь шалгуураа тогтоох нь зохимжтой байж болох юм. Харин нөөцийн өнөөгийн түвшин энэ хэмжээнээс их хол доогуур байгаа юм. Ийм учраас хөтөлбөрийн хүрээнд 2020 он гэхэд нийт нөөцийг 2012 оны түвшин буюу Монгол улс гадаад шокд өртөхөөс өмнө үеийн 6½ сарын импортын хэмжээнд хүргэхээр төлөвлөж байна. БНХАУ-ын Ардын банкны своп хэлцлээр хүлээсэн үүргийг хасаад нийт гадаад албан нөөц 2022 онд 4¼ сарын импорттой тэнцэх тооцоо гарч байгаа нь шалгуурыг хангаж байгаа юм.

Нөөцийн зохистой хэмжээг тодорхойлох аргууд 1/ (импортын сараар)



Эх үүсвэр: ОУВС-гийн мэргэжилтнүүдийн тооцоолол.
1/ Халбарчлах үүднээс бүх тоог импортын сараар илэрхийлэв. Улаан зураас нь 2016 оны эцэс дэх гадаад валютын нөөцийн бодит хэмжээг (2.9 сартай тэнцэх) зааж байна. Харин босоо баганууд нь ялгаатай хэмжигдэхүүнээр илэрхийлсэн зорилгот үзүүлэлт юм.

Шигтгээ 3. Гадаад сектор болон валютын ханшны үнэлгээ (төгсгөл)

Өргөтгөсөн тэнцлийн үнэлгээний хүрээнд, гурван арга бүгд (макро тэнцвэр, тэнцвэрийн бодит үйлчилж буй валютын ханш (REER) болон гадаад тогтвортой байдал) 2016 оны эцэс гэхэд урсгал тэнцэл хэвийн хэмжээнээс бага зэрэг өндөр, мөн 2016 онд төгрөгийн ханш 25 хувиар унасантай холбогдон дотоодын мөнгөн тэмдэгт тодорхой хэмжээгээр доогуур үнэлэгдсэн болохыг харуулж байна. Хэдий тийм боловч нөөц, мөн гадаад шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын хэмжээ нэмэгдэхийн хэрээр урсгал тэнцлийн алдагдал даган нэмэгдэх төлөвтэй байгаа учраас ажлын хэсэг ерөнхий гадаад позицийг сул байна гэж дүгнэж байна. Хөтөлбөрийн хүрээнд нөөцийг өсгөн нэмэгдүүлснээр гадаад позици тогтворжих гольдролдоо эргэн орно. Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позици (ГХОЦП) маш их сөрөг утгатай буюу тэр нь 2016 оны эцсийн байдлаар ДНБ-ний 239 хувь орчим байна. Пассивын ихэнх хэсэг ам.доллараар илэрхийлэгдсэн бөгөөд гол төлөв гадаадын шууд хөрөнгө оруулалт (ДНБ-ний 118%) болон гадаад өр (ДНБ-ний 132%)-өөс бүрдэж байна.

ГШХО-таас хамааралтай эдийн засагт эхэндээ ГХОЦП сөрөг утгатай байх нь хэвийн үзэгдэл бөгөөд уурхайнуудын ашиглалт эхэлж, төлбөрийн тэнцэл сайжирснаар урт хугацаанд ГХОЦП аажимдаа сайжирдаг. Банкны салбарын цэвэр пассив позицийг ханшны эрсдэлээс хамгаалаагүй байгаа нь гадаад эмзэг байдлыг улам бүр даамжруулах эрсдэлд оруулж байна. (Гадаад өрийн динамикийн талаарх хэлэлцүүлгийг Хавсралт II-аас үзнэ үү).

Монгол улсын валютын ханшны үнэлгээ

2016

	Макро тэнцвэр	Гадаад тогтвортой байдал	REER
Суурь урсгал дансны тэнцэл	-4.1	-4.1	-4.1
Урсгал дансны норм	-4.5	-6.4	-4.8
Урсгал дансанд шаардагдаж байгаа өөрчлөлт	0.5	2.3	...
Үнэлгээнээс илүү (+) / дутуу (-) 1/	-1.4	-7.2	-6.8

1/ Өргөтгөсөн тэнцлийн үнэлгээний хүрээнд -0.32 утга бүхий мэдрэмжийн коэффициент ашиглан тооцов.

ХӨТӨЛБӨР

А. Стратеги

18. ОУВС-гийн хөтөлбөрийн зорилго бол эдийн засгийг тогтворжуулан банкны салбарыг бэхжүүлэх, цаашдын өсөлтийг хангаж, өрийн тогтвортой байдлыг сэргээх явдал мөн. Нэн тэргүүний асуудал бол эдийн засгийг тогтворжуулах явдал юм. Хөтөлбөрт хамрагдах хүсэлтийн захидал болон Эдийн засаг, санхүүгийн бодлогын санамж бичиг (аль алиныг нь Хавсралт I-аас үзнэ үү)-д тодорхойлсончлон, төсвийн алдагдлыг бууруулах явдал бол өрийн тогтвортой байдлыг сэргээн, алдагдлыг санхүүжүүлэх түвшинд байлгаж, Монголбанкн дахь гадаад валютын нөөцийг зузаатгахад тэргүүлэх ач холбогдолтой юм. Нэг хэсэгтээ мөнгөний бодлогыг хатуу байлгаж, валютын ханшийг ч уян хатан хэвээр хадгалах хэрэгтэй. Банкны салбарыг иж бүрэн оношлогоонд хамруулж, дараа нь шаардлагатай бол дахин хөрөнгөжүүлэлт, бүтцийн өөрчлөлт хийж, хууль эрх зүйн болон хяналтын тогтолцоог сайжруулах арга хэмжээ авна.

19. Хөтөлбөр мөн эдийн засгийн бүтцийн ужиг доголдлыг арилгаснаар тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн суурь үндсийг тавьж байгаа юм. Монгол улс 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш ОУВС-тай хамтран таван удаа хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд

бусад хугацаанд нь тухайлбал, түүхий эдийн үнэ өндөр байх үед дэлхий дээр эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй орны тоонд орж байв. Тэлэлт, агшилтын энэхүү мөчлөгийг дуусгавар болгож, улс орныг тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн замд оруулах нь гол зорилго мөн. Өмнөх хөтөлбөрүүд ч мөн үүнийг хийхийг

зорьж байсан боловч хэрэгжилтийн тал дээр, ялангуяа төсвийн сахилга бат, банкны салбар болон түүнийг хууль эрхзүйн хувьд бэхжүүлэх зэрэг асуудлын хувьд хэрэгжилт хангалтгүй байсан юм. Цаашид дараах шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Үүнд: (i) төсвийн бодлогыг сахилгажуулан мөчлөг дагасан байдлыг нь бууруулах; (ii) төв банкны засаглалыг сайжруулж, үндсэн чиг үүрэгт нь хандуулах; (iii) санхүүгийн секторыг бэхжүүлэх; (iv) эдийн засгийн төрөлжилт, хүртээмжтэй өсөлтийг хөхиүлэн дэмжих; болон (v) нийгмийн нэн эмзэг хэсгийг хамгаалах. Хөтөлбөрийг боловсруулахад дээр дурдсан асуудлуудаар манлайлж ирсэн Дэлхийн банк болон Азийн Хөгжлийн Банкны дадлага туршлага ихээхэн хувь нэмэр оруулсан болно.

20. Шаардлагатай бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийг харгалзан гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр /ӨСХ/-ийг санал болгож байна. Ингэснээр үндсэн суурь бэрхшээлийг шийдэхийн зэрэгцээ өрийн өсөн нэмэгдэх хандлагыг эргүүлж, валютын нөөцийг бүрдүүлэх хугацаа боломж олгох юм. Монголын хувьд өөр нэгэн боломжит хувилбар болох Стэндбай хөтөлбөр бол гол төлөв богино хугацаатай байдаг учраас улс орны бүтцийн асуудлыг шийдэхэд тохиромж муутай юм.⁵ Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр бол 2009 оны Стэндбай хөтөлбөрийн хүрээнд тохирсон шинэчлэлийн хэрэгжилт, тогтвортой ахиц дэвшлийг хязгаарласан асуудлаас зайлсхийх сайн талтай юм.

21. Өргөтгөсөн хөтөлбөрийн хүрээнд ОУВС-гийн санхүүжилтээс гадна санхүүгийн бусад түншүүд ихээхэн хэмжээний хөнгөлөлттэй зээл олгох болно. Энэхүү хөнгөлөлттэй санхүүжилт, төсвийн тохируулгын хамт Монгол улсын өндөр хүүтэй, богино хугацааны зээлээс хамаарах хамаарлыг багасгаж, улмаар өрийн тогтвортой байдлыг сэргээхэд дэмжлэг үзүүлэх юм. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк (АХБ)-аас авах тусламж бол бодлогын амлалттай холбоотой төсвийн дэмжлэг, түүнчлэн, төсөвт суусан зардлыг санхүүжүүлэхэд боломжийн хэрээр чиглэсэн төслийн санхүүжилт байх юм. Япон улс, өөрийн бодлогын матрицын хүрээнд төсвийн дэмжлэг санал болгож байна. БНСУ-ын төслийн санхүүжилтийн тусламжийн хэлбэрээр, харин БНХАУ-ын Ардын банк Монголбанктай байгуулсан своп хэлцлийн хугацааг сунгахаар тохироод байна. Бүх түншүүд олгож байгаа зээлийнхээ бодлогын хүрээнд уялдаа холбоо, агуулгыг давхцуулахгүй хангахын тулд нягт хамтран ажиллаж байна.

22. Хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын хувийн хэвшлийн зээлдүүлэгчидтэй үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тооцлоо.

- **Гадаад зээлдэгчид.** Хөтөлбөрт хамрагдах асуудлаар ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрсэнийг зарласнаас хойш тун удалгүй эрх баригчид зах зээлд гарч, 2017 оны гуравдугаар сард хугацаа нь дуусч байсан Хөгжлийн банкны 580 сая ам.долларын, жилийн 8,75 хувийн купон бүхий бондыг долоон жилийн хугацаатай, засгийн газрын шинэ бондоор амжилттай солилцлоо. Энэхүү

⁵ ӨСХ-ийн эргэн төлөх хугацаа илүү урт байгаа нь Оюу толгойн экспортын орлого нэлээд их болсон үед төлбөр хийх боломжийг олгож байгаа юм. Мөн Монгол улсын өөр том дүнтэй бондын төлбөр хийх үүрэг хүлээсэн 2021 болон 2022 онуудтай давхцахгүй байгаа юм.

хэлцлийн хувьд зах зээлийн сонирхол нэлээд их байсан бөгөөд энд мөн шинэ мөнгөний бүрэлдэхүүн хэсэг ч байсан. Нийтдээ 3½ тэрбум ам.долларын захиалга ирсэн боловч, босгох хөрөнгийн хэмжээг 600 сая ам.доллараар хязгаарласнаар эрх баригчид нэрлэсэн үнээс дээгүүр үнээр гаргаж, шинэ бондын өгөөжийг 7,625 хувь болгож бууруулж чадсан байна. Эрх баригчдын хөтөлбөр ёсоор 2018 онд хугацаа нь дуусах хоёр бондыг урьдчилан санхүүжүүлэхийн тулд зах зээлд буцаж гарна гэж тооцож байна.

- **Дотоод зээлдэгчид.** Эрх баригчид мөн хөтөлбөр хэрэгжих хугацаанд өрийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд ихэвчлэн арилжааны банк болох дотоодын зээлдүүлэгчидтэй үргэлжлүүлэн хамтран ажиллах чиглэл баримтална. Өнөөгийн байдлаар засгийн газрын зээллэгийн хэмжээ их, бодлогын хүүгийн түвшин өндөр, банкуудын тайлан тэнцэл сул дорой, бас магадгүй зах зээлийн бүтэц сул (хөрөнгө оруулагчдын бааз суурь бага, кастодиан үйлчилгээний хүчин чадал хязгаарлагдмал байгаа зэрэг) байгаа учраас дотоод өгөөж өндөр байна. Цаг хугацаа өнгөрөх тусам эдийн засаг тогтворжин өрийн зах зээлийг гүнзгийрүүлэх Засгийн газрын хүчин чармайлтын үр дүнд эдгээр хүчин зүйлсийн ихэнх нь өөрчлөгдөх төлөвтэй байна. Эдгээр өөрчлөлт, эрх баригчдын зүгээс зээлдүүлэгч нартай идэвхтэй ажилласны дүнд Засгийн газар өнөөгийнхөөс илүү хямд зардлаар (бага хүүтэй) өөрийгөө санхүүжүүлэх боломж гарна.

Б. Төсвийн бодлого


23. Хөтөлбөрийн хүрээнд төсвийн их хэмжээний тохируулга хийнэ (ЭЗСБМ, 13 т.). Тус улсын өрийн асуудал хүндэрснийг харгалзан төсвийн үндсэн буюу зээлийн үйлчилгээний зардлыг хассан тэнцлийг төсвийн гүйцэтгэлийг хянах гол үзүүлэлт болгон авч байна. Энэ нь 2016 онд ДНБ-ний 13 хувийн алдагдалтай байгааг 2020 он гэхэд ДНБ-ний ¼ хувийн ашигтай болгохыг зорьж байна. Энэ бол маш их том зорилт боловч хэрэгжих боломжтой, бодит зорилт юм. Учир нь 2016 оны нөхцөл байдалд гол төлөв нэг удаагийн (тухайлбал, өр барагдуулалт, зарим нь сонгуулийн өмнөх хөтөлбөр гэх мэт) хүчин зүйлс нөлөөлсөн юм. Төсвийн тохиргоо хийгдэж, тооцоолсон ёсоор өсөлт сэргэж, дотоод өгөөж аажмаар хэвийн түвшинд очин хөтөлбөрийн хөнгөлөлттэй санхүүжилттэй хавсран өрийн тогтвортой байдлыг сэргээнэ гэж тооцож байна.⁶ Ирэх хоёр жилд төсвийн алдагдал өндөр, өсөлт бага хэвээр, мөн өрийн хэмжээ ч 2018 оны эцэс гэхэд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлбэл ДНБ-ний бараг 90 хувь хүртэл өсөхөөр байгаа ч 2020-иод онд Оюу Толгойн үйлдвэрлэл жигдэрч, уул уурхайн болон уурхайн бус ДНБ-ний өсөлт тогтворжсоноор засгийн газрын өрийн түвшин 2022 он гэхэд ДНБ-ний 74 хувь болж буурах юм.

⁶ Төсвийн алдагдлыг багасгаснаар өсөлтөд дарамт болно гэж тооцож байгаа хэдий ч (ОУВС-ийн мэргэжилтнүүд тооцоондоо I-ээс бага зэрэг өндөр буюу нэлээд болгоомжилсон богино хугацааны үржүүлэгч ашиглахаар тооцож байна), уул уурхайн бүтээн байгуулалт хийгээд дээр дурдсан геологийн хүчин зүйлс сайжрахын хэрээр огцом агшилтаас зайлсхийх боломжтой бөгөөд 2019 он гэхэд өсөлт сэргэх юм.

Төсвийн арга хэмжээнүүд	
Тооцоолж буй хэмнэлт 2017-2019	
(ДНБ-нд эзлэх хувиар)	
Зарлагын арга хэмжээнүүд	9.0
Хөрөнгийн зардлыг бууруулах	5.2
Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж тэтгэврийн шинэчлэл хийх	1.5
Төрийн албаны цалингийн санг царцаах	1.4
Бараа, үйлчилгээ худалдан авах зардлыг бууруулах	0.9
Орлогын арга хэмжээнүүд	2.2
Орлогын удирдлагыг сайжруулах	0.1
Шатахууны онцгой албан татварын хөнгөлөлтийг хэсэгчлэн буцаах	0.8
Орлогын татварыг шатлалтай болгох	0.2
Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх	0.6
Тээврийн хэрэгсэл, согтууруулах ундаа, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх	0.3
Нийт	11.2

24. Төсвийн алдагдлыг бууруулах зорилтыг хангахдаа орлого, зарлагын олон арга хэмжээнд суурилна (ЭЗСБМ 14–15, 19 тт.). Эдгээр арга хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын зардлыг оновчтой болгож, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг царцааж, онцгой татвар, бусад татварыг нэмэгдүүлнэ.⁷ (2017 оны нэгдсэн төсвийн тодотгол болон хөтөлбөрийн үзүүлэлттэй нийцсэн бусад дэмжих арга хэмжээ авах нь хөтөлбөрийг батлах урьдчилсан нөхцөл юм). Эрх баригчид мөн татварын системд иж бүрэн нарийвчилсан үнэлгээг эхлүүлж, орлогын удирдлагын шинэтгэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хугацаанд зарлагын арга хэмжээнүүд ДНБ-ний 9 хувьтай, харин орлогын арга хэмжээнүүд 2¼ хувьтай тэнцэх хэмжээний төсвийн хэмнэлт гаргаж өгөхөөр байгаа нь нэг удаагийн зардлын хүчин зүйлс үгүй болсны зэрэгцээгээр ОУВС-гийн мэргэжилтнүүдийн үнэлгээгээр Монгол улс олон улстай харьцуулахад төсвийн орлого багатай орны тоонд бус зарлага ихтэй орны тоонд орж байна.

⁷ Хөтөлбөрт тулгарч буй эрсдэлийг харгалзан эхний үнэлгээний хүрээнд төсөв дээр болзошгүй нэмэлт арга хэмжээг боловсруулна.



25. Хөтөлбөр өнгөрсөн хугацаанд төсвийн бодлогыг алдагдуулсан үндсэн эрсдэлүүдийг авч үзэн, төсвийн үйл явцын бүх үе шатанд санхүүгийн сахилга батыг бэхжүүлнэ (ЭЗСБМ, 18 т.). Хамгийн гол нь Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар энэ байгууллага илүү бие даасан, арилжааны чиглэлтэй болж, түүнчлэн Монголбанк орон сууцны хөнгөлөлттэй хөтөлбөр зэрэг төсөвтэй адилтгах үйл ажиллагаанд шинээр цэвэр санхүүжилт олгохгүй гэсэн үүрэг амлалт авсан юм.⁸ Үүний зэрэгцээгээр, Засгийн газрын гишүүд одоо Засгийн газрын хуралдаанд асуудал оруулж хэлэлцүүлэхийн тулд Сангийн яамны зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай болно; УИХ төсвийн нийт зарлагын дүнг нэмэгдүүлэх боломжгүй болно; төсвийн болон макро эдийн засгийн хараат бус урьдчилсан тооцоо, судалгааг гаргаж өгөх чиг үүрэг бүхий Төсвийн зөвлөл байгуулна; төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог үлэмж чангатгана; мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлд илүү нийцүүлэх болно. Түүнээс гадна, Төсвийн тухай хуулийн хариуцлага, төсвийн тодотгол зэрэг асуудалд холбогдох зүйл, заалтыг ёсчлон хатуу чанд дагаж мөрдөх болно.

В. Мөнгөний болон валютын ханшийн бодлого

26. Монголбанк мөнгөний бодлогоо зохистой хэмжээнд хатуу байлгах үүрэг хүлээв (ЭЗСБМ, 21т.). Инфляци 2016 оны эцсийн байдлаар 1 хувиас бага байсан түвшингөөсөө өсөн нэмэгдэж эхлээд байгаа бөгөөд энэ жил 6 хувьд хүрэх төлөвтэй байна. Хэдий тийм ч одоогийн байдлаар бодлогын хүү жилийн 14 хувь, бодит хүү эерэг, өмнөх үеийнхээс илүү өндөр түвшинд байгаа юм. Иймд эдийн засаг тогтворжиж, төлбөрийн тэнцлийн болон инфляцийн үзүүлэлт боломжийн түвшинд байгаа нөхцөлд мөнгөний бодлогыг зөөллөх санал гарч ирж болох юм. Гэсэн хэдий ч, ялангуяа хөтөлбөрийн хүрээнд их хэмжээний гадаад санхүүжилт (нэг дор) орж ирэх

⁸ Эрх баригчид хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх улмаар яваандаа хувийн хэвшилд шилжүүлэх санаатай байгаа.

тул зах зээл дээрх эх үүсвэрийн нийлүүлэлтийг Монголбанк болон Сангийн яам хоёр нягт хамтран удирдах хэрэгтэй юм.

27. Хөтөлбөрийн хүрээнд хийх нэгэн чухал алхам бол олон улсын шилдэг туршлагад нийцсэн Төв банкны хуулийн шинэчлэн найруулгыг батлах явдал мөн (ЭЗСБМ.22-23 тт).

Шинэчлэн найруулсан хууль Монголбанкны бүрэн эрхийг тодорхой болгох, түүний засаглал, хараат бус байдлыг бэхжүүлэх болно. Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүд одоо бодлогын шийдвэрт саналын эрхтэй оролцох болж, банкны хяналт шалгалтын асуудлаар хамтын шийдвэр гаргадаг болно. Монголбанк мөн байгууллагын бүтцийн шинэчлэл хийж, ялангуяа хүний нөөц, мэдээллийн технологийг сайжруулахад голлон анхаарч, захиргааны өөрчлөлт ч хийх юм. Монголбанк жил бүр хийлгэдэг хөндлөнгийн аудитаа үргэлжлүүлэн хийлгэж, мөн эрх баригчид Монголбанкны өөрийн хөрөнгө сөрөг утгатай болсон асуудлыг (алдагдалтай төсвийн шинжтэй үйл ажиллагааг эцэс болгон төсөв/өрийн шинжтэй үр дагаврыг харгалзан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гаргах) шийдвэрлэх стратеги боловсруулах үүрэг хүлээх юм.

28. Хөтөлбөрийн дагуу валютын ханшны уян хатан чөлөөт хөдөлгөөнийг хязгаарлахгүй хэвээр байлгана (ЭЗСБМ т.24).

Зах зээл дээр үүссэн эмх замбараагүй нөхцөл байдлыг залруулах, мөн валютын нөөцийг бүрдүүлэх зах зээл дээр бий болсон нааштай нөхцөл байдлыг ашиглан валют худалдан авахаас бусад тохиолдолд зах зээл дээрх төв банкны оролцоог хязгаарлах болно. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бодлогын тохиргоо, орж ирэх санхүүжилтийг харгалзан хөтөлбөр дуусгавар болоход, Монголбанк гадаад шокт нэрвэгдэхээс өмнөх буюу 2012 оны үеийн түвшинд хүрсэн, өөрөөр хэлбэл нөөцийн зохистой байдлыг шалгуур үзүүлэлт (Шигтгээ 3-ыг үзнэ үү)-ийг хангасан 6½ сарын импорттой тэнцэх хэмжээний валютын нөөцтэй болсон байна. (Өмнө дурьдсанчлан, БНХАУ-ын Ардын банкны своп хэлцлийн эх үүсвэрийг оруулахгүй байсан ч 4¼ сарын импортын хэрэгцээг хангах хэмжээний хангалттай нөөцтэй болох тооцоо гарч байна.)

Г. Санхүүгийн салбарын бодлого

29. Санхүүгийн салбарын шинэчлэлийн үр дүнд эрүүл, тогтвортой санхүүгийн тогтолцоог бий болгохыг зорино.

Монголын банкуудын санхүүгийн тайлан мэдээнээс үзвэл системийн нөхцөл байдал ерөнхийдөө асуудалгүй мэт харагдаж байгаа боловч хөрөнгийн ангилал, эрсдлийн нөөц сан байгуулах банкуудын практик болон хяналт шалгалтын зохих арга хэмжээг авахгүй байх хандлага зэргээр зарим ноцтой асуудлыг нуун дарагдуулсан байх магадлалтай юм. Тийм учраас банкны системийг эрүүлжүүлэх эхний шийдвэрлэх алхам бол банкуудын тайлан тэнцэлд иж бүрэн оношлогоо хийх явдал мөн. Дараагийн ээлжинд шаардлагатай бол банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх, заримыг нь татан буулгах хүртэл арга хэмжээ авах хэрэгтэй. Үүний зэрэгцээ эрх баригчид банкны эрх зүйн зохицуулалтыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх, банкны хяналт шалгалтыг бэхжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт хяналт шинжилгээ хийх, үзүүлэх дэмжлэгийг сайжруулах зэрэг арга хэмжээ авна. Мөн чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх тогтолцоог сайжруулахыг зорьж байгаа бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр чухал чухал арга хэмжээ хэрэгжүүлж эхлээд байна. Хөгжлийн банкныг Монголбанк хянан шалгадаг болсон явдал чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглүүштэй

ЮМ.

30. Активын чанарын хараат бус үнэлгээ (АЧҮ)-г бүх банкинд хийлгэнэ (ЭЗСБМ, 27 т.).

Монголбанк нь ОУВС-гийн мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийг боловсруулсан байгаа бөгөөд (урьдчилсан нөхцөл болгож) АЧҮ хийж гүйцэтгэх боломжтой аудит/зөвлөх компаниудын дунд тендер зарлаад байна. Үнэлгээ хийх компаниудыг удахгүй сонгон шалгаруулах бөгөөд аравдугаар сарын эцэс гэхэд АЧҮ-г хийж дуусгахаар төлөвлөж байна. Үүний дараагаар үнэлгээгээр илэрсэн аливаа дутагдлыг шийдвэрлэх бизнес төлөвлөгөө болон өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө танилцуулахыг банкуудаас шаардах юм. Ингэхдээ дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө, 2019 он хүртэл ашиг, алдагдлын урьдчилсан тооцоо зэргийг хамруулсан байх шаардлага тавьж байгаа юм. Монголбанк банкуудаас хүлээн авсан бизнес төлөвлөгөөг нь өөрийн дотоод стресс тест загвараар (хөтөлбөрийн хугацаанд цаашид учирч болзошгүй хохирлыг тооцон) сорин нягтлан шалгаж, 2017 оны 12 дугаар сарын эцэс гэхэд банкуудын бизнесийн болон дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг нь батлах (эсвэл няцаах) тухайд эцсийн шийдвэрээ гаргана. АЧҮ эсвэл бизнесийн төлөвлөгөөний шинжилгээний аль нэгээр өөрийн хөрөнгийн хомсдол илэрсэн тохиолдолд тухайн банкнаас одоо байгаа эсвэл шинэ хувьцаа эзэмшигчдээсээ хөрөнгө босгохыг шаардах бөгөөд 2018 оны зургадугаар сар гэхэд дахин хөрөнгөжүүлэх ажил дуусгавар болсон байх ёстой. Өнөөгийн байдлаар банкны системийн дахин хөрөнгөжүүлэх хөрөнгө оруулалтын хэрэгцээ ДНБ-ний 7 хүртэл хувьтай тэнцэнэ гэсэн урьдчилсан тооцоо байна.

31. Эхний ээлжинд төсвийн хөрөнгөөс бус харин банкуудын одоогийн хувь нийлүүлэгчдийн хөрөнгөөр бүхэлд нь дахин хөрөнгөжүүлэхийг зорино (ЭЗСБМ, 28-32 тт.).

Банкууд хувьцаа эзэмшигчдээсээ эсвэл хувийн хэвшлээс хөрөнгө босгож чадаагүй нөхцөлд мөн тэр нь санхүүгийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулах хэмжээнд хүрсэн гэж үзвэл ОУВС-тай зөвшилцөн боловсруулсан хатуу шалгуурыг хангасан тохиолдолд төсвийн хөрөнгийг ашиглаж болно.⁹ Дахин хөрөнгөжүүлэхдээ эхний ээлжинд хувийн хөрөнгийг богсоход ач холбогдол өгөх болно. Гэхдээ энэ нь хангалтгүй байж болох учраас өрийн тогтвортой байдлын шинжилгээнд ДНБ-ний 3,5 хувьтай тэнцэх хэмжээний болзошгүй өр төлбөр тусгасан болно. Төсвийн хөрөнгийг ашигласан банкуудад бизнесийн бүтцийн өөрчлөлт, засаглалын, магадгүй удирдлагын өөрчлөлт хийх шаардлагатай болно. Эдгээр банкууд дахь төрийн өмчийн эзэмшлийг эрх баригчид хууль журмын дагуу эрх тэгш менежмент хийх үүрэг амлалт авч байна. Системийн эрсдэлд хүргэхгүй жижиг банкууд хувийн эх үүсвэрээс хөрөнгөө бүрэн босгож чадаагүй бол татан буулгана.

32. Эрх зүйн зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог шинэчилнэ (ЭЗСБМ, 33 т.).

Банкны тухай хууль болон Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон холбогдох дүрэм, журамд дараах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд: (i) активын ангилал, эрсдлийн нөөц сан байгуулах болон барьцааны үнэлгээг сайжруулах; (ii) хувьцаа эзэмшигчид, удирдлагад тавих шаардлагыг зохистой болгох, холбогдох этгээдэд олгосон зээлийн эрсдэл болон эцсийн ашиг хүртэгч өмчлөгчийн талаарх дүрэм журмыг шинэчлэх; (iii) урьдчилж арга хэмжээ авах тогтолцоог боловсронгуй болгох; (iv) банкиг татан буулгах шийдвэр гүйцэтгэлийг сайжруулах; (v) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын босгыг чангатгах; ба (vi) нэмэлт хөрөнгө оруулалт болон нөөц сан

⁹ Ийм тохиолдолд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах мөн төсвийн хөрөнгийг ашиглах талаар шинэ хууль хэрэгтэй болох байх.

байгуулах, мөн хяналт шалгалтын зардал гаргуулах үүднээс банкуудаас шимтгэл, хураамж нэхэмжлэх Монголбанкны бүрэн эрхийг нэмэгдүүлэх зэрэг болно. Мөн, Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-ийн тухай хуулийг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулна. Эцэст нь, Монгол улсын Хөгжлийн банкны тухай шинэ хуулийн дагуу Хөгжлийн банкнийг Монголбанкны хяналт, шалгалтанд хамруулах асуудлыг байхыг баталгаажуулсан.

33. Өрийн асуудлын үр дүнтэй шийдлийг тууштай дэмжинэ (ЭЗСБМ, 35 т.). Банкуудын одоогийн үйл ажиллагааны орчинг хянан шинжилж, дампуурал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон татварын хууль тогтоомжтой холбоотой аливаа хүндрэл бэрхшээлийг, мөн чанаргүй зээлийн худалдах, бусдад шилжүүлэхэд саад болж буй хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхойлж, тодорхойлсон саад бэрхшээлийг үе шаттайгаар арилгах хуваарь тогтоох зэргээр чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх стратеги боловсруулна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл энэхүү стратегийг 2018 оны нэгдүгээр сарын эцэс гэхэд батлах юм. Энэ чиглэлээр эрх баригчид техник туслалцаа авах хүсэлт тавих төлөвлөгөөтэй байгаа. Монголбанк ч мөн чанаргүй зээлийг шийдвэрлэх зохистой бодлого, стратеги, бас эх үүсвэртэй байхыг, түүнчлэн чанаргүй зээлийн тайлангаа сайжруулахыг банкуудаас шаардах болно. Банкууд чанаргүй зээлийн асуудлыг дангаараа удирдах чадваргүй болох нь батлагдвал эрх баригчид цаашид ОУВС болон бусад түншүүдтэй хамтран төрийн өмч давамгайлсан хөрөнгийн менежментийн компанийн асуудлыг авч үзнэ.

34. Банк бус санхүүгийн салбар жижиг боловч тогтмол хяналт шалгалт хийх шаардлагатай. Монгол улсын санхүүгийн нийт активын 5-аас бага хувь эзлэж байгаа учраас санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахгүй боловч энэ салбарт хяналт шалгалт тавих асуудал сорилт болж байна. Санхүүгийн зохицуулах хорооны чадавхийг энэ чиглэлээр сайжруулах хэрэгтэй.

35. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлнэ (ЭЗСБМ, 36- 37 тт.). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль болон Эрүүгийн хуульд 2018 оны гуравдугаар сарын эцэс гэхэд нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр авлигатай тэмцэх хүчин чармайлтыг дэмжих хууль эрх зүйн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан батлахыг эрх баригчид зорьж байна. Цаашид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, авилгатай тэмцэх эрх бүхий байгууллагын хөрөнгө хүч, дадлага туршлагыг бэхжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Мөн ОУВС, АХБ, Ази, Номхон далайн бүлэг, Дэлхийн банк зэрэг олон талт хөгжлийн түншүүдтэй хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлнэ.

Д. Нийгмийн хамгаалал ба өрсөлдөх чадвар/төрөлжүүлэлт

36. Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь хөтөлбөрийн чухал тэргүүлэх чиглэл юм (ЭЗСБМ, 20 т.). Монгол улс томоохон хэмжээний макро эдийн засгийн тохиргоо хийх учраас нийгмийн нэн эмзэг хэсгийг хангалттай хамгаалсан байх нь амин чухал юм. Эрх баригчид “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийн санхүүжилтийг нийт өрхийн нэн ядуу 40 хувьд чиглүүлэх бөгөөд эндээс гарсан бүх хэмнэлтийг нэн ядуу бүлэгт зориулсан хүнсний талоны зарцуулалтыг нэмэгдүүлэхэл ашиглана. Ингэснээр нийгмийн хамгааллын хавтгайрсан зардлыг илүү үр ашигтай,

үр дүнтэй болгоно. Үүний зэрэгцээ, Монгол улсад нийгмийн халамжийн 70 гаруй хөтөлбөр байгаагийн ихэнх нь зорилтот бүлэгт давхардан олгогдож байна. Эдгээр хөтөлбөрүүдийг тэтгэмжийн хэмжээг нь бууруулалгүй нэгтгэснээр захиргааны зардал зэргээр зарим нэг бага хэмжээний хэмнэлт бий болгох юм. Эцэст нь, Дэлхийн банк, АХБ-ны зүгээс нийгмийн хамгааллын тогтолцоо илүү үр дүнтэй болгохын тулд өөр бусад хэд хэдэн санал санаачлага дээр ажиллаж байна.

37. Эдийн засгийг төрөлжүүлэх, түүний өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээ авч байна (ЭЗСБМ, 38 т.). Тус улс ашигт малтмалаар баялаг учраас уул уурхай үргэлжид эдийн засгийн гол салбар байх боловч хөдөө аж ахуй, аялал жуулчлалын хувьд ч бас нөөц бололцоо их байна. Мал эмнэлгийн тогтолцоог сайжруулах, ургамлын хорио цээрийн стандартыг дээшлүүлснээр, Орос болон Хятад улс руу махны экспортыг эрчимжүүлэх төлөвлөгөөтэй байна; 60 сая гаруй толгой малтай улсад энэ талын нөөц боломж их байгаа юм. Эрх баригчид мөн ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр дээр ажиллаж байгаа бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийг бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр шинэчилнэ. Эцэст нь, эрх баригчид аялал жуулчлалын сонирхол татах газар болохын хувьд Монгол улсаа сурталчлах хүч чармайлтаа улам бүр нэмэгдүүлнэ.

Е. Хөтөлбөрийн санхүүжилт, хэлбэр, ба эрсдэл

38. Монгол улсын квотын 435 хувьтай тэнцэх хэмжээ (314,5054 сая ЗТЭ буюу 425 сая орчим ам.доллар)-ний санхүүжилтийн эрх нээхийг санал болгож байна. Ингэхдээ хөтөлбөрийн хугацаанд хэтийн төлөвт ОУВС-гийн мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ, хийгдэх шинэчлэлийн цар хүрээ, нийт гадаад санхүүжилтийн хэрэгцээний тооцоо зэргийг үндэслэн энэ хэмжээний санхүүжилт (энгийн нөхцлөөр авах санхүүжилтийн эрхийн дээд хэмжээ)-ийг санал болгож байна.

39. Олон болон хоёр талт хандивлагчид санхүүгийн нэмэлт дэмжлэг үзүүлснээр нийт санхүүжилт 5½ тэрбум ам.доллар болж байна. Азийн хөгжлийн банк хөтөлбөрийн хугацаанд нийт 900 сая гаруй ам.долларын дэмжлэг үзүүлэх болсны 600 сая ам.долларыг төсвийн дэмжлэгт, 300 сая ам.долларыг төслийн санхүүжилтэд тус тус олгоно. Дэлхийн банк хөтөлбөрийн хугацаанд төсвийн дэмжлэгт 400 сая ам.долларын дэмжлэг үзүүлэх амлалт өгсөн, мөн нэмэлт 200 сая ам.долларыг төслийн санхүүжилтийн хэлбэрээр олгох төлөвтэй байна. Япон улс 850 сая ам.доллар амласнаас бүгдийг нь төсвийн дэмжлэгт зориулахаар болсон. БНСУ 2017–2022 онуудад өмнө амласан 200 сая ам.долларыг оролцуулан нийтдээ 700 сая ам.долларын төслийн санхүүжилт хийхээр боллоо. Энэхүү хөнгөлөлтэй дэмжлэг хийгээд дунд хугацаанд санхүүжилтийн нийт хэрэгцээг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж байгаа хувийн хэвшлийн оролцооны стратеги байгаагүй байсан

Монгол улс: Хөтөлбөрийн санхүүжилт (2017-2022) (сая ам.доллар)	
	<u>Нийт санхүүжилт</u> 2017-2022
Санхүүжилт	5,650
ОУВС	425
Олон улсын санхүүгийн бусад байгууллага	1,500
Дэлхийн банк 1/ Үүнээс төслийн санхүүжилт	600 175
АХБ Үүнээс төслийн санхүүжилт	900 300
Хоёр талын түнш улс орон	1,550
Япон	850
Солонгос Үүнээс төслийн санхүүжилт	700 700
БНХАУ-ын Ардын банкны своп хэлцэл	2,175
Сурвалж: ОУВС-ийн шинжээчдийн урьдчилсан тооцоо.	
1/ Дэлхийн банк хөтөлбөрийн хугацаанд төсвийн дэмжлэгт 400 сая ам.долларын дэмжлэг үзүүлэх амлалт өгсөн, мөн нэмж 200 сая ам.долларыг төслийн санхүүжилтийн хэлбэрээр олгох төлөвтэй байна.	

бол Монгол улсын өр тогтвортой гольдролд орж чадахгүй байсан билээ. БНХАУ-ын Ардын банк 2017 оны 8 дугаар сард хугацаа нь дуусч байсан 15 тэрбум юань (2,2 тэрбум ам.доллар)-ийн дүн бүхий своп хэлцэлээ 2020 он хүртэл сунгасан байна. Цаашилбал, Монгол улсын бодлого хөтөлбөрийн дагуу хэрэгжсэн тохиолдолд энэхүү своп хэлцлээ 2020 онд дахин сунгаж болно гэдгийг БНХАУ-ын Ардын банкнаас илэрхийлээд байна. Эцэст нь, хөтөлбөр хэрэгжсэнээр хувийн хэвшлийн санхүүгийн болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжинэ гэсэн хүлээлттэй байгаа. Саяхан амжилттай хийсэн бондын солилцоо үүнийг нотолж байгаа юм.

40. Хөтөлбөр бүрэн санхүүжигдсэн. Хөтөлбөрийн эхний 12 сард үүсэх санхүүжилтийн дутууг хандивлагчдын эх үүсвэрээр бүрэн нөхөх баталгаа бий болсон. Мөн түүнчлэн хөтөлбөрийн үлдсэн хугацаанд ч олон талт болон хоёр талт хангалттай санхүүжилт орж ирнэ гэсэн сайн хэтийн төлөв харагдаж байна. Түүнчлэн, эхний жилийн санал болгож буй төслийн санхүүжилтийг Монгол улсын төсвийн зардлын зүйл ангитай тулгаж өгч, төсөвтэй адилтгах үйл ажиллагаа болгон хувиргаснаар санхүүжилтийн дутууг нөхөхөд дэм болж байна.¹⁰ Эцэст нь, хөтөлбөрт хувийн хэвшлийн зээлдүүлэгчдийн оролцоо хадгалагдан үлдэхээр тусгасан билээ.

41. Эргэн төлөх чадвар. Монгол улс санал болгож буй хөтөлбөрийн хүрээнд олгогдох зээлийн төлбөрийн тухайд хүлээсэн үүргээ биелүүлнэ гэж үзэж байгаа. Өнөөгийн байдлаар Монгол улсад ОУВС-гийн зээлийн төлөгдөөгүй өрийн үлдэгдэл байхгүй, зээлийн өө сэвгүй түүхтэй юм. ОУВС-гийн зээлийн дүн хамгийн ихдээ ДНБ-ний 3½ хувиар хязгаарлагдах буюу нийт гадаад нөөцийн 10 орчим хувийг эзэлж байна. Тийм учраас Монгол улс ОУВС-гийн зээлийг эргүүлэн төлөх хангалттай чадвартай хэмээн ажлын хэсэг үзэж байна. Монгол улс БНХАУ-аас 1986-1991 онуудад авсан 5,6 сая швейцарь франкийн өртэй байна; хоёр тал энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж байгаа бөгөөд БНХАУ Монгол улсын хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг авч хэлэлцэхэд татгалзах зүйлгүй болохоо Захирлуудын зөвлөлд илэрхийлсэн юм.

42. Хөтөлбөр ихээхэн эрсдэлтэй тулгарч байна. Эрх баригчид хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх амлалт өгч байгаа хэдий ч, дотоод бодлого эргэж буцах ихээхэн эрсдэл байсаар байна. Энэ нь бодлогын амлалтын эмзэг чанар, мөн (2017 оны

Монгол улс: Хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарь
(сая ам.доллар)

	2017 оны II улирал	2017 оны III улирал	2017 оны IV улирал	2018 оны I улирал
Санхүүжилт	313	198	248	278
ОУВС	57	28	28	28
Олон улсын санхүүгийн бусад байгууллага, хоёр талын хандивлагчид	257	170	220	249
Сурвалж: ОУВС-ийн шинжээчдийн хэтийн тооцоо				

¹⁰ Хөтөлбөрийн сүүлийн жилүүдэд олгогдох санхүүжилтийн хэмжээг Монгол улсын эрх баригчид болон хандивлагч нар дахин ярилцан шийдэж, санхүүжилтийг бүрэн ашиглах хуваарийг гаргана.

зургадугаар сард болох Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон 2020 оны парламентын сонгууль) сонгуулийн мөчлөгөөс хамаарч байгаа юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвар маш хүчтэй улс төрийн дэмжлэгт тулгуурласан боловч шинэчлэлийн цар хүрээ маш өргөн байна. Тийм учраас ОУВС хэд хэдэн чиглэлээр техник туслалцаа үзүүлэн дэмжих болно.

Бас түүхий эдийн үнэ унах, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах, дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн эерэг үр нөлөө буурах, уул уурхайн томоохон төслүүд хойшлох, зээлийн нөхцөл муудах зэргээр олон янзын болзошгүй гадаад шокд өртөх эрсдэл бас байна. Эдгээр хүчин зүйлс өсөлт хийгээд өрийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болох юм.

43. Эдгээр эрсдлийг харгалзан хөтөлбөрийн үнэлгээг улирал тутам хийнэ. Эхний болон хоёр дахь багц шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2017 оын 4 дүгээр сар болон 7 дугаар сар эцсийн байдлаар тус тус үнэлэх болно. Хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл, гадаад цэвэр албан нөөц, Монголбанкны дотоод цэвэр актив, дунд болон урт хугацаатай хөнгөлөлттэй бус гадаад өр болон Засгийн газар, Монголбанкны баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдэл (дээд хязгаар) зэрэг тоон үзүүлэлтээр шалгуур хийж улирал тутам хянаж, мониторинг хийнэ. Дунд болон урт хугацаатай хөнгөлөлттэй бус гадаад өр болон хугацаа хэтэрсэн гадаад өр төлбөрийн хуримтлагдсан дүн гэсэн хоёр үзүүлэлтээр гүйцэтгэлийн тогтмол шалгуур (дээд хязгаар нь “тэг”) ашиглана. Мөн нөөц мөнгөний хувьд завсрын зорилтот үзүүлэлт тавьж өгнө. Дээр дурдсан шинэчлэлийн гол арга хэмжээнд гарч байгаа ахиц дэвшлийг хэмжих үүднээс бүтцийн шалгуур үзүүлэлт тогтоож өгсөн болно.

44. Урьдчилсан нөхцөл. Захирлуудын зөвлөлийн хурлын өмнө эрх баригчид дараах нөхцөлийг урьдчилан хангаад байна. Үүнд:

a. Хөтөлбөрийн зорилтот үзүүлэлтүүдийг тусгасан 2017 оны төсвийн тодотгол болон дунд хугацааны төсвийн хүрээг батлан 2017 оны зорилтот үзүүлэлтүүдийг хангахад шаардлагатай төсвийн бүх арга хэмжээг УИХ-аар батлуулах. Үүнийг 4 дүгээр сарын 13-нд хангасан.

b. Активын чанарын үнэлгээний ажлын даалгаврыг ОУВС-гийн мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж, нэр хүнд бүхий компаниудаар хийлгэх зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг эхлүүлэх. Үүнийг 3 дугаар сарын 31-нд хангасан.

c. Ипотекийн зээлийн хөтөлбөр болон төсөвтэй адилтгах аливаа бусад зээл (жишээ нь, компаниудад) олгох Монголбанкны цэвэр санхүүжилтийг зогсоох. Энэ тухайд Монголбанкнаас энэ оны 4 дүгээр сарын 13-нд албан тоот ирүүлсэн.

45. Урьдчилан сэргийлэх үнэлгээ. Монголбанкин дээр урьдчилан сэргийлэх үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтэд эхний үнэлгээ хийх үеэр эцэслэх төлөвтэй байна. Энэ тухайд тусгай ажлын хэсэг Монголбанкин дээр ажиллаад 4 дүгээр сарын эхээр буцсан. Монголбанк олон улсын тэргүүлэгч нягтлан бодох бүртгэлийн компаниудаар аудит хийлгэдэг, санхүүгийн тайлангаа хэвлэн нийтэлдэг практикаа үргэлжлүүлнэ. Шинэчилсэн үнэлгээгээр шилдэг туршлага, урьдчилан сэргийлэх шаардлагад төв банкны хяналт, засаглал болон хууль эрх зүйн орчин аль хэр нийцэж байгааг үнэлэх юм. Хөтөлбөр урьдчилсан хамгаалах асуудлыг тухайлбал Монголбанкны хууль эрх зүйн шинэчлэл хийх шаардлага, төсөвтэй адилтгах үйл ажиллагааг нь хязгаарлах арга хэмжээг хэдийнэ тусгасан юм.

АЖЛЫН ХЭСГИЙН ҮНЭЛГЭЭ

46. Монгол шиг гэнэтийн гадаад шокд нэрвэмтгий улсад бодлогын сахилга бат нэн чухал юм. Монгол Улс ашигт малтмалын арвин их нөөцтэй, харин нэг салбарт, мөн экспортын нэг зах зээлээс хэт хамааралтай байгаа учраас гэнэтийн гадаад шокд нэрвэмтгий, маш эмзэг байна. Зохистой бодлого хэрэгжүүлэхгүй бол тэлэлт, агшилтын мөчлөгт амархан орох бөгөөд сүүлийн жилүүдэд яг л ийм юм болсон. 2008-2009 оны хөтөлбөр амжилттай хэрэгжиж, эрдэсээр баялаг улсад тохирсон хамгийн сүүлийн үеийн шилдэг төсвийн тогтолцоог нэвтрүүлсэн юм. Харин үүнийгээ ягштал баримтлах улс төрийн хүсэл зориг дутсанаас түүхий эдийн үнэ сэргэхэд төсвийн зарцуулалт ч дагаад нэмэгдсэн билээ. Хожим нь, гадаад нөхцөл байдал эргэн муудсан үед эрх баригчид эдийн засгаа дэмжих тэлэх бодлого хэрэгжүүлсэн нь төсвийн, гадаад тэнцлийн болон санхүүгийн ноцтой хямралд хүргэсэн билээ.

47. Одоо эдийн засгийг тогтворжуулах үүднээс макро бодлогыг нэн даруй чангатгах хэрэгтэй. Өрийн тогтвортой байдлыг сэргээх замд оруулахын тулд төсвийн алдагдлыг огцом бууруулах ёстой. Хөтөлбөрийн хүрээнд орж ирэх хөнгөлөлттэй санхүүжилт энэ шилжилтийг түргэтгэн, өрийн тогтвортой байдлыг сэргээхэд дэмжлэг болно. Мөнгөний бодлогыг хатуу хэвээр байлгах ёстой боловч эдийн засаг тогтворжихын хэрээр зарим талаар сулруулж болно. Валютын ханш 2016 оны огцом уналтаас хойш нэлээд доогуур үнэлэгдсэн байгаа хэдий ч гадаад цочролын эсрэг жийрэг болгон ашиглахын тулд уян хатан байлгах хэрэгтэй. Монгол улсын гадаад эдийн засгийн байр суурь өнөөгийн байдлаар сул дорой байгаа хэдий ч, хөтөлбөрт хамрагдсанаар тогтворжих хандлагатай байна.

48. Бүтцийн шинэчлэл бол хөтөлбөрийн үр дүн тогтвортой байх, өнгөрсөн хугацааны тэлэлт, агшилтын мөчлөгийг давталгүй, түүнээс урьдчилан сэргийлэх бүрэлдэхүүний түлхүүр хэсэг мөн. Хөтөлбөр (МУХБ болон Монголбанкны төсөвтэй адилтгах үйл ажиллагааг зогсоох зэргийг багтаасан) төсвийн сахилга батыг чангатгах, төв банкны хараат бус байдал, засаглалыг сайжруулах, банкны салбарыг бэхжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх цогц арга хэмжээг хамарч байгаа юм. Мөн хөтөлбөрт нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлж, нэн эмзэг бүлгийг хамгаалахад чиглэсэн зорилтот шинжтэй болгож байгаа юм.

49. Эрх баригчид хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүсэл зориг дүүрэн байгаа боловч энэ бол өндөр эрсдэлтэй хөтөлбөр юм. Хөтөлбөрийн бодлогыг Засгийн газар бүрэлдээд тун удаагүй байхдаа өнгөрсөн зун боловсруулсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-өөс бараг тэрчигээр нь авсан бөгөөд Засгийн газар УИХ-д үнэмлэхүй олонхийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч, олон арга хэмжээ хэрэгжүүлэхэд хэцүү, улс төрийн маргаан дагуулах магадлалтай, ялангуяа цаг хугацаа өнгөрөхийн хэрээр шинэчлэлээс залхах явдал даамжран, олон чиглэлээр бодлогын ухралт гарах эрсдэл бий. Үүний зэрэгцээ, эдийн засгийн гадаад шокийн магадлал байж л байгаа, мөн түүхий эдийн үнэ унах, худалдааны гол түншийн эдийн засгийн өсөлт удаашрах, уул уурхайн томоохон төслүүд саатах, эсвэл дэлхийн зах зээлийн нөхцөл байдалд сөрөг өөрчлөлт гарах юм бол бүгд эргээд Монгол улсын тооцоолж буй эдийн засгийн сэргэлт, өрийн тогтвортой байдалд ноцтой үр дагавартай байж болно. Эдгээр эрсдэлээс хамгаалахын тулд хөтөлбөрийг батлуулахын өмнө

урьдчилан биелүүлэх нөхцөлийг тусгаж, бодлогын хэд хэдэн үүрэг амлалтыг боломжийн хэрээр эрт хэрэгжүүлж эхлүүлэхээр тохирсон бөгөөд улирал тутам үнэлгээ хийх болно.

50. Ажлын хэсэг өргөтгөсөн хөтөлбөрт хамрагдах эрх баригчдын хүсэлтийг дэмжиж байна. Монгол улсын төлбөрийн тэнцлийн хэрэгцээг харгалзан, авч хэрэгжүүлсэн байгаа бодлогын арга хэмжээ, хөтөлбөрийн хугацаанд алсыг харсан шинэчлэлийг хэрэгжүүлэх эрх баригчдын амлалт, хүсэл зоригийн үндсэн дээр ажлын хэсэг 314,5054 сая ЗТЭ-тэй тэнцэх хэмжээний өргөтгөсөн хөтөлбөрт хамрагдах Монгол улсын хүсэлтийг дэмжиж байна.


8/ Баталгаа, хөрөнгийн өөрчлөлт, хүүгийн орлогыг /хэрвээ байгаа бол/ оруулсан. Төсөөллийн хувьд төсөөллийн хугацаанд гарах ханшийн өөрчлөлтийг хамруулав.

9/ Үндсэн хувьсагчид (ДНБ-ий бодит өсөлт, бодит хүү, бусад өрийг нэмэгдүүлэх урсгалууд) өмнөх төсөөлсөн оны түвшинд хэвээр байна гэж тооцсон.



Монгол Улс: Улсын өрийн тогтвортой байдлын шинжилгээ - Улсын өрийн бүтэц ба алтернатив хувилбарууд

Улсын өрийн бүтэц



Алтернатив хувилбарууд

— Суурь төсөөлөл Өмнөх гүйцэтгэлд суурилсан хувилбар - - - - - Үндсэн тэнцэл тогтмол байх хувилбар



Үндсэн таамаглалууд
(Хувиар)

Суурь хувилбар	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	Өмнөх гүйцэтгэлд суурилсан хувилбар	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026
	ДНБ-ий бодит өсөлт	-0.2	1.8	8.1	5.3	6.1	8.5	7.0	7.0	6.8		6.7	ДНБ-ий бодит өсөлт	-0.2	7.4	7.4	7.4	7.4	7.4	7.4	7.4
Инфляц	9.3	4.4	4.9	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7	Инфляц	9.3	4.4	4.9	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7
Үндсэн тэнцэл	-5.5	-3.1	-1.0	0.3	1.5	1.6	1.5	1.6	1.5	1.6	Үндсэн тэнцэл	-5.5	-5.0	-5.0	-5.0	-5.0	-5.0	-5.0	-5.0	-5.0	-5.0
Үйлчилж буй хүү	5.2	6.1	5.6	4.8	4.2	3.7	3.8	4.2	4.4	4.8	Үйлчилж буй хүү	5.2	6.1	4.2	2.9	2.0	1.2	0.8	0.9	0.8	0.9
Үндсэн тэнцэл тогтмол байх хувилбар																					
ДНБ-ий бодит өсөлт	-0.2	1.8	8.1	5.3	6.1	8.5	7.0	7.0	6.8	6.7											
Инфляц	9.3	4.4	4.9	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7											
Үндсэн тэнцэл	-5.5	-5.5	-5.5	-5.5	-5.5	-5.5	-5.5	-5.5	-5.5	-5.5											
Үйлчилж буй хүү	5.2	6.1	5.3	4.7	4.2	3.9	4.0	4.5	4.7	5.1											

Эх үүсвэр: ОУВС-гийн мэргэжилтнүүд


Монгол Улсын өрийн тогтвортой байдлын шинжилгээ - Суурь таамаглалын биелэгдэх магадлал

Өмнөх таамаглалын биелсэн байдал /бусад улс орнуудтай харьцуулснаар/

ДНБ-ий бодит өсөлт

(Хувиар, бодит төсөөлөл)


Монгол: таамаглалын дундаж утгын алдаа, 2006-2014: **-0.70**
хувиар илэрхийлсэн түвшин: **29%**



Үндсэн тэнцэл

(ДНБ-ий хувиар, гүйцэтгэл-төсөөлөл)


Монгол: таамаглалын дундаж утгын алдаа, 2006-2014: **-0.69**
хувиар илэрхийлсэн түвшин: **29%**



Инфляц /дефлятор/

(хувь, гүйцэтгэл-төсөөлөл)


Монгол: таамаглалын дундаж утгын алдаа, 2006-2014: **-0.41**
хувиар илэрхийлсэн түвшин: **20%**



Төсвийн тохиргооны төсөөллийн биелэгдэх магадлалыг үнэлэх нь


Мөчлөгийн нөлөөллийг арилгасан үндсэн тэнцлийн (МНАУТ) 3 жилийн тохиргоо

(ДНБ-ий хувиар)



Мөчлөгийн нөлөөллийг арилгасан үндсэн тэнцлийн (МНАУТ) 3 жилийн дундаж түвшин


(ДНБ-ий хувиар)



Огцом өсөлт, уналтын шинжилгээ

ДНБ-ий бодит өсөлт

(Хувиар)



Эх үүсвэр: ОУВС-гийн мэргэжилтэнүүд

1/ Зурагдсан тархаалт, хувиар илэрхийлсэн түвшин бүх улс орнуудад хамаарна. Төсөөллийг өмнөх жилийн хавар хийгдсэн ДЭЗТБ-д суурилсан.

2/ Өрийн түвшин ДНБ-ий 60 хувиас давсан хөгжингүй болон шинэ тутам хөгжиж буй орнуудын 1990-2011 онуудын жилийн тоон мэдээлэлд суурилсан. Босоо тэнхлэгт түүврийн хувийг харуулав.

Монгол Улсын өрийн тогтвортой байдлын шинжилгээ - Стресс тест


Макро-төсвийн стресс тест

— Суурь төсөөлөл
— ДНБ-ий бодит өсөлтийн шок


— Үндсэн тэнцлийн шок
— Бодит ханшийн шок

— Бодит хүүгийн шок


Улсын нийт өр, нэрлэсэн дүнгээр (ДНБ-ий эзлэх хувиар)



Улсын нийт өр, нэрлэсэн дүнгээр (Орлогод эзлэх хувиар)



Нийт санхүүжилтийн хэрэгцээ (ДНБ-ий эзлэх хувиар)




Нэмэлт стресс тест

— Суурь төсөөлөл


— Макро-төсвийн нийлмэл шок

— Болзошгүй өр төлбөрийн шок


Улсын нийт өр, нэрлэсэн дүнгээр (ДНБ-ий эзлэх хувиар)



Улсын нийт өр, нэрлэсэн дүнгээр (Орлогод эзлэх хувиар)



Нийт санхүүжилтийн хэрэгцээ (ДНБ-ий эзлэх хувиар)



Үндсэн таамаглалууд

(хувиар)

	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026		2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026
Үндсэн тэнцлийн шок											ДНБ-ий бодит өсөлтийн шок										
ДНБ-ий бодит өсөлт	-0.2	1.9	8.3	5.5	6.3	8.5	7.0	7.0	6.8	6.7	ДНБ-ий бодит өсөлт	-0.2	-3.9	2.3	5.3	6.1	8.5	7.0	7.0	6.8	6.7
Инфляц	9.3	4.4	4.9	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7	Инфляц	9.3	3.0	3.5	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7
Үндсэн тэнцэл	-5.5	-5.5	-3.1	-1.0	0.3	1.5	1.5	1.5	1.5	1.5	Үндсэн тэнцэл	-5.5	-6.0	-4.7	-3.8	1.5	1.6	1.5	1.6	1.5	1.6
Үйлчилж буй хүү	5.2	6.1	5.8	5.1	4.4	4.0	4.1	4.5	4.7	5.1	Үйлчилж буй хүү	5.2	6.1	5.4	4.8	4.3	3.7	3.8	4.2	4.4	4.7
Бодит хүүгийн шок											Бодит ханшийн шок										
ДНБ-ий бодит өсөлт	-0.2	0.6	7.1	4.7	5.7	8.3	6.8	6.8	6.6	6.5	ДНБ-ий бодит өсөлт	-0.2	1.3	7.8	5.3	6.1	8.5	7.0	7.0	6.8	6.7
Инфляц	9.3	4.4	4.9	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7	Инфляц	9.3	6.1	4.9	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7
Үндсэн тэнцэл	-5.5	-3.1	-1.0	0.3	1.5	1.6	1.5	1.6	1.5	1.6	Үндсэн тэнцэл	-5.5	-3.6	-1.5	0.3	1.5	1.6	1.5	1.6	1.5	1.6
Үйлчилж буй хүү	5.2	6.1	5.8	5.4	4.9	4.6	5.0	5.5	5.9	6.3	Үйлчилж буй хүү	5.2	6.3	5.3	4.7	4.1	3.6	3.7	4.1	4.3	4.6
Нийлмэл шок											Болзошгүй өр төлбөрийн шок										
ДНБ-ий бодит өсөлт	-0.2	-3.9	2.3	4.7	5.7	8.3	6.8	6.8	6.6	6.5	ДНБ-ий бодит өсөлт	-0.2	-3.9	2.3	5.3	6.1	8.5	7.0	7.0	6.8	6.7
Инфляц	9.3	3.0	3.5	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7	Инфляц	9.3	3.0	3.5	5.9	5.8	5.9	5.8	5.6	5.7	5.7
Үндсэн тэнцэл	-5.5	-6.0	-5.7	-4.1	0.3	1.5	1.5	1.5	1.5	1.5	Үндсэн тэнцэл	-5.5	-3.1	-1.0	0.3	1.5	1.6	1.5	1.6	1.5	1.6
Үйлчилж буй хүү	5.2	6.3	5.8	5.4	5.0	4.8	5.1	5.6	5.9	6.4	Үйлчилж буй хүү	5.2	6.4	5.3	4.7	4.1	3.6	3.7	4.1	4.3	4.6

Эх үүсвэр: ОУВС-гийн мэргэжилтнүүд


Монгол Улсын өрийн тогтвортой байдлын шинжилгээ: Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн нэгдсэн дүрслэл

Өрийн түвшин1/	ДНБ-ий бодит өсөлтийн шок	Үндсэн тэнцлийн шок	Бодит хүүгийн шок	Валютын ханшийн шок	Болзошгүй өр төлбөрийн шок
Нийт санхүүжилтийн хэрэг	ДНБ-ий бодит өсөлтийн шок	Үндсэн тэнцлийн шок	Бодит хүүгийн шок	Валютын ханшийн шок	Болзошгүй өр төлбөрийн шок
Өрийн төлөв байдал 3/	Зах зээлийн хандлага	Гадаад санхүүжилтийн хэрэгцээ	Богино хугацаат өрийн өөрчлөлт	Оршин суугч бус этгээдийн эзэмшиж буй өр	Гадаад валютын өр


Улсын нэрлэсэн өрийн магадлалт тархалт

(ДНБ-д эзлэх хувиар)



Өрийн эмзэг байдлын шинжилгээ

(эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлттэй харьцуулсан үзүүлэлтүүд)



Эх үүсвэр: ОУВС-гийн мэргэжилтэнүүд

1/ Тодорхой шок эсвэл суурь төсөөллийн үед өрийн дарамтын шалгуур үзүүлэлт 70 хувиас хэтрээгүй тохиолдолд ногооноор, өрийн дарамт зөвхөн тодорхой шокийн үед хэтэрч байвал шар өнгөөр, суурь төсөөллийн үед хэтэрч байвал улаанаар, стресс тест хамааралгүй үед цагаанаар нүдийг тэмдэглэсэн болно.

2/ Тодорхой шок эсвэл суурь төсөөллийн үед нийт санхүүжилтийн хэрэгцээний шалгуур үзүүлэлт 15 хувиас хэтрээгүй тохиолдолд ногооноор, зөвхөн шокийн үед хэтэрч байвал шар өнгөөр, суурь төсөөллийн үед хэтэрч байвал улаанаар, стресс тест хамааралгүй тохиолдолд цагаанаар нүдийг тэмдэглэсэн болно.

3/ Хэрвээ тухайн орны үнэлгээ анхааруулах доод утгаас доогуур байвал ногооноор, анхааруулах дээд утгаас дээгүүр байвал улаанаар, хэрвээ энэ 2 утгын дунд оршиж байвал шараар тэмдэглэсэн. Хэрвээ тоон өгөгдөл байхгүй, эсвэл энэ тест хамааралгүй бол цагаанаар тэмдэглэсэн.

Эрсдэлийн үнэлгээний доод, дээд хязгаарыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Бондын хүүгийн зөрүү /спред/ 200-600 хооронд, гадаад санхүүжилтийн шаардлага ДНБ-ий 5-15 хувийн хооронд, богино хугацаат өр төлбөрийн хувь хэмжээний өөрчлөлт 0.5-1 хувийн хооронд, оршин суугч бус этгээдийн эзэмшиж буй улсын өрийн хэмжээ 15-45 хувийн хооронд, гадаад валютаар илэрхийлсэн өр 20-60 хувийн хооронд

4/ 2017 оны 1 сарын 5-наас 4 сарын 5-ны хоорондын 3 сарын хугацааны АНУ-ын ЗГ-ын бондын хүүтэй харьцуулсан хүүгийн зөрүү /спред/

5/ Гадаад санхүүжилтийн хэрэгцээг урсгал дансын алдагдал, дунд болон урт хугацааны гадаад нийт өрийн үндсэн төлбөр, өмнөх оны эцэс дэх богино хугацаат гадаад өрийн нийлбэр дүнгээр тодорхойлсон.

Гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээ

Гадаад өрийг оршин суух шалгуурын дагуу тодорхойлох бөгөөд гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээний хамрах хүрээнд дараах зүйлийг оруулж байна. Үүнд: (i) төрийн болон төрөөс баталгаа гаргасан гадаад өр, үүний дотор хоёр талын болон олон улсын байгууллагаас авсан хөнгөлөлттэй зээл болон своп хэлцлийн шугамыг; (ii) банкны салбар болон хувийн корпорациудын гадаад өр төлбөрийг хамруулна. Монгол улсын хувьд уул уурхайтай холбоотой компани хоорондын зээл хувийн хэвшлийн гадаад өрийн ихэнх хэсгийг бүрдүүлдэг. Компани хоорондын зээл 2016 оны эцсийн байдлаар нийт гадаад өрийн 30 орчим хувийг эзэлж байна.⁴


Монгол улсын нийт гадаад өр маш өндөр байгаа ба гадаадын хөрөнгө оруулалттай компани хоорондын зээл энэ тоог өсгөн харагдуулж байна. Гадаад өр 2016 оны эцсийн байдлаар ДНБ-ий 220 хувь буюу 7.1 тэрбум ам.долларын компани хоорондын зээлийг хасч тооцвол ДНБ-ий 155 хувьтай тэнцэж байсан. Эдгээр зээлийг оршин суух шалгуураар гадаад өрийн нэг хэсэг гэж үздэг боловч тэдгээртэй холбоотой эрсдэл төрийн болон хувийн хэвшлийн бусад хэлбэрийн гадаад өрийг бодвол Монгол улсын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаатай шууд холбоогүй юм.

Гадаад өр 2016 онд огцом өссөн нь шинээр авсан гадаад зээллэг, мөн валютын ханшны их хэмжээний уналтын хавсарсан үйлчлэлээр нөхцөлдсөн юм. Гадаад өр 2015 оны эцсээс 2016 оны эцэс хүртэл ДНБ-ий 30 хувиар өссөн байна. Улсын гадаад өр, гуравдугаар сард Засгийн газрын Кредит Суиссээс шинээр авсан 250 сая ам.долларын зээл, дараа нь дөрөвдүгээр сард 500 сая ам.долларын бонд гаргаснаар ойролцоогоор 7 хувиар өссөн байна. Гадаад өрийн 2016 оны өсөлтийн үлдсэн ихэнх хэсгийг төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2015 оны эцэстэй харьцуулахад бараг 25 хувиар унаснаас үүдэлтэй байна.

Гадаад өрийн түвшин 2017 онд оргилдоо хүрээд 2018 оноос хойш хурдан буурна. Энэ бууралтын хэмжээ нь шокд мэдрэмтгий байна. Монгол улс 580 сая ам.долларын бондын зах зээлийн солилцоог амжилттай хийсэн, бөгөөд 2018 онд хугацаа нь дуусч байгаа бондын хугацааг сунгахын тулд жилийн эцсээр зах зээл дээр эргэн ирэх магадлалтай байна. Хөтөлбөрийн хүрээнд хандивлагчдын их хэмжээний хөнгөлөлттэй дэмжлэг богино хугацаанд гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлж байгаа хэдий ч хэсэг хугацааны дараа энэ хямдхан санхүүжилт, мөн Монгол улсын дунд хугацааны суурь үзүүлэлтүүд сайжирснаар гадаад өрийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ. Одоо хэрэгжиж байгаа уул уурхайн бүтээн байгуулалтын ачаар 2017 оноос эхлэн, ялангуяа урьдчилсан тооцоолж буй хугацааны эцэс рүү их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирснээр экспортын болон өсөлтийн динамикийг эерэг болгох төлөвтэй байна. Хэдий тийм ч, өрийн динамик гадаад шокуудад, ялангуяа төгрөгийн ханшны огцом уналтад өртөмтгий хэвээр байгаа юм (уул уурхайн компаниудын орлого ам.доллараар орж ирж байгаатай холбогдуулан тэдний төлбөрийн чадвар ханшны өөрчлөлтөөс хамгаалагдсан байгаа учраас Компани хоорондын зээлийн хувьд дээрх нөлөөллийг хэтрүүлэн үнэлсэн байх талтай).

⁴ Энэ тоо 2015 оны эцсээр 50 хувь орчим байсан бөгөөд 2016 онд буурсан нь Оюу Толгойд орж ирсэн компани хоорондын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 4.1 тэрбум ам.долларыг урт хугацаатай гадаад зээл болгон хувиргаснаар компани хоорондын зээлийн ангилалд хамрагдахгүй болсон явдал голлон нөлөөлжээ.

График 1. Гадаад өрийн тогтвортой байдал: Хязгаарын тестүүд 1/ 2/



Эх сурвалж: ОУВС, улс хариуцсан мэргэжилтнүүдийн тооцоолол.

1/ Бодит гүйцэтгэлийн тоонуудыг сүүдэрлүүлэн харуулав. Аль ч шок нь хагас стандарт хазайлтанд тогтвортой. Суурь хувилбар болон бодит байдлын хувьсах үзүүлэлтүүдийн дундаж төсөөллүүдийг дөрвөлжин хайрцагт харуулав. Мөн бодит тоонуудын 10 жилийн дундажийг энд бас харж болно.

2/ Түүхэн хувилбаруудын хувьд, 10 жилийн бодит тоонуудын дундажийг авсан ба үүнийг өрийн дараагийн таван жилийн динамикийг тооцоолоход ашиглалаа.

3/ Шокийн 1/4 стандарт хазайлтын тогтвортой үзүүлэлтийг зээлийн бодит хүү, өсөлтийн хувь, урсгал дансны тэнцэлд хэрэглэв.

Хүснэгт 1. Гишүүн орон: Гадаад өрийн тогтвортой байдлын хүрээ, 2012-2022
(өөрөөр заагаагүй бол ДНБ-нд эзлэх хувиар)

	Гүйцэтгэл					Төсөөлөл						Өрийг тогтворжуулах хүүгийн бус урсгал данс 6/	
	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022		
1 Суурь: Гадаад өр	125.2	151.2	171.7	186.3	220.0	235.5	232.7	215.3	198.4	178.9	159.1	-19.4	
2 Гадаад өрийн өөрчлөлт	32.7	26.0	20.5	14.6	33.7	15.5	-2.8	-17.4	-16.9	-19.5	-19.9		
3 Гадаад өр үүсгэгч болох нь тогтоогдсон урсгал (4+8+9)	-22.7	5.8	14.0	10.1	52.7	-4.7	-9.3	-24.3	-16.7	-18.6	-17.6		
4 Урсгал дансны алдагдал, хүүгийн төлбөрийг оруулаагүй	25.5	21.6	5.2	-3.7	-5.1	-6.9	-1.2	3.9	1.8	0.6	0.4		
5 Бараа үйлчилгээний тэнцлийн алдагдал	-108.6	-100.1	-108.7	-87.8	-99.8	-2.4	2.0	5.4	2.7	1.0	-1.4		
6 Экспорт	43.5	39.6	52.1	45.3	50.8	55.5	54.6	54.8	54.7	55.1	53.4		
7 Импорт	-65.1	-60.5	-56.7	-42.6	-49.1	53.0	56.6	60.2	57.4	56.2	52.0		
8 Өр үл үүсгэгч хөрөнгийн цэвэр урсгал (сөрөг утгатай)	-35.9	-16.7	-2.3	-0.9	37.0	-9.7	-14.7	-20.8	-16.6	-15.8	-10.0		
9 Өрийн автомат динамик өөрчлөлтүүд 1/	-12.3	0.9	11.1	14.7	20.8	11.9	6.6	-7.5	-2.0	-3.5	-8.0		
10 Нэрлэсэн хүүгийн нөлөөлөл	1.9	3.8	6.3	7.7	9.2	11.3	10.8	9.8	8.8	7.8	5.9		
11 Бодит ДНБ-ний нөлөөлөл	-9.6	-14.2	-12.3	-4.2	-1.9	0.5	-4.2	-17.2	-10.8	-11.3	-13.9		
12 Үнэ, ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл 2/	-4.5	11.4	17.1	11.2	13.5		
13 Үлдэгдэл, нийт гадаад активын өөрчлөлтийг оруулаад (2-3) 3/	55.3	20.2	6.5	4.5	-19.0	20.3	6.6	6.9	-0.2	-0.8	-2.2		
Гадаад өр, экспортын харьцаа (хувиар)	287.8	382.0	329.8	411.3	433.4	424.5	425.9	392.8	362.6	324.4	297.7		
Нийт гадаад санхүүжилтийн хэрэгцээ (тэрбум ам. доллар)	4.1	4.0	2.4	1.3	2.1	2.8	3.5	4.2	3.4	3.2	3.2		
ДНБ-нд эзлэх хувиар	33.2	32.0	19.3	11.5	19.0	27.0	32.8	37.0	27.4	23.9	21.9		
Гол хувьсагчдыг түүхэн дундажаар нь авсан хувилбар 5/						235.5	221.0	208.2	190.9	174.0	157.4	-24.8	
Суурь хувилбарыг гаргахад авсан макро эдийн засгийн гол нөхцөлүүд						<u>Historical Average</u>	<u>Standard Deviation</u>						
Бодит ДНБ-ний өсөлт (хувиар)	12.3	11.6	7.9	2.4	1.0	7.4	5.8	-0.2	1.8	8.1	5.3	6.1	8.5
ДНБ-ний ам. долларын дефлятор (өөрчлөлт хувиар)	5.1	-8.3	-10.2	-6.1	-6.8	4.4	16.0	-6.7	0.7	0.9	1.5	1.3	1.4
Гадаад зээлийн нэрлэсэн хүү (хувиар)	2.4	3.1	4.1	4.3	4.6	2.7	1.4	4.8	4.7	4.6	4.4	4.2	3.6
Экспортын өсөлт (ам. долларынх, хувиар)	-1.7	-6.9	27.5	-16.4	5.5	13.6	27.4	1.8	1.0	9.4	6.7	8.3	6.7
Импортын өсөлт (ам. долларынх, хувиар)	5.4	-4.8	-9.3	-27.8	8.5	16.9	39.6	0.7	9.4	16.0	1.9	5.2	1.9
Урсгал дансны тэнцэл, хүүгийн төлбөр ороогүй	-25.5	-21.6	-5.2	3.7	5.1	-9.3	12.0	6.9	1.2	-3.9	-1.8	-0.6	-0.4
Өр үл үүсгэгч хөрөнгийн цэвэр орох урсгал	35.9	16.7	2.3	0.9	-37.0	11.5	22.1	9.7	14.7	20.8	16.6	15.8	10.0

Page 1

1/ $[r - g - r(1+g) + ea(1+r)] / (1+g+r)$ -ийг өмнөх үеийн өрийн үлдэгдлээр үржүүлж бодов. $r =$ гадаад өрийн нэрлэсэн үйлчилж буй зээлийн хүү, $g =$ ам. долараар илэрхийлсэн ДНБ-ний дефляторын өөрчлөлт, $e =$ ДНБ-ний бодит өсөлтийн хувь, $a =$ нэрлэсэн ханшийн чангаралт (дотоодын мөнгөн тэмдэгтийн ам. долараар илэрхийлсэн үнэ цэнийн өсөлт, $a =$ гадаад өрийн дүнд дотоодын валютаар авсан өрийн эзлэх хувь.

2/ Үнэ, валютын ханшны өөрчлөлтийн нөлөөлөлийг бодохдоо $[-r(1+g) + ea(1+r)] / (1+g+r)$ -ийг өмнөх үеийн өрийн үлдэгдлээр үржүүлж бодов. Дотоодын валют чангарч, инфляци (ДНБ-ний дефляторт суурилсан) өсвөл g нэмэгдэнэ ($e > 0$).

3/ Тооцоололд энэ мөрөнд үнэ ба валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөг тусгав.

4/ Урсгал дансны алдагдал дээр өнгөрсөн хугацааны эцэст байсан дунд ба урт хугацаат, богино хугацаат өрийн төлбөрийн дүнг нэмж гаргана.

5/ Гол хувьсах хэмжигдэхүүнд нь ДНБ-ний бодит өсөлт; бодит хүү; долларын дефляторын өсөлт, хүүгийн бус урсгал данс болон зээлээс бусад орох урсгалын ДНБ-д эзлэх хувийн жин орно.

6/ Урт хугацаандаа тогтмол тэнцэл нь өрийн харьцааг тогтворжуулна. Гэхдээ гол хувьсах хэмжигдэхүүнүүдийг (ДНБ-ний бодит өсөлт, бодит хүү, долларын дефляторын өсөлт, зээлээс бусад орох урсгалын ДНБ-

Нэмэлт хавсралт I. Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай албан хүсэлтийн захидал

2017 оны 4 дүгээр сарын 13

Улаанбаатар

Хатагтай Кристин Лагард
Тэргүүн
Олон Улсын Валютын Сан
Вашингтон хот, К.Т. 20431

Хүндэт хатагтай Лагард,

Монгол улс бол асар их ашигт малтмалтай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын нөөц боломжтой, авъяаслаг ажиллах хүчин, мөн хүчирхэг ардчилал бүхий орон. Бидний урт хугацааны ирээдүй эргэлзээгүй гэрэл гэгээтэй юм. Гэхдээ сүүлийн жилүүдэд бид түүхий эдийн үнийн огцом бууралт, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) унаснаар хүнд цохилтод өртөөд байна. Эдгээр цочролоос эдийн засгийг хамгаалах хүчин чармайлт өндөр өсөлтийг хэсэг зуур хадгалж чадсан боловч, улсын өр нэмэгдэн гадаад байдал суларч, банкуудын активын чанар буурахад хүргэсэн байна. Үүний үр дүнд, зах зээлийн итгэл буурч, өсөлт буурсанаар хүн амын өргөн давхаргыг хамарсан хүндрэл бэрхшээл, эдийн засгийн ноцтой эмзэгшил нүүрлэж байна.

Монгол Ардын Нам 2016 оны зургадугаар сарын парламентын сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж, эдийн засгийг сэргээж, хуримтлагдсан асуудлыг шийдвэрлэх сонгуулийн уриатай засгийн эрхэнд гарч ирсэн юм. Бид Монгол улсын эдийн засагт тулгамдаад буй хүндрэлүүдийн цар хүрээг ил тод хүлээн зөвшөөрч, олон улсын санхүүгийн байгууллага, бусад гол түншүүдтэйгээ хамтран зөвшилцсөний үндсэн дээр "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг нэн даруй бэлтгэн, төлөвлөгөөний дагуу шуурхай арга хэмжээ авч ирлээ. Бусад арга хэмжээний зэрэгцээ тухайлбал, Монголбанк 8 дугаар сард бодлогын хүүгээ 4,5 нэгж хувиар нэмэгдүүлж, мөн төсвийн алдагдлыг бууруулах зорилготой төсвийг УИХ арваннэгдүгээр сард баталсан. Төсвийн алдагдлыг ОУВС-гийн тодорхойлолтоор 2016 онд ДНБ-ний 17 хувиас энэ жил 10.6 хувь болтол бууруулж баталсан.

Түүнчлэн бид Таван толгой гэх мэт уул уурхайн гол төслүүдийн яриа хэлэлцээг эхлүүлээд байгаа ба шинэчлэлийн эхний хүнд хэцүү үеийн дараагаар эдийн засгийн тогтвортой, урт хугацааны өсөлтийг хангах үүднээс бүтцийн шинэчлэлийн хэд хэдэн түлхүүр арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. Төсвийн тогтолцоогоо сайжруулах чухал арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд Монголбанкны тухай хуулийг бүрэн шинэчилснээр сүүлийн үеийн бодлогын алдааг давталгүй урьдчилан сэргийлнэ гэж үзэж байна. Санхүүгийн салбарын хувьд бид дараах зүйлийг төлөвлөж байна. Үүнд: (i) банкны системийн иж бүрэн оношилгоог явуулж шаардлагатай бол дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх, (ii) эрх зүйн зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулах, (iii) засаглалыг сайжруулах болон (iv) чанаргүй активын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно. Эцэст нь, бид эдийн засгийг төрөлжүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч байна.

Олон талт болон хоёр талт хөгжлийн түншүүд маань хөтөлбөрийн бодлогын тохиргоо, бүтцийн шинэчлэлд дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй санхүүжилт олгох үүрэг амлалт аваад байна. Эдгээр тусламж дэмжлэг хөтөлбөрийн маань санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болох чухал ач холбогдолтой юм. Үүнээс гадна, өндөр хүүтэй, богино хугацааны бусад өрийн хамаарлыг багасгах боломж олгосноор өрийн төвшин болон санхүүжилтийн нийт хэрэгцээг бууруулах, улмаар өрийн тогтвортой байдлыг сэргээхэд дэмжлэг болно.

Хавсралтаар толилуулж буй Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандум (ЭЗСБМ) нь Монгол улсын Засгийн газраас 2017-2020 онуудад хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулж байна. Бодлогын эдгээр арга хэмжээний дэмжлэг болгон 314,5054 сая ЗТЭ (Монгол улсын квотын 435 хувьтай тэнцэх хэмжээнд)-тэй тэнцэх хэмжээний санхүүжилт бүхий ОУВС-гийн гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (EFF)-т хамрагдах хүсэлтээ үүгээр уламжилж байна. ЭЗСБМ-ын хавсралт Хүснэгт А1-ээр өргөтгөсөн санхүүгийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжилтийг хянах зорилтот тоон үзүүлэлтүүдийг тогтоож, мөн дагалдах Техникийн санамж бичигт эдгээр зорилтот үзүүлэлтийг хэрхэн тодорхойлж, үнэлгээ хийх тухайд нарийвчлан тайлбарласан байгаа. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг батлахын өмнө урьдчилан авах нөхцөлт арга хэмжээний жагсаалт болон бүтцийн шинэчлэлийн гол үзүүлэлтүүдийг ЭЗСБМ-ын хавсралт Хүснэгт А2-т тусгасан байгаа. Бид хөтөлбөрийн хүрээнд гарсан ахиц дэвшлийг үнэлэхэд шаардлагатай Техникийн санамж бичигт заасан мэдээллээр ОУВС-гийн ажилтнуудыг цаг тухайд нь хангах болно.

Бид ЭЗСБМ-д заасан бодлого хөтөлбөрийн зорилгод хүрэхэд хангалттай гэж үзэж байгаа ба шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ авахад бэлэн байна. Бид, ЭЗСБМ-д тусгасан бодлогын хэрэгжилтийн талаар, мөн тэдгээр бодлогод ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх бол ОУВС-гийн дүрэм, журмын дагуу ОУВС-гийн ажилтнуудтай урьдчилан зөвшилцөх болно.

Засгийн газрын ил тод байх бодлогын хүрээнд энэхүү захидал, ЭЗСБМ, Техникийн санамж бичиг болон ажлын хэсгийн тайлангийн мэдээллийн чанартай хавсралтуудыг олон нийтэд мэдээлэхээр төлөвлөж байна. Иймд, Захирлуудын зөвлөл энэхүү Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг баталсны даруйд ОУВС-гийн цахим хуудас дээр эдгээр баримт бичгийг хэвлэн нийтлэх эрхийг ОУВС-гийн ажилтнуудад үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

/гарын үсэг зурсан/

Б.Чойжилсүрэн
Сангийн сайд

/гарын үсэг зурсан/

Н.Баяртсайхан
Монголбанкны ерөнхийлөгч

Хавсралтууд
Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандум
Техникийн санамж бичиг

Хавсралт I. Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандум 2017 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засаг, санхүүгийн бодлогын энэхүү меморандум (ЭЗСБМ) Монгол улсын эдийн засагт үүссэн нөхцөл байдал, сүүлийн үеийн өөрчлөлтүүд болон цаашдын төлөв байдлыг тодорхойлохоос гадна ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дэмжлэгтэй авч хэрэгжүүлэх бодлогын болон бүтцийн шинэчлэлийн хөтөлбөрийг танилцуулна.

I. Нөхцөл байдал

1. **Монгол улс эдийн засгийн хүчирхэг чадавхитай боловч хэд хэдэн хүндрэлтэй тулгараад байна.** Бидэнд идэвхитэй ашиглаж байгаа ашигт малтмалын томоохон нөөц, өндөр боловсролтой хүн ам, мөн эдийн засгаа төрөлжүүлэн Азийн бүс нутгийн интеграцад илүү идэвхитэй оролцох нөөц боломж байна. Гэвч зургадугаар сард Засгийн газар маань шинээр бүрэлдэхэд өсөлт зогсонги байдалд орсон, төлбөрийн тэнцэл доройтсон, их хэмжээний төсвийн алдагдал, өсөн нэмэгдэж буй өр, банкны системийн асуудал хуримтлагдсан зэргээр эдийн засгийн байдал маш хүнд хэцүү сорилтой тулгарсан байлаа.

2. **Эдгээр бэрхшээлийг зарим талаар томоохон гадаад цочролууд нөхцөлдүүлсэн байна.** ГШХО 2011 онд 4½ тэрбум ам.доллар (ДНБ-ний 40 гаруй хувь) байсан бол Оюу Толгойн зэс, алтны уурхайн бүтээн байгуулалтын эхний үе шат дуусч, хоёр дахь үе шатны маргаан, хөрөнгө оруулалтын орчинд сөрөг өөрчлөлт орсон, нүүрс, зэсийн экспортын үнэ огцом унасан зэргийн тусгал болж 2015 онд бараг тэг болж буурсан байна. Ингэснээр, экспортын болон төсвийн орлого эрс багасгахад хүргэсэн юм.

3. **Бодлогын алдаа ч бас нөлөөлсөн.** Түүхий эдийн үнэ өндөр байсан сайн цагт хамгаалалт бүрдүүлж чадаагүй, үнэ унаж нөхцөл байдал муудахад авч хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих бодлого түр хугацаанд өндөр өсөлтийг хадгалахад тусалсан хэдий ч улсын өрийг нэмэгдүүлэн төлбөрийн тэнцлийг улам сулруулж, банкны активын чанарт сөргөөр нөлөөлж, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдагдуулснаар эдийн засгийн эмзэг байдлыг хурцатгасан байна. Үүнд:

- **Төсвийн бодлого.** Монгол улсын Хөгжлийн банк (МУХБ) 2015 он хүртэл хэдэн жилийн турш төсвийн шинжтэй зарцуулалт хийж ирсэнээс нэгдсэн төсвийн алдагдлыг ДНБ-ний 10 хүртэл хувьд хүргэсэн байна. Цаашилбал, 2016 оны сонгуулийн өмнөх үеийн зарцуулалт нэмэгдсэнээр төсвийн алдагдлыг (ОУВС тодорхойлолтоор) ДНБ-ний 17 хувь хүртэл нэмэгдүүлэв.
- **Мөнгөний болон ханшны бодлого.** Монголбанк 2012-14 онуудад тэлэх бодлого хэрэгжүүлж ирсэн: бодлогын хүүг нэлээд бууруулж, төсвийн шинжтэй хэд хэдэн зээлийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлснээр эдийн засагт ДНБ-ний 25 орчим хувьтай тэнцэх хэмжээний мөнгөний нийлүүлэлт хийсэн байна. Ийм бодлого зээлийн огцом өсөлтийг урамшуулж, импорт өсөхөд хүргэв. Төгрөгийн ханш аажим суларч байсан боловч, энэ үед Монголбанк төгрөгийн ханшийг хамгаалах гэж удаан хугацаанд оролдсоноор 2012 онд 4 тэрбум гаруй ам.доллар байсан нөөцөө 2015 оны эцэс гэхэд 1,3 тэрбум ам.доллар болтол бууруулсан байна. Валютын ханшны уналт инфляцийг нэмэгдүүлсэн боловч, эдийн засгийн уналт эхэлсэнээр тэр нь тогтворжиж ирсэн юм.
- **Санхүүгийн салбарын бодлого.** Монголбанкны уламжлалт бус бодлогын хүрээнд олгосон зээл эрсдлээр огт жигнээгүй, их дүнтэй зээлийн эрсдэл болон салбарын төвлөрлийн лимит хязгаарт хамрагдалгүй явж ирсэн юм. Ерөнхийд нь авч үзвэл, хяналтын тогтолцоо зохистой байж чадсангүй, хязгаарлагдмал нөөц, зохих ёсны арга хэмжээ авахын оронд ойр ойрхон өршөөл үзүүлж, журмын мөрдүүлэлт ч сул байсан. 2013-14 онуудад зээл огцом өсч, дараа нь эдийн засгийн өсөлт саарснаас банкуудын активын чанар муудсан. Үүний зэрэгцээ, төгрөгийн ханш унаснаар ханшийн эрсдэлийн эсрэг ямар ч хамгаалатгүй зээлдэгчдэд голлон олгосон долларын зээлийн чанарт сөргөөр нөлөөлсөн байна.

4. **Манай Засгийн газар Монгол улсын эдийн засгийн асуудлыг даван туулах шийдвэрлэх сонгуулийн уриатайгаар УИХ-ын 76 суудлаас 65-ыг нь авсан хүчтэй олонхийн дэмжлэг хүлээсэн.** Бид засаглалыг сайжруулах, институциудыг бий болгох, эдийн засгаа эрүүлжүүлэхэд шаардлагатай хүнд, хэцүү арга хэмжээ авахад энэ хүчээ ашиглах санаа зориг дүүрэн байна. Ажлаа хүлээн авсны дараа тун удалгүй бид эдийн засгийг төрөлжүүлэх, тогтвортой өсөлтийн үндэс суурийг тавих зорилго бүхий нэн даруй тогтворжуулах арга хэмжээ, түүнчлэн бүтцийн шинэчлэл хийх "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-өө зарласан билээ. Үүнээс гадна, бид ОУВС зэрэг олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн бусад түншүүдээсээ идэвхтэй дэмжлэг хүссэн. Бодлогын тохируулга, бүтцийн шинэчлэл хэрэгжүүлснээр, мөн түүнчлэн гадаад дэмжлэгтэйгээр Монгол улс энэ хүнд хэцүү үеийг даван туулж, тогтвортой өсөлтийн замдаа эргэн орно гэдэгт бид итгэлтэй байна.

II. Эдийн засгийн сүүлийн үеийн байдал ба цаашдын төлөв

5. **Эдийн засгийн өсөлт эрс удааширч,** 2011 онд 17 хувь байсан бол 2016 онд 1 хувь хүртлээ унаж, ажилгүйдэл огцом өссөн байна. Өнгөрсөн жил, геологийн түр зуурын хүчин зүйлээс шалтгаалан Оюу Толгойн эхний үе шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан бол, харин дөрөвдүгээр улиралд экспорт огцом өсч, мөн БНХАУ-ын нүүрсний эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, түүхий эдийн үнэ сэргэснээр нүүрсний үйлдвэрлэл нэмэгдэж уул уурхайн салбарын нийт өсөлт эерэг түвшинд хадгалахад дэмжлэг боллоо. Засгийн газрын зарлага өндөр байсан, Оюу толгойн хоёр дахь үе шатны бүтээн байгуулалт эхэлсэн хэдий ч хөдөө аж ахуй, тээврийн салбарыг эс тооцвол, уул уурхайн бус салбаруудад олигтой өсөлт гарсангүй. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэл суларсан, тодорхой бус байдлын тусгал болсон юм. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хэрэглээ буурснаар төгрөгийн ханшны их хэмжээний уналтыг үл харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны сааралтаас шалтгаалан хэрэглээний үнийн инфляци бараг тэг хүртлээ буурсан байна.

6. **Эдийн засаг 2017 онд доод төвшиндөө хүрэх магадлалтай байна.** Оюу толгойн төслийн 1 дүгээр үе шатанд тохиосон геологийн хүчин зүйлсээс гадна төсвийн алдагдлыг бууруулах арга хэмжээ нь өсөлтөд жинтэй сөрөг нөлөө үзүүлж байгаа боловч, харин түүхий эдийн үнэ нэмэгдэж, нүүрсний үйлдвэрлэл төлөвлөсөн хэмжээнээс илүү өссөн, мөн Гацууртын алтны уурхай ирэх жилээс үйлдвэрлэлээ эхлүүлэх болсон нь эерэгээр нөлөөлж байна Оюу толгойн хоёр дахь үе шатны төслийн бүтээн байгуулалт ойрын хэдэн жилийн хугацаанд жил бүр ойролцоогоор 1 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт татах болно. Уул уурхайн бус салбарын өсөлт нь уул уурхайн томоохон хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуйн салбарт өсөн нэмэгдэж буй хүч чадлын эерэг нөлөөллөөр дэмжигдэнэ. Нийт өсөлт 2017 онд бага зэрэг сөрөг байх төлөвтэй байгаа боловч, Таван толгойн уурхайн хөрөнгө оруулалтын улмаас 2019 онд 8 хувиас давж хурдан сэргэх бөгөөд Оюу толгойн хоёр дахь үе шатны төслийн бүтээн байгуулалт эхэлснээр цаашид ч өндөр өсөлттэй байх төлөвтэй байна. Инфляци 2016 онд төгрөгийн ханшны уналтын тусгал болж 2017 он эцсээр 6 хувьд буцаж очих бөгөөд цаашид эдийн засаг хэвийн болоход 6½ хувь орчимд тогтворжих төлөвтэй байна.

7. **Монгол улсын гадаад орчин сул дорой хэвээр байгаа ч дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн сүүлийн үеийн сэргэлтийн улмаас нааштай хандлага гарч байна.** Экспорт нэмэгдэж эдийн засгийн удаашралаас импорт зогсонги байснаас өнгөрсөн жил худалдааны тэнцэл сайжирсан. Урсгал данс 2015 оноос хойш төгрөгийн гадаад валюттай харьцах ханшны уналтаас шалтгаалан сайжирсан боловч ДНБ-ний 4 хувийн алдагдалтай хэвээр байна. Өмнөх Засгийн газар 2016 онд дөрөвдүгээр сард хөрөнгийн зах зээлээс өндөр хүүтэй зээл авснаас шалтгаалан санхүүгийн хөрөнгийн урсгал нэмэгдсэн байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөллөөр, мөн своп шугамын ашиглалтын үр дүнд нийт тэнцэл 2016 онд тэгтэй ойрхон байсан бөгөөд нийт гадаад албан нөөц 1,3 тэрбум ам.доллар (3 сарын импорт)-ын хэмжээнд ерөнхийдөө тогтвортой байсан юм. Гэсэн хэдий ч гадаад секторын орчин дарамтанд хэвээр байна. Төгрөгийн ханш оны хоёр дахь хагаст 25 орчим хувиар суларсан, бас 2017-2018 онд нэлээд их дүн бүхий бондын төлбөр хийх хугацаа дөхөж байна.

8. **2016 онд төсвийн байдал эрс муудсан.** Орлого огцом буурч, хүүгийн төлбөр нэмэгдэж, өмнө нь хойшлогдож байсан хөрөнгийн зардлын төлбөрийг барагдуулсан, мөн сонгуулийн өмнөх зардал зэргээс шалтгаалан төсвийн алдагдал 2015 оны төвшингөөс хоёр илүү дахин нэмэгдэж, (ОУВС-гийн тодорхойлолтоор) ДНБ-ний 17 хувьд хүрсэн байна. Төсвийн энэ их хэмжээний алдагдал, төгрөгний ханшны уналттай хавсран улсын өрийн хэмжээг ДНБ-ний 84 хувь хүртэл өсгөсөн байна. Зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, эрсдэлийн талаарх зах зээлийн хүлээлт нэмэгдсэнээс шалтгаалан засгийн газрын богино хугацаат өрийн бичгийн хүү 2016 онд жилийн 17 хувь хүртлээ өслөө. Түүнчлэн, Монгол улсын зээлжих зэрэглэл буурч, гадаад зээллэгийн өртөг нэмэгдэж алдагдал дагаад өсөв.

9. **Эдийн засгийн байдал сул байснаас мөнгөний сектор дарамтад байв.** Зээлийн өсөлт сул хэвээр, зөвхөн хүүгийн татаастай зээлийн хөтөлбөрүүдийн хүрээнд олгогдож буй зээлээр л нөхцөлдөж байна. Эдгээр зээлүүд ч улам хумигдаж байна. Бодлогын хүүг хэд хэдэн удаа бууруулсны дараагаар Монголбанк наймдугаар сард 4.5 хувиар огцом нэмэгдүүлэн жилийн 15 хувьд хүргэж, валютын ханшийг сулруулж байсан илүүдэл мөнгийг татан авах зорилгоор төв банкны урт хугацааны үнэт цаасыг нэвтрүүлээ. Хэдийгээр инфляци өнгөрсөн жилийн эцэст бараг тэг болж, маш нам төвшинд байсан боловч эрсдэлтэй орчин хийгээд банкны салбарын бүтцээс шалтгаалан зээлийн хүү өндөр байсаар байна. Эдийн засаг идэвхигүй, нам инфляци зэргээс шалтгаалан арванхоёрдугаар сард бодлогын хүүг 1.0 хувиар бууруулсан байна. Монголбанк 2016 оны хоёрдугаар хагаст Засгийн газарт олгох зээлийг зогсоож, орон сууцны зээлийн санхүүжилтийг нэгэнт олгосон зээлийн үндсэн өрийн болон хүүгийн төлбөрт орж ирсэн дүнгээр хязгаарласан байна.

10. **Банкны салбар дарамтанд байна.** Эдийн засаг сул байгаагаас активын чанар буурч, чанаргүй зээлийн (бүтцийн өөрчлөлт хийсэн зээл болон хуучин зээлийн өрийг оролцуулахгүйгээр) харьцаа 7 хувьд хүртэл өссөн байна. Ялангуяа, гадаад валютын зээлийн хувьд чанаргүй зээлийн эзлэх хувийн жин хамгийн өндөр байгаа нь тэдгээрийн дийлэнхи нь ханшийн эрсдлийн хамгаалалтгүй байснаас болсон байна. Ийм их хувийн жин дарж буй чанаргүй зээлийн хувьд эрсдлийн сан хангалтгүй байснаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаанд дарамт учруулж байна. Бүтцийн өөрчлөлтөд хамруулсан зээлийн заримынх нь чанар тодорхойгүй байгаа юм.

III. 2017–2020 оны эдийн засаг, санхүүгийн бодлого

A. Тойм

11. **Макро эдийн засаг, санхүүгийн зохистой бодлого өргөн хүрээтэй бүтцийн шинэчлэлийн хамт хөтөлбөрийн гол цөм болно.** Доор дурьдсанчлан, бидний төлөвлөж байгаа төсвийн алдагдлыг эрчимтэй бууруулахын зэрэгцээ нийгмийн хамгааллыг бэхжүүлэн төсвийн сахилга батыг чангатгах шинэчлэлийн хэд хэдэн арга хэмжээ авна. Саяхан батлагдсан Хөгжлийн банкны тухай шинэ хууль бол энэ стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Мөнгөний бодлого зохих ёсоор хатуу байх болно. Үнийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах Төв банкны уламжлалт чиг үүрэгт анхаарлаа төвлөрүүлэн, сүүлийн жилүүдэд баримталж ирсэн зохисгүй бодлогоос зайлсхийн Монголбанкны засаглалыг бэхжүүлж, үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр Монголбанкны тухай хуулийг шинэчлэнэ. Түүхий эдээс хамааралтай эдийн засагт маань учрах цочролыг шингээгчийн хувьд валютын ханшийг уян хатан хэвээр байлгаж, гадаад валютын нөөцөө дахин бүрдүүлэх болно. Мөн банкуудын эрсдэл даван туулах чадварыг иж бүрнээр задлан шинжилж, үр дүнгээс нь хамааран банкуудыг дахин хөрөнгөжүүлж, бүтцийн өөрчлөлт хийнэ. Үүний зэрэгцээ, бид шаардлагатай бол, банкны засаглалыг бэхжүүлж, мөн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн зохицуулалт, хяналт шалгалт, дампуурлын асуудлыг сайжруулна. Эцэст нь, бид эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хэд хэдэн арга хэмжээ авч байна.

12. **Олон талт болон хоёр талын хөгжлийн түншүүдийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр манай эдгээр санаачлагын үр дүнд эдийн засаг тогтворжиж, тогтвортой, урт хугацааны өсөлтийн үндэс суурийг тавих юм.** Эдийн засаг тогтворжин, уул уурхайн төслүүд эдийн засгийн эргэлтэнд орсноор өсөлт 8 хувь хүртэл нэмэгдэх төлөвтэй байна. Уруудаж байсан валютын нөөцийн хэмжээ чиглэлээ өөрчилж, хөтөлбөрийн эцэс гэхэд, Монгол улс гадаад цочролд өртөхөөс өмнөх үеийн хэвийн төвшин буюу 2012 оны хэмжээнд өөрөөр хэлбэл 4 тэрбум орчим ам.доллар (6½ сарын импорт)-т хүрэх ёстой. Засгийн газрын өр 2019 оноос буурч эхлэн, 2022 он гэхэд (ОУВС-гийн тодорхойлолтоор болон өнөөгийн үнэ цэнийн хувьд) ДНБ-ний 74 хувь хүртэл буурна. Төсвийн алдагдлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр цаашид тодорхой хугацааны дараа төлөвлөсөн өсөлт гарч ирэхэд түүнтэй уялдан банкны салбарын хувийн хэвшилд олгох зээлийн хэмжээ ч нэмэгдэнэ.

В. Төсвийн бодлого

13. **Төсвийн алдагдлыг ихээхэн хэмжээгээр бууруулах нь нэн тэргүүний чухал зорилт юм.** Төсвийн бодлогын сахилга бат алдагдаж Засгийн газар, ХБ бөгөөд Монголбанк үндсэндээ зэрэгцээ төсөвтэй ажиллаж байснаас олон жилийн турш төсвийн хэт өндөр алдагдалтай явж ирсэн байна. Өнгөрсөн жил (ХБ-ны арилжааны зардлыг оролцуулан) төсвийн алдагдал ОУВС-ын тодорхойлолтоор ДНБ-ний 17 хувьд хүрсэн бөгөөд 2017 онд бид ДНБ-ний 10.6 хувь хүртэл бууруулах бодолтой байна. Энэ зорилтын хүрээнд төсөвт тодотгол хийж, үүнтэй уялдсан арга хэмжээг хамт батлах явдал **урьдчилсан нөхцөл** байх юм. Энэ бол зохицуулалт, тохируулгын томоохон зорилго юм. Гэхдээ бид хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Учир нь, 2016 оны гүйцэтгэл нэг удаагийн чанартай хэд хэдэн хүчин зүйлээс нэлээд хөөрөгдсөн тоо гарсан. Цаашид төсвийн алдагдлыг аажмаар бууруулж, 2022 он гэхэд ДНБ-ний 2 хувьд хүргэхээр төлөвлөж байна. (2018 оны төсвийг хөтөлбөрийн санхүүгийн зорилттой нийцүүлэн батлах нь бүтцийн бэнчмарк болох юм.) 2022 он гэхэд Оюу Толгойн төслийн 2 шатны үйлдвэрлэл нэмэгдэх бөгөөд энэ үеэс бид төсвийн тэнцлийг ашигтай гаргах зорилтод шилжих болно. Улсын өрийн төвшин их байгааг харгалзан, хөтөлбөрийн санхүүгийн хөшүүрэг нь үндсэн тэнцэл байх бөгөөд 2020 онд ашигтай гарах ёстой. Доор дурьдагдсан эн улсын өр дунд хугацааны зорилтот үзүүлэлт байх болно.

14. **Төсвийн алдагдлыг бууруулахын тулд төсвийн тодотголд өргөн хүрээний арга хэмжээ төлөвлөж байна. Үүний дотор хөтөлбөрийн хугацаанд ойролцоогоор ДНБ-ний 9 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг танахын тулд дараах санаачлагыг хэрэгжүүлнэ.**¹ Үүнд:

- **Хөрөнгийн зардал.** Өргөн уудам газар нутаг, хүн амын бага нягтрал нь хөрөнгө зарцуулалт их шаардлагатай гэсэн үг юм. Хөрөнгийн зардал нэлээд өндөр буюу сүүлийн гурван жилд дунджаар ДНБ-ний 12 хувь байгаа хэдий ч, энэ хүнд хэцүү үед Засгийн газрын ч, орон нутгийн төвшинд ч зардлыг зохистой болгох шаардлагатай байна.
- **Цалингийн сан.** Мөн 2018 оныг дуустал төрийн албан хаагчдын цалингийн өсөлтийг царцаан, зэрэг дэв нэмэх асуудлыг түр зогсоох, 2019 хүртэл төрийн албанд шинээр элсүүлэхгүй байх шийдвэр гаргахаар төлөвлөж байна. Энэ хязгаарлалтыг хэрэгжүүлэхдээ эрүүл мэнд, боловсрол, үнцгой байдал, цагдаа зэрэг тэргүүлэх салбарыг тусгайлан авч үзэж, эдгээр салбарт чөлөөлөгдөж буй хоёр орон тоон дээр нэг шинэ ажилтан авч байхаар төлөвлөж байна.
- **Тэтгэвэр.** Бид тэтгэвэрийг ихээхэн өгөөмөр болгосон сүүлийн арга хэмжээнүүдийг цуцалж, бас эрэгтэй, эмэгтэй гэж ялгаварлалгүй тэтгэвэрт гарах насыг жилд 6 сараар нэмэгдүүлсээр 65 нас хүртэл өсгөх болно.
- **Нийгмийн хамгаалалын зардал.** Манай хүн амын хамгийн эмзэг хэсэгт чиглэсэн тэргүүлэх ач холбогдол бүхий нийгмийн хамгаалалын зардлыг хамгаалах, илүү үр ашигтай болгох зорилт тавьж байна. Хөтөлбөрийн хугацаанд нийгмийн хамгааллын сүлжээг зохих ёсоор ажиллуулж, боловсрол, эрүүл мэндийн зардалд тэргүүлэх ач холбогдол өгөх болно. “Хүүхдийн мөнгө хөтөлбөр” зорилтот чиглэмжийг тодорхой бус хугацаагаар сунгаж, Монгол улсын нийт айл өрхийн хамгийн ядуу 40

¹ Өөрөөр заагаагүй бол бүх арга хэмжээ 2017 оноос хойш хүчин төгөлдөр болно.

хувьд чиглүүлэн, хамрагдаагүй үлдсэн хэсгийн дээд бүлгийн 40 хувийн хүүхдүүдэд 2019 оноос нөхөн олгох шийдвэрийг цуцална. Үүнээс үүссэн хэмнэлтийг Монгол улс хамгийн ядуу иргэдийг илүү сайн хамгаалахын тулд, зорилтог чиглэл бүхий хүнсний талоны хөтөлбөрийн зардлыг нэмэгдүүлэхэд бүхэлд нь ашиглах болно. Мөн нийгмийн шилжүүлгийн давхардсан олон хөтөлбөр (нийт тэтгэлгийн дундаж төвшнийг хадгалахын сацуу)-ийг нэгтгэснээр захиргааны зарим зардлыг хэмнэх юм.

- **Бусад зардал.** Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааны төвлөрсөн тогтолцоог нэвтрүүлэх замаар зардлын хэмнэлт бий болно. Үүний зэрэгцээ, 2017 төсөв батлагдсанаас хойш шинээр батлагдсан улсын төсөвт сөрөг үр нөлөө бүхий зарим хуулийг хүчингүй болгож буцаана.

15. **Мөн төсвийн тодотголын хамт (хөтөлбөрийн хугацаанд ДНБ-ний 2¼ хувьтай тэнцэх хэмжээгээр) орлого нэмэгдүүлэх дараахь арга хэмжээнүүдийг авна. Үүнд:**

- **Онцгой албан татвар болон гаалийн албан татвар.** Автобензин, дизелийн түлшний (2017 оны долдугаар сарын 1 болон 2017 оны аравдугаар сарын 1-ээс тус тус хэрэгжиж эхлэх байсан) онцгой албан татварыг сүүлийн хоёр удаагийн хөнгөлөлтийг цуцалж, газрын тосны бусад бүтээгдэхүүний татварын төвшинг оновчтой болгоно. Суудлын автомашин болон архи, тамхины онцгой албан татвар (2017 оны тавдугаар сарын 1 ба 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс тус тус) болон импортын тамхины гаалийн татварыг (2017 оны тавдугаар сарын 1-нээс) нэмэгдүүлэх болно.
- **Хүн амын орлогын албан татвар.** ХАОАТ өсөн нэмэгдэх шатлалтай дэглэмд шилжиж, илүү орлоготой хэсгээс татах татварын хувь нэмэгдсэнээр төсөвт (2018 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн) нэмэлт орлого төвлөрүүлж эхэлнэ.
- **Хадгаламжийн хүүгийн татвар.** Хадгаламжийн хүүгийн орлогын татвар ногдох босгыг үгүй болгосноор энэхүү татварыг хадгаламжийн хүүгийн орлогод бүхэлд ногдуулах болов.
- **Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 3 жилийн хугацаанд одоогийн хувь хэмжээ дээр нэмж нийтдээ 5 хувь хэмжээгээр (2018 онд 2 хувь, 2019 онд 1 хувь, мөн 2020 онд 2 хувь), ажил олгогч болон хувь хүн тус тусын хувь хэмжээг тус бүр 2.5 хувь хэмжээгээр нэмэгдүүлэх юм.**

16. **Хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй санхүүжилтийг авснаар өрийн тогтвортой байдлыг сэргээж байгаа юм.** Төсвийн дээр дурдсан зохицуулалт, тохируулга дангаараа улсын өрийг тогтвортой болгоход хангалтгүй юм. Учир нь төсвийн алдагдал буурч байгаа хэдий ч хэмжээ нь их байгаа учраас өр болон санхүүжилтийн нийт хэрэгцээг хангах хөнгөлөлттэй санхүүжилт шаардлагатай байгаа юм. ОУВС-гийн дэмжлэгтэй хөтөлбөрийн хүрээнд хоёр талын болон олон талт хөгжлийн түншүүдээс хүлээгдэж буй 3 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй дэмжлэг авснаар бид богино хугацаатай, өндөр хүүтэй дотоод зээлээс хамаарах хамаарлаа бууруулах боломжтой болно. Ингэснээр өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн түвшин 2019 оноос эхлэн буурч 2022 он гэхэд (ОУВС-гийн тодорхойлолтоор) ДНБ-ний 74 хувь хүртэл багасна гэж тооцоолж байна.

17. **Мөн өрийн тогтвортой байдлын шалгуурт нийцсэн нөхцөлөөр хувийн хэвшлийн гадаад, дотоод зээлдүүлэгчдийн оролцоог үргэлжлүүлэн хангахын тулд хүчин чармайлт гаргаж байна.** Гадаад өрийн хувьд өнгөрсөн сард бид гуравдугаар сард хугацаа нь дуусч байсан 580 сая ам.долларын өртөг бүхий Хөгжлийн банкны бондыг зах зээлийн таатай нөхцөл бүхий шинэ бондоор амжилттай сольж чадсан. Манай бондын захиалга маш эрэлттэй байсан бөгөөд, бид гурван жилээр анх төлөвлөж байсан хугацааг долоон жил болгож, боломжийн купонтой арилжсан бөгөөд, зах зээлийн ямар ч сөрөг үйлдэл гараагүй билээ. Зах зээлийн эерэг хариу үйлдлээс цаашид өрийн бусад бүтээгдэхүүнээрээ санхүүгийн зах зээлд буцаж гарах төлөвлөгөө бидэнд байна. Дотоод зах зээлийн хувьд хөтөлбөрийн хугацаанд өрийн тогтвортой байдлын шаардлагад нийцсэн нөхцөлөөр Засгийн газрын санхүүжилтийг үргэлжлүүлэх талаар зээлдүүлэгчидтэйгээ хамтран ажиллах болно. Макро эдийн засгийн төлөв, төсвийн нөхцөл байдал сайжирснаар хүү буурах төлөвтэй байгаа бөгөөд өнөөдөр зонхилж байгаагаас ч нэлээд доогуур үнээр Засгийн газар санхүүжүүлтийн хэрэгцээгээ хангах чадвартай болох боломж бүрдэнэ гэж үзэж байна.

18. **Мөн бид өнгөрсөн бодлогын алдааг давталгүй, төсвийн сахилга батыг хангах үүднээс төсвийн бүтцийн шинэчлэлийн томоохон хөтөлбөр боловсруулсан юм. Үүнд:**

- **Хөгжлийн банкны тухай хууль.** Хөгжлийн банкны тухай шинэ хуулийг баталснаар түүний хараат бус байдлыг бэхжүүлж, зөвхөн цэвэр арилжааны шинжтэй үйл ажиллагаа явуулахаар хязгаарлаж өгсөн билээ. Хуульд дараах гол хамгаалалтын чанартай заалтуудыг суулгаж өгсөн юм. Үүнд: цаашид Засгийн газар, УИХ-ын аль аль нь ерөнхий тэргүүлэх чиглэлийг зааж өгөхөөс өөрөөр төсөл сонгон шалгаруулахад оролцохгүй; төслүүдийг эдийн засгийн үр ашгийн шалгуураар л сонгоно; МУХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сүүлийн жилүүдэд улс төрийн албан тушаалд ажиллаагүй хүмүүсээс оруулж ажиллуулна; дээд төвшиний удирдлагыг нь олон улсын, өрсөлдөөнт үйл явцаар сонгон шалгаруулна; мөн МУХБ-ны үйл ажиллагаанд Монголбанк хяналт шалгалт тавих болсон юм. Эдгээр заалтуудад суурьлан, бид Хөгжлийн банк өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ирсэнээс маш их ялгаатай үйл ажиллагаа явуулна гэсэн хүлээлтэй байгаа боловч нэг хэсэгтээ хашир хандаж төсвийн алдагдалд Хөгжлийн банкны санхүүжилтийг оруулж тоохон хянаж байх бодолтой байна. Цаашид магадгүй дараах нөхцөл хангагдсан гэж үзвэл төсвийн хяналтаас Хөгжлийн банкныг хасах асуудлыг авч үзэж болох юм. Үүнд: (i) тус банк хамгийн багадаа нэг жилийн туршид цэвэр арилжааны байдлаар үйл ажиллагаа эрхэлсэн түүхтэй болох; (ii) гуравдагч этгээдийн аудитаар аль төслүүд үнэхээр арилжааны шинжтэй байгааг тодорхойлуулж, үлдсэн бүгдийг нь Засгийн газарт шилжүүлэх; болон (iii) Засгийн газрын санхүүжилт, баталгаанаас хамаарах хамаарлаа мэдэгдэхүйц хэмжээнд хүртэл бууруулна (ингэснээр байгууллагынхаа хараат бус байдлыг бий болгоход дэмжлэг болно). МУХБ эдгээр бүх шалгуурыг ханган төсвийн зорилтот үзүүлэлтүүдээс хасагдсан тохиолдолд, МУХБ тэнцлийн тусгай зорилтот үзүүлэлт ашиглах болно.
- **Орон сууцны зээлийн хөтөлбөр.** Бид хэдийнэ энэ хөтөлбөрийн санхүүжилтийг Монголбанкны цэвэр санхүүжилтаар хязгаарлаж, мөн Монголбанкнаас сүүлийн үед хэрэгжүүлж байсан төсвийн шинжтэй өөр бусад хөтөлбөр (жишээ нь, компаниудад зээл олгох гм)-ийг зогсоосон билээ. Орон сууцны шинэ зээлийг зөвхөн өмнө олгосон зээлийн үндсэн өрийн болон хүүгийн төлбөрийн орлогоор л эргүүлэн санхүүжүүлж байгаа (*урьдчилсан арга хэмжээ*) юм. Түүнээс гадна, 2017 оны төсвийн тодотголоос эхлэн, зээлийн хүүгийн орлогоор санхүүжигдсэн орон сууцны зээлийн хэмжээг төсвийн хүснэгтийн Засгийн газрын цэвэр зээл ангилалд бүртгэж ил тод тусгах болсон. Монголбанк зөвхөн Засгийн газрын зуучлагч байдлаар орон сууцны хөтөлбөрт оролцоно гэсэн мэдэгдлийг тусгасан Харилцан ойлголцлын санамж бичигт Засгийн газар, Монголбанкны хооронд гарын үсэг зурна. Бид ирэх жилээс хөтөлбөрийг засгийн газрын мэдэлд шилжүүлэх бодолтой байгаа бөгөөд үүнийг хэрхэн хийх тухайд Дэлхийн банкны дэмжлэгтэй шинжээч хөлслөөд ажиллуулж байна. Сангийн яам хөтөлбөрийг санхүүжилтийг нэмэгдүүлэх сонголт хийж болох ч, төсвийнхөө хаа нэгтээ үүнтэй дүйцэх хэмжээний хэмнэлт гаргах хэрэгтэй болно. Цаашдаа бид орон сууцны хөтөлбөрийг цэвэр хувийн хэвшлийнхэнд хүлээлгэн өгөх бодолтой байна. Энэ тохиолдолд хөтөлбөрийн хүрээнд гаргасан аливаа Засгийн газрын баталгаа, эсвэл олгосон татаас нь төсөвт ил тодоор тусгагдах ёстой болно.
- **“Нэмбэл хас”.** Одоогийн УИХ төсвийн алдагдлыг бууруулах асуудал дээр хатуу байр суурьтай байгаа боловч, Монголын түүхэндээ үргэлж ийм байж чадаагүй юм. Хэрэг дээрээ, сүүлийн жилүүдэд УИХ дээр нэгдсэн төсвийн тэнцлийг сулруулсан хэд хэдэн жишээ байна. Нэгдсэн төсвийн тухай болон холбогдох бусад хуульд 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд нэмэлт өөрчлөлт оруулснаар 2018 оноос эхлэн УИХ-ын хэлэлцүүлгийн үеэр гишүүд төсвийн нийт зарлагын дүнг нэмэгдүүлдэг эрх мэдлийг хязгаарлан, аливаа санал, санаачилга гаргасан тохиолдолд харгалзах үнийн дүн бүхий өөр зардлыг бууруулах замаар зардлын хязгаарыг өсгөхгүй байх зарчмыг баримлах юм (*бүтцийн бэнчмарк үзүүлэлт*).
- **Төсвийн тодотгол.** Ямар нэгэн шинэ төсөл, хөтөлбөрт зардал гаргахаас өмнө төсвийн тодотголоор батлуулж байх ёстой гэсэн Нэгдсэн төсвийн тухай хуулийн урд өмнөх зарим тохиолдолд хэрэгсэхгүй явж ирсэн заалтыг хатуу чанга мөрдөнө.
- **Сангийн яамны бүрэн эрх.** Их хэмжээний санхүүгийн үр дагавар бүхий санал, төсөл, хөтөлбөрийг Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэхийн өмнө Сангийн яамнаас урьдчилан зөвшөөрөл авдаг болох тухай Засгийн газрын тогтоол шинээр гаргаж хэрэгжүүлнэ.

- **Хариуцлагын тогтолцоо.** Манай шинэ Засгийн газар төсвийн тухай хуулийн зөрчилд сайд, дээд шатны удирдах албан тушаалтнуудад хувийн хариуцлага тооцох тухай эдгээр хуулийн заалтыг чанд баримталж ажиллахаар төлөвлөж байна.
- **Төсвийн зөвлөл.** Ерөнхий сайд, Сангийн сайд, болон Монголбанк ерөнхийлөгч, нэр хүнд бүхий бусад хүмүүсээс бүрдсэн Төсвийн хараат бус зөвлөлийг 2017 оны 12 дугаар сарын эцэс гэхэд тусгай хуулийн дагуу байгуулна (*бүтцийн бэнчмарк үзүүлэлт*). Энэ бол нам бус зөвлөл байна. Төсвийн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээхгүй ч, УИХ-ын гишүүдийн бодлогын саналд хараат бус төсвийн урьдчилсан таамаглал, тооцоо боловсруулах, төсвийн хязгаарыг давахын тулд төсвийн гадуурх хэрэгсэл ашиглаж байгаа эсэхэд хяналт тавихыг зорьж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хяналт шинжилгээ хийнэ. Олон улсын туршлагаас харахад ийм байгууллага төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах боломжтой гэдгийг харуулж байна. Үүний зэрэгцээ Үндэсний аудитын газрыг цаашид бэхжүүлэх хүчин чармайлт гаргаж ажиллана.
- **Төр-хувийн хэвшлийн түншлэл / концесси.** Сүүлийн жилүүдэд, концессийн гэрээг ямар нэгэн төвлөрсөн хяналтгүй засгийн газрын янз бүрийн нэгжүүд олноор хийсэн байна. Бид концессийн төсөл санаачлах орон нутгийн засаг захиргааны эрхийг аль хэдийн хязгаарласан бөгөөд төр-хувийн хэвшлийн түншлэлийн бүхий л төслийн хувьд хянагчийн үүргийг Сангийн яаманд хариуцуулах санаатай байна. Эдгээр гэрээтэй холбоотой ямар нэгэн нэмэлт төлбөр хийхийн өмнө одоо үйлчилж байгаа бүх концессийн гэрээний аудит хийх бодолтой байна. Түүнчлэн, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр үйлчилж байгаа хууль эрх зүйн орчныг олон улсын шилдэг туршлагаар шинэчилнэ. Эдгээр хууль, тогтмолжид нэмэлт өөрчлөлт оруулах хүртэл бид (магадгүй зарим нэг шинэ барих-ашиглах-шилжүүлэх төслийг эс тооцвол, мөн зарим барих-шилжүүлэх гэрээг бид барих-ашиглах-шилжүүлэх төсөл болгон хувиргаж болох юм) ямар ч шинэ концессийн гэрээ байгуулахгүй. Цаашилбал, бид одоогоор эхлээгүй байгаа төслийн гэрээг цуцлах талаар хүчин чармайлт гаргах болно.
- **Улсын төсвийн хөрөнгө оруулалт.** Монгол улсын төсөл сонгон шалгаруулах шалгуур, сонгогдсон төслүүдийн хэрэгжилтийн талаар ноцтой асуудлууд гарч байна. Саяхан хийгдсэн улсын хөрөнгө оруулалтын менежментийн үнэлгээ (PIMA)-гээр нарийвчилсан оношилгоо хийж, тодорхой санал зөвлөмж ч гарсан. Бид нэмүү өртөг багатай төслүүдийг хязгаарлах замаар УТХО-ыг оновчтой төлөвлөж, яваандаа Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр, хөрөнгө оруулалтын хөтөлбөр үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй бүрэн нийцэж байх явдлыг хангах зорилгоор үйл ажиллагаагаа сайжруулахыг зорьж байна.
- **Ирээдүйн өв сан.** Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны нэгдүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон боловч бодит хуритлал хоёр жил орчмоор хойшлох учраас шилжилтийн үеийн зүйл заалтыг баталсан юм. Бидний үзэж байгаагаар, энэ хууль хэмнэлт, хуримтлалын ач холбогдлыг тодруулж өгөхийн зэрэгцээгээр, хуримтлал үүсгэх боломжгүй төсвийн алдагдал өндөр байгаа үед хэмнэлт гаргах шаардлага тавихгүй хангалттай уян хатан байх ёстой. Ирээдүйн өв сангийн 2022 он хүртэлх орлогыг бүхэлд нь засгийн газрын өрийн төлбөр гүйцэтгэхэд ашиглах бөгөөд Хүний хөгжлийн сангийн зарлагыг (жишээ нь, Хүүхдийн мөнгө хөтөлбөр) улсын төсвийн дансанд саадгүй шилжүүлэх болно.
- **Хугацаа хэтэрсэн өр төлбөр.** Цаашид хугацаа хэтэрсэн өр төлбөр үүсч хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд бид хяналт, үнэлгээнийхээ тогтолцоог чадавхижуулах үүрэг амлалт авч байна.

19. Монгол улсын татварын системийг бэхжүүлэх хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- **Татварын тогтолцоог үнэлэх ажлын хэсэг.** ОУВС-гаас техникийн туслалцаагаар 2017 оны 8 дугаар сард багтаан (НӨАТ, аж ахуйн үйл ажиллагааны, ялангуяа уул уурхайн татвар) татварын бүтэцд дүн шинжилгээ хийх хараат бус шинжээчдийн ажлын хэсэг байгуулж, татварын тэгш байдал, үр ашгийг сайжруулах үүднээс орлогын хувьд төвийг сахисан, эсхүл орлого нэмэгдүүлэх зөвлөмж гаргуулах болно (бүтцийн бенчмарк). Ажлын хэсэг 2017 оны 12 дугаар сарын эцэс гэхэд тайлангаа гаргаж өгнө (бүтцийн бенчмарк).

- **Татварын зардал.** Дэлхийн банкны техник туслалцааны дэмжлэгтэйгээр одоо байгаа татварын зардалд дүн шинжилгээ хийж, дараагийн төсөвт эдгээр зардлын хуваарилалтыг бууруулна.
- **Орлогын удирдлага.** ОУВС, АНУ-ын Төрийн сангийн идэвхитэй дэмжлэгтэйгээр бид сүүлийн хэдэн жилийн турш орлогын удирдлагын тогтолцоог бэхжүүлсээр ирсэн. Энэхүү ажил үргэлжилж байгаа бөгөөд одоо жижиг бизнест зориулсан хялбаршуулсан татварын асуудалд анхаарлаа хандуулж байна. Янз бүрийн хэмжээний бизнесийн хувьд дагаж мөрдөх стратегийг 2017 оны 4 дүгээр сарын эцэс гэхэд бид дуусч, хэрэгжүүлж эхэлнэ (*бүтцийн бэнчмарк*). Үүний зэрэгцээ, аравдугаар сарын эцэс гэхэд бид шинэчилсэн Татварын ерөнхий хуулийг УИХ-д өргөн барина (*бүтцийн бэнчмарк*). Эцэст нь, 2017 он гэхэд 10-дугаар сарын эцэс гэхэд ОУВС-гийн техник туслалцааны төслийн зөвлөмж ёсоор бичил бизнес эрхлэгчдэд зориулсан хялбаршуулсан татварын тогтолцоо бий болгох хууль тогтоомжыг өргөн барих юм (*бүтцийн бэнчмарк*).
- **Автомат дахин үнэлгээ.** Төгрөгөөр ногдуулах тогтмол торгууль, хураамж, тэмдэгтийн хураамж, аливаа бусад орлогыг 2019 оноос эхлэн инфляцитай уялдуулан жил бүр автоматаар дахин үнэлэх тогтолцоог хангах болно.

20. **Нийгмийн хамгааллыг илүү үр ашигтай, үр дүнтэй болгоно.** Дээр дурьдсанчлан, “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг илүү зорилтот шинжтэй болгон хэмнэлтийг нь хүнсний талоны санхүүжилтийг нэмэгдүүлэхэд ашиглах (*бүтцийн бэнчмарк*) бөгөөд бусад хөтөлбөрүүдийг ч оновчтой болгоно. Тэтгэврийн параметрын шинэчлэл зэрэг хэд хэдэн өөр бусад санаачилгыг хэрэгжүүлнэ. Эдгээрийн тухайд Дэлхийн банкны хөгжлийн бодлогын зээл болон АХБ-ны бодлогод суурилсан зээлийн материалд дэлгэрэнгүй тайлбарласан болно.

С. Мөнгөний болон валютын ханшны бодлого

21. **Мөнгөний бодлого үнийн тогтвортой байдлыг хангах үүднээс зохих ёсоор хатуу хэвээр байх болно.** Монголбанк эдийн засгийн суурь үзүүлэлтээс хамааруулан 2017 онд мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлнэ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр эдийн засаг хэвийн байдалд ороход одоогийн жилийн 2 ½ хувийн инфляцитай байгаа нөхцөлд төлбөрийн тэнцэл, инфляцийн үзүүлэлт зорилтот төвшиндөө байвал жилийн 14 хувьтай байгаа бодлогын хүүгээ Монголбанк бууруулах асуудлыг авч үзэж болох юм. Төсвийн алдагдал их байгаа, их хэмжээний гадаад санхүүжилт бөөн бөөнөөр орж ирэх магадлалтай байгаа учраас нөөц мөнгөний хэмжээг хөтөлбөрт заасан хязгаарт барьж байх явдал бэлэн мөнгөний нягт няхуур удирдлагыг шаардах бөгөөд Монголбанк болон Сангийн яамны хооронд нягт уялдаатай хамтран ажиллах шаардлагатай болох байх.

22. **Монголбанкны тухай шинэ хууль батлах нь тэргүүлэх чиглэл мөн** (*бүтцийн бэнчмарк*: 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд өргөн мэдүүлж, 2018 оны гуравдугаар сарын эцэс гэхэд баталсан байх). Хууль хэрэгжсэнээр Монголбанкны бүрэн эрхийг тодорхой болгон засаглалыг нь бэхжүүлж, хараат бус байдлыг нь сайжруулна. Мөнгөний бодлогын зөвлөлийн эрх мэдлийг дээшлүүлж, Зөвлөлийн гишүүд бодлогын шийдвэрт санал өгөх эрхтэй болно. Үүний нэгэн адил, хяналтын зөвлөлийн шийдвэр ч хамтын шийдвэр байх болно. Шийдвэр гаргах этгээдүүд аливаа нэг банк болон нийт банкны системийн нөхцөл байдлыг хянаж, хэлэлцэх, шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын шийдвэр гаргах бөгөөд тогтмол хуралдаж байх юм. Монголбанкныг орчин үеийн болгон шинэчилж, дахин зохион байгуулах бөгөөд хүний нөөц, мэдээллийн технологийн хувьд сайжруулах талаар анхаарахын зэрэгцээ засаглалыг нь бэхжүүлэх юм. Цаашилбал, бид жил бүрийн хөндлөнгийн аудит хийлгэх үүргээ ухамсарлан ажиллана.

23. **Монголбанкны дүрмийн сан сөрөг утгатай болсон тул шат дараатай шийдэх стратеги боловсруулна.** Энэ байдал Монголбанкны үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар хязгаарлалгүй олон жилийн турш ужиг үргэлжилсэн хэдий ч, Монголбанкны хувьд хүчтэй, хараат бус үйл ажиллагаатай бие даасан байгууллагынх нь хувьд хамгаалах үүднээс засч залруулах шаардлагатай байна. Улсын өр аль хэдийн их байгааг харгалзан энэ чиглэлээр дэс дараатай арга хэмжээ авах хэрэгтэй.

24. **Интервенцийг зөвхөн ханшны хэт их хэлбэлзлэлийг тэгшитгэх, зах зээлийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхээр хязгаарлах бөгөөд валютын ханшийг уян хатан хөдөлгөөнт байдлыг хэвээр хадгална.** Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ёсоор төлбөрийн тэнцэл ашигтай гаргах хийгээд валютын цэвэр нөөцийн зорилтот үзүүлэлтүүдийг хангахтай уялдуулан Монголбанк гадаад нөөцөө хуримтлуулна. Хөтөлбөр дуусгавар болох үед нийт гадаад нөөц Монгол улс гадаад шокд нэрвэгдэхээс өмнөх үеийн төвшин буюу 2012 оны төвшинд, өөрөөр хэлбэл 6½ сарын импорттой тэнцэх хэмжээнд хүрэх болно.

25. **Бусад.** Хөтөлбөрийн явцад бид дараах арга хэмжээнээс зайлсхийх болно. Үүнд: гадаад гүйлгээний хууль ёсны урсгал төлбөр болон шилжүүлэг хийхэд шинээр хязгаарлалт тавих эсвэл мөрдөж байгаа хязгаарлалтыг чангатгах; олон валютаар гүйлгээ хийх практик нэвтрүүлэх эсвэл өөрчлөх; ОУВС-гийн дүрмийн VIII зүйлд үл нийцэх хоёр талын төлбөрийн гэрээ байгуулах; эсвэл төлбөрийн тэнцлийн шалтгаанаар импортын квотын хязгаарлалт ногдуулах, эрчимжүүлэх зэрэг арга хэмжээ авахгүй болохоо батлан илэрхийлж байна.

D. Санхүүгийн салбарын бодлого

26. **Манай санхүүгийн систем найдвартай, тогтвортой ажиллаж, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулах нөхцлийг тууштай хангах явдал бол бидний зорилт мөн.** Эхний ээлжинд байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, эрсдэл даван туулах чадварыг үнэлэх үүднээс банкны системийн иж бүрэн оношилгоо хийх нь тэргүүн зэргийн зорилт болж байна. Энэхүү оношилгооны үр дүнгээр банкны бүтцийн өөрчлөлт, дахин хөрөнгөжүүлэх үйл явцыг эхлүүлэх бөгөөд шаардлагатай бол амьдрах чадваргүй банкуудыг цаг тухайд нь аливаа эрсдэл үүсгэхгүйгээр шийдвэрлэх болно. Эдгээр арга хэмжээг авахын зэрэгцээ банкны дүрэм журмуудыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлж, банкны хяналт шалгалтыг бэхжүүлэн хяналт-шинжилгээ, банкны хөрвөх чадварыг дэмжих дэмжлэгийг сайжруулах замаар иж бүрэн илүү цогц шинжтэй болгоно. Бид мөн чанаргүй зээлийн хувьд үр дүнтэй бүтцийн өөрчлөлт хийж, асуудлыг шуурхай шийддэг болох чиглэлээр тогтолцоогоо сайжруулах бодолтой байна. Эцэст нь, бид Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо бэхжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ тал дээр АХБ, Ази Номхон далайн бүлэг, ОУВС болон Дэлхийн банк зэрэг манай олон талт түншүүд зохих туслалцаа үзүүлж байна.

Санхүүгийн эрсдэл даван туулах чадвар /financial resilience/-ын үнэлгээ

27. **Банкны системийн иж бүрэн оношилгоо хийнэ.** Манай банкуудын санхүүгийн эрсдэл даван туулах чадвар, санхүүгийн түвшин, амьдрах чадварыг үнэлэх зорилгоор бид Монгол улсын бүх 14 банкинд дараах шаардлага тавих болно. Үүнд: (i) активын хараат бус үнэлгээ (Активын чанарын үнэлгээ, АЧҮ) хийлгэх; (ii) санхүүгийн түвшинг харуулсан 2019 оныг дуусталх хугацаанд хэрэгжүүлэх бизнесийн төлөвлөгөө, үүний дотор шаардлагатай бүтцийн өөрчлөлтийн болон дахин хөрөнгөжүүлэлтийн аливаа нөлөөллийг тусгасан байхыг шаардана. АЧҮ болон бизнес төлөвлөгөөний хяналтын бүх үйл явцыг 2017 оны 12 дугаар сарын оны эцэс гэхэд дуусгавар болгохоор төлөвлөж байна. Энэхүү үйл явцыг дэлгэрүүлбэл:

- Монголбанк нийцлийг хангах, нийт үйл явцын зорилго, арга замыг ханган хэрэгжүүлэх үүднээс банк тус бүрт хийх оношилгооны ажлын явцыг хянах Удирдах хороог томилж ажиллуулна. ОУВС ажилтнууд бүх үйл явцад ажиглагчаар ажиллах болно.
- Монголбанк, ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр ажлын даалгаврыг нь боловсруулсан активын чанарын үнэлгээ хийх хараат бус, олон улсын нэр хүнд бүхий шинжээч компани (үүд)-ийг хөлслөх худалдан авах ажиллагааны журмаа 2017оны гуравдугаар сарын 31-ний өдөр танилцуулсан (***урьдчилсан арга хэмжээ***). Ажлын даалгаврын шаардлага ёсоор сонгон шалгаруулах аудитын компани нь сүүлийн хоёр жилийн хугацаанд тухайн банктай ямар нэгэн гэрээ байгуулсан ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой гэж онцлон зааж өгсөн байгаа. Активын чанарын үнэлгээ (АЧҮ)-г 2017 оны 10 дугаар сарын эцэс гэхэд хийж, дуусгавар болгоно.

- Активын чанарын үнэлгээн дээрээ суурилан банкууд бизнес төлөвлөгөөгөө 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд Монголбанкинд гаргаж өгөх шаардлагатай. Бизнес төлөвлөгөөг ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр боловсруулсан шаардлага, үйл ажиллагааны үе шатны дагуу бэлтгэх ба санхүүгийн нарийвчилсан тооцоо болон 2019 он хүртэл хугацаанд шаардагдах дүрмийн сангийн нэмэлт хөрөнгийн тооцоо гаргах ёстой бөгөөд Монголбанк, ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр тэдгээр бизнес төлөвлөгөөг нь стресс тестийн загвараараа үнэлж, баталгаажуулна. АЧҮ-ний үр дүн болон бизнес төлөвлөгөөг ашиглан банкууд, 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлт болон ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр тодорхойлсон өөрийн хөрөнгийн ерөнхий зорилтот үзүүлэлтийн аль алиныг нь хангаж байгаа эсэхийг 2016 оны эцсээс 2019 оны эцэс хүртэлх хугацаанд үнэлэх боломжтой болно.
- Монголбанк нь банкуудын бизнес төлөвлөгөөний талаар шийдвэр гаргах бөгөөд хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор, өөрөөр хэлбэл, 2017 оны 12 дугаар сарын эцэс гэхэд тэдэнтэй эргэж холбогдоно. АЧҮ-ээр өөрийн хөрөнгийн “хангалттай” үнэлгээ авсан, бизнес төлөвлөгөө нь 2019 он хүртэлх хугацаанд хангалттай үр ашиг бүхий бизнес болон хөрөнгөжилтийг нотолж чадахаар байгаа нөхцөлд ямар ч нэмэлт арга хэмжээ шаардлагагүй болно. Оношилгооны судалгаагаар өөрийн хөрөнгийн дутагдал илэрсэн эсвэл бизнесийн загвар нь үр ашиггүй болох нь илрэх юм бол тухайн банкнаас дахин хөрөнгөжүүлэх болон бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө гаргаж өгөхийг шаардана. Эдгээр төлөвлөгөөнд үнэлгээний үр дүнгээр илэрсэн дутагдлыг шийдэхийн зэрэгцээ өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх, мөн урт хугацааны ашигт ажиллагааг хангахын тулд, бас мөн бизнесийн үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлтийг тууштай хийх тодорхой арга хэмжээг тусгасан байвал зохино.

Банкны дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлтийн процесс

28. **Банкны өөрийн хөрөнгө бүрэн дүүрэн хүрэлцээтэй, ашигтай ажиллах, сайн удирдлагатай байж, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах боломжийг хангах үүргийг банкны хувьцаа эзэмшигчид хүлээх учиртай.** Өөрийн хөрөнгө дутагдаж байгаа бол тохиролцсон бизнес төлөвлөгөөний дагуу асуудалд орсон тухайн байгууллага өөрийн хөрөнгийн хүрэлцээний болон санхүүгийн бусад шалгуурыг хангах хугацаатай, хянах боломжтой үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж өгнө. Эдгээр хугацаат үүргийн биелэлтийг Монголбанк хянан үзэж, шаардлагатай өөрчлөлтийг улирал тутам тохирч ажиллана. Хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө, эсвэл цөөнхийн буюу дийлэнх хувь эзэмшигчээр магадгүй гадаад хөрөнгө оруулагчийг оролцуулан шаардлага хангасан шинэ хувь нийлүүлэгчдийг авчрах замаар 2018 оны зургадугаар сар гэхэд байгууллага бүрэн хөрөнгөжүүлсэн байх шаардлагатай. Бид, банкны дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлтийн үйл явцаар хангалттай нөөц сан бий болгож, санхүүгийн тогтвортой байдлыг хангах болно.

29. **Банкны хувьцаа эзэмшигчид банкаа бүрэн дахин хөрөнгөжүүлж чадахгүй бол санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд дэс дараалсан бүтцийн өөрчлөлтийг дэмжих үүднээс төсвийн хөрөнгийг хатуу шалгуурын дор ашиглаж болно.** Төсвийн аливаа эх үүсвэр ашиглахын өмнө дараах шалгуурыг хангасан байна. Үүнд: АЧҮ-гээр тодорхойлсон аливаа алдагдлыг одоогийн хувьцаа эзэмшигчид хаасан байх; банкны урт хугацааны амьдрах чадварыг хангахын тулд бүтцийн өөрчлөлт хийсэн байх; удирдлагын зохих өөрчлөлт хийсэн байх; бөгөөд төсвийн хөрөнгийг зөвхөн олон нийтийн ашиг сонирхлын үүднээс санхүүгийн тогтвортой байдлыг хангахад л зарцуулах болно. Эдгээр шалгуур яг ямар байх ёстойн тухайд бид 2017 оны аравдугаар сарын эцэс гэхэд ОУВС-гийн ажилтнуудтай харилцан ойлголтонд хүрч, 2017 оны 12 дугаар сарын эцэс гэхэд хууль, тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийнэ (**бүтцийн бэнчмарк**). Санхүүгийн ийм дэмжлэг үзүүлэхийн тулд Засгийн газар, ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр боловсруулсан хатуу журмын дагуу холбогдох төсвийг батлуулах болно. Ихэнх тохиолдолд, үүнийг санхүүгийн хөрөнгийн солилцоо хэлбэрээр төсвийн санхүүжилт хэсэгт тусад нь харуулах нь зүйтэй гэж үзэж байна, гэвч үүнийг тухайн үед нь тодорхойлно. Банкны салбар дахь төрийн одоогийн болон болзошгүй оролцоог бууруулах стратегийн баримт бичгийг 2018 оны есдүгээр сарын төгсгөл гэхэд бид боловсруулна.

30. **Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) банкны дахин хөрөнгөжүүлэлт, бүтцийн өөрчлөлтөд зориулах төсвийн хөрөнгийн ашиглалтын хувьд зохистой засаглалыг хангаж ажиллана.** Зах зээл, болон хадгаламж эзэмшигчдийг цаг тухайд нь мэдээллээр хангах үүднээс Монгол улсын Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-ийг тус зөвлөлд гишүүнээр оруулж зөвлөлийг томсгож, дахин хөрөнгөжүүлэх үйл явцын олон нийтийн харилцааны стратегийн асуудал эрхэлсэн хэвлэлийн төлөөлөгчийг нэн даруй томилж ажиллуулна. Олон нийттэй харилцах стратегийг ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр боловсруулна.

31. **ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр бүтцийн өөрчлөлт хийсэн банкууд дахь төрийн өмчийн оролцоог хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдийг 2017 оны 12 сарын эцсээр байгуулна.** Уг хуулийн этгээд банкууд дахь Засгийг газрын хувь нийлүүлсэн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх чиг үүрэгтэй бөгөөд тухайн банкуудтай цэвэр арилжааны үндсэн дээр хараат бус зарчмаар харилцах болно. Энэхүү мэргэшсэн байгууллагын гишүүд, банкны ТУЗ дахь төрийн төлөөллийн гишүүд, банкны удирдлага өндөр ёс суртахуунтай, хараат бус, мэргэжлийн шаардлага хангасан эсэхийг, мөн төрийг төлөөлсөн хувьцаа эзэмшигчийн хувьд гаргасан гол шийдвэртээ хариуцлага хүлээдэг байх болно. Банкуудын арилжааны бизнест улс төрийн аливааг оролцоог хязгаарлахын тулд төрийн өмчийн менежмент хийх энэхүү мэргэшсэн байгууллага болон төрийн оролцоотой банк тус бүрийн хооронд хоёр талын харилцааг зохицуулах гэрээнд гарын үсэг зурна.

32. **Төлбөрийн болон санхүүгийн чадваргүй банкуудыг санхүүгийн системээс гаргахдаа хадгаламж эзэмшигчдийн итгэл, санхүүгийн тогтвортой байдлыг ханган эдийн засгийн хамгийн бага өртгөөр хийнэ.** Банкны бүтцийн өөрчлөлтийн тухай хууль тогтоомж хийгээд хамтран ажиллах тогтолцоог бид 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр олон улсын шилдэг стандартад хүргэнэ (*бүтцийн бэнчмарк*). Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар банкинд бүтцийн өөрчлөлтийн иж бүрэн арга хэрэгслээр Монголбанкыг хангах бөгөөд хяналт шалгалтын газрын боловсон хүчнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Хадгаламжийн даатгагчдын олон улсын нийгэмлэгийн “Хадгаламжийн даатгалын тогтолцооны үндсэн зарчим”-д нийцэх нийцлийг хангах үүднээс 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд ХДК-ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна (*бүтцийн бэнчмарк*). ХДК даатгуулагч хадгаламж эзэмшигчдийн болзошгүй хохирлыг барагдуулахад шаардлагатай үүргийн биелэлтийг хангах эх үүсвэрийг гаргах нөөц төлөвлөгөөг 2017 оны 4 дүгээр сарын эцэс гэхэд боловсруулсан байна. Шаардлагатай бол хадгаламжийн төлбөр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангахын тулд Монголбанкт хийх мэдээллийн солилцоог эрчимжүүлэх замаар 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд ХДК-ийн үйл ажиллагааг сайжирна. Банкуудыг эдийн засгийн хамгийн бага зардлаар үр ашигтай, цаг тухайд нь бүтцийн өөрчлөлт хийх явдлыг Монголбанк хариуцна.

Хууль, эрх зүйн болон хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах

33. Банкны системд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулахын тулд дараах арга хэмжээ авна. Үүнд:

- **Активын ангилал, зээлийн эрсдлийн сан байгуулах болон барьцаа хөрөнгийн үнэлгээний талаарх СТОУС-ын нягтлан бодох бүртгэлийн болон олон улсын стандартын хэрэгжилтийг болгоомжтой байдлаар хангах.** Үүнтэй холбогдуулан 2017 оны 6 дугаар сарын эцэс гэхэд ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр, Монголбанк активын ангилал, эрсдлийн сан байгуулах тухай журамдаа нэмэлт өөрчлөлт оруулан батална (*бүтцийн бэнчмарк*).
- **Банкны эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын нэмэлт шаардлагуудын тусгайлсан үнэлгээг нэвтрүүлэх.** Бид банкуудын өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үнэлгээ (ICAAP болон ILAAP) болон хяналт шалгалтын үнэлгээ (SREP) дээр үндэслэн Тулгуур II үйл явцыг 2018 оны 12 дугаар сарын эцэс гэхэд нэвтрүүлж эхлүүлнэ. Монголбанк 2019 оны 1 дүгээр сарын эцэс гэхэд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагын журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулах болон Базелийн гэрээ (Хөрвөх чадвартай актив, өөрийн хөрөнгийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн менежмент, хяналт шалгалтын зарчим)-ний шаардлагад нийцүүлэх болно.

- **Банкуудын засаглалыг сайжруулах.** Бид 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд дараах арга хэмжээг авсан байх болно. Үүнд: (i) ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр олон улсын шилдэг туршлагын дагуу банкны ТУЗ-ийн бүх гишүүн, дээд шатны удирдлага, хувьцаа эзэмшигчдэд тавих шалгуурыг чангатгах; (ii) холбоотой этгээдүүдэд олгох зээлийн талаарх дүрэм журам шинэчлэн нэвтрүүлэх; болон (iii) эцсийн өмчлөгчид тавих шаардлагыг чангатгана (бүтцийн бэнчмарк). Шинэчилсэн хууль, тогтоомжид үндэслэн, 2018 оны есдүгээр сарын эцэс гэхэд бид, холбоотой этгээдүүдийн зээлд бүтцийн өөрчлөлт хийх эсвэл шийдэхдээ холбоотой бус этгээдтэй хийсэн гүйлгээнээс илүү таатай нөхцөл олгохгүй байхыг хангах үүднээс холбоотой этгээдүүдэд олгосон зээлийн шалгалт хийнэ.
- **Арга хэмжээг урьтаж авах, нэмэлт хөрөнгө шаардах хяналт шалгалтын эрх мэдлийг нэмэгдүүлэх.** ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр, 2017 оны 11 дүгээр сарын эцэс гэхэд бид бас Банкны тухай хуульд дараах зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулна. Үүнд: (i) Монголбанкны урьтаж хийх арга хэмжээний тогтолцоог сайжруулах, түүний дотор, тухайлбал, дүрмийн сангийн доод хэмжээнээс дээгүүр шалгуур нэвтрүүлэх замаар дүрмийн санд үүсч болзошгүй дутагдлыг хяналт шалгалтаар тогтоох; (ii) томоохон эрсдлийн талаарх журмыг олон улсын шилдэг практикт уялдуулах; (iii) оношилгооны судалгаа, бизнес төлөвлөгөөний задлан шинжилгээний дүнгээр илэрсэн, мөн санхүүгийн байдлыг сайжруулах, эсвэл зээлийн алдагдлыг шингээх болон ирээдүйн алдаглыг тооцох зорилгоор банкуудаас дүрмийн сан болон эрсдлийн сангаа нэмэгдүүлэхийг шаардах Монголбанкны эрх мэдлийг нэмэгдүүлэх; (iv) Активын чанарын үнэлгээний зардал мэтийн хяналт шалгалтын зардлыг нөхөх шимтгэл хураамжийг банкуудаар гаргуулах бүрэн эрхийг Монголбанкинд олгох зэрэг болно (*бүтцийн бэнчмарк*).

Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт мониторинг хийж, дэмжлэг үзүүлнэ

34. **Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварт мониторинг хийж, шаардлагатай бол эх үүсвэрээр ил тод, шуурхай хангах болно.** Бид тайлагналыг сайжруулах замаар түргэн борлогдох активуудын болон мөнгөн гүйлгээнд өдөр тутмын хяналт тавьж, урьдчилан тооцох арга хэрэгсэлээ нэмэгдүүлнэ. Шаардлагатай бол банкуудад зээл олгох журмаа олон улсын шилдэг туршлагын дагуу шинэчлэх болно. Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангалттай төвшинд хадгалах үүднээс Монголбанк дүрэм, журмынхаа дагуу зохих арга хэмжээ авахад бэлэн байдалд байх болно.

Чанаргүй зээлийн асуудлын шийдлийг идэвхижүүлэх нь.

35. **Өрийн асуудлыг үр дүнтэй шийдэх арга хэмжээ авна.** Бид хоёр чиглэлээр ажиллана. Үүнд:
- **Зээлийн бүтцийг Банкны бодлого, зээлийн журмыг боловсронгуй болгох.** Бид чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх стратеги, бодлого, дотоод хүчин чадалтай байхыг, мөн 2018 оны 6 дугаар сарын эцсээс эхлэн чанаргүй зээлийн дэлгэрэнгүй тайлан ирүүлж байхыг банкуудад даалгасан журмыг 2017 оны 12 дугаар сарын эцэс гэхэд батална.
 - **Чанаргүй зээлийн асуудлыг үр дүнтэй шийдэхэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох.** Холбогдох бусад яам, тамгын газартай хамтран банкуудын үйл ажиллагааны өнөөгийн орчныг задлан шинжилж, дампуурлын болон шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж, татварын асуудал, мөн чанаргүй зээлийн борлуулалт, аутсорсинг асуудалтай холбоотой эрх зүйн болон зохицуулалтын аливаа саад бэрхшээлийг тодорхойлж, илрүүлсэн саад бэрхшээлийг үе шаттай арилгах хуваар бүхий чанаргүй зээлийг шийдвэрлэх стратеги боловсруулна. Санхүүгийн тогтортой байдлын зөвлөл энэ стратегийг 2018 оны 1 дүгээр сарын эцэс гэхэд батлана (бүтцийн бэнчмарк). Бид энэ талаар техникийн туслалцаа хүсэх бодолтой байна.

Мөн Активын удирдлагын компани (АУК) байгуулах чиглэлээр хийсэн ажил их байна. АУК олон улс оронд нааштай үүрэг гүйцэтгэсэн боловч, активын чанарын үнэлгээний үйл явцад АУК ямар үүрэг гүйцэтгэх зэргээр шийдвэл зохих хэд хэдэн асуулт байна. Энэ тухайд цаашид шинээр хууль тогтоох санаачилга гаргах эсэхийн тухайд бид анхааралтай судлаж үзэн АХБ болон ОУВС-гийн ажилтнуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийднэ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

36. **Бид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон авлигатай тэмцэх тогтолцоогоо сайжруулан олон улсын стандартад нийцүүлэх хүсэл зориг дүүрэн байна.** Эдгээр чиглэлээр ахиц дэвшил гаргаснаар бизнесийн орчинг сайжруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, бас мөн санхүүгийн болон уул уурхайн зэрэг түлхүүр салбаруудад ил тод, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

37. **Эхний ээлжинд, 2018 оны 3 дугаар сарын эцэс гэхэд авлигатай тэмцэх тухай хууль, тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийг батална.** Тухайлбал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, болон Эрүүгийн хуульд дараах нэмэлт өөрчлөлт оруулна. Үүнд: (i) Авлигатай тэмцэх тухай НҮБ-ын конвенцийн дагуу зүй бусаар баяжихтай холбоотой хэргийг оролцуулан авлигын үйлдлийг гэмт хэрэгт тооцох; (ii) дотоодын улс төрчдийн хувьд Санхүүгийн ажиллагааны ажлын хэсэг /FATF/-ийн стандартын дагуу магадлан шинжилгээ хийлгэх шаардлагад хамруулна; болон (iii) дээд шатны удирдах албан тушаалтны өмчийн эд хөрөнгийг хамарсан хөрөнгийн мэдүүлгийн ил тод цогц шаардлагад хамруулах бөгөөд цаг тухайд нь хэвлэн нийтлэх асуудал эрхэлсэн нэг байгууллагад тайлагнах, мэдүүлэг өгөхгүй байх, эсвэл худал мэдүүлэг өгөхийг хуулиар хориглоно. Цаашдаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй болон авлигатай тэмцэх эрх бүхий байгууллагынхаа нөөц боломжийг нэмэгдүүлж, арга туршлагыг нь сайжруулах болно.

Е. Өрсөлдөх чадвар ба төрөлжүүлэлт

38. **Уул уурхай олон арван жилийн туршид Монгол улсын эдийн засгийн үндсэн салбар байх төлөвтэй байгаа боловч төрөлжүүлэн олон салбартай болгох хийгээд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх хүчин чармайлт шаардлагатай байна.** Үүний тулд бид малын эрүүл мэндийн тухай хуулийг боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна: ургамалын хорио цээрийн стандартаа дээшлүүлснээр 60 сая гаруй толгой мал бүхий Монгол улсын мал аж ахуй, махны экспортын нөөц бололцоог ашиглаж эхлэхэд дэмжлэг болох юм. Бид мөн ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр дээр ажиллах болно. Эцэст нь, бид бизнесийн орчинг сайжруулах үүднээс тусгай зөвшөөрлийн тухай хуулийг шинэчлэн найруулах болно. Эдгээр асуудлын талаар Дэлхийн Банкны төсвийн дэмжлэгийн зээлийн баримт бичигт нарийвчлан авч үзсэн байгаа.

А. Хөтөлбөрийн эрсдэл, болзошгүй зардал ба хяналт шинжилгээ

39. **Хөтөлбөр эрсдэлтэй тулгарч болзошгүй боловч бид ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр шаардлагатай бол бодлого зохицуулалт хийхэд бэлэн байх болно.** Дараах үндсэн эрсдэл тулгарч болох юм. Үүнд: (i) түүхий эдийн үнэ буурах; (ii) худалдааны гол түнш орнуудад эдийн засгийн өсөлт буурах; (iii) орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх; (iv) өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх; (v) хөрөнгийн орох урсгал төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх; болон (vi) бусад магадлашгүй өр, төлбөр гүйцэтгэх. Эдгээр эрсдэл макро эдийн засгийн орчин, цаашилбал улсын өрийн тогтвортой байдалд ихээхэн сөргөөр нөлөөлж болох юм. Ийм эрсдэл тулгарах юм бол, Засгийн газар хөтөлбөрийн зорилго зорилтуудаа үргэлжлүүлэн хангах үүднээс ОУВС-гийн ажилтнуудтай нягт зөвшилцсөний үндсэн дээр бодлогын тохируулгын шуурхай арга хэмжээг авахад бэлэн байна. Ийм үед авбал зохих төсвийн арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн анхны хяналт шалгалтаар боловсруулна.

40. **Хөтөлбөрийн хэрэгжилтэнд улирал тутам үнэлгээ явуулна.** Энэ үнэлгээгээр макро эдийн засгийн гүйцэтгэлийг мөн хөтөлбөрийн бүтцийн бэнчмаркийг хангах талаар гарсан ахиц дэвшлийг үнэлэх болно. Хөтөлбөрийн эхний хоёр үнэлгээг 2017 оны 6 дугаар сарын 30-наас, 2017 оны 9 дүгээр сарын 30-наас өмнө тус тус хийнэ.

41. **Эхний үнэлгээнээс өмнө Монголбанкны эрсдэлийн үнэлгээг хийгдэнэ.** Энэ бол хөтөлбөрийн явцад ашиглах ОУВС-гийн хөрөнгийг хамгаалах хангалттай баталгаа байгаа эсэхийг нягтлан хянах үүднээс ОУВС-гийн дэмжлэгтэй хөтөлбөр бүрийн эхэнд гүйцэтгэдэг стандарт арга хэмжээ юм.

Хүснэгт А1. Монгол Улс: Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлт

	4/30/2017	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/30/2018
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт 1/ 2/	Зорилтот үзүүлэлт				
Гадаад цэвэр албан нөөцийн өөрчлөлт (доод хязгаар, өссөн дүнгээр, хугацааны эцсийн үлдэгдлийн өөрчлөлт, сая ам.доллараар, хөтөлбөрийн валютын ханшаар)	-250	0	100	250	550
Монголбанкны дотоод цэвэр актив /ДЦА/ (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр хөтөлбөрийн валютын ханшаар)	5,400	5,100	4,900	4,600	4,000
Нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл (доод хязгаар, төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр, тэрбум төгрөгөөр)	-650	-850	-1,050	-1,500	-350
Засгийн газрын эсвэл Монголбанкны авсан эсвэл баталгаа гаргаж өгсөн нэг ба дээш жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус шинэ гадаад өр (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар).	600	1,800	1,800	1,800	1,800
Засгийн газрын эсвэл МБ-ны баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдэл (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар)	850	850	850	750	750
Зорилтот үзүүлэлт (IT)					
Нөөц мөнгө (дээд хязгаар, тэрбум төгрөгөөр)	3,400	3,500	3,900	4,000	4,200
Гүйцэтгэлийн байнгын шалгуур үзүүлэлт					
Засгийн газрын эсвэл Монголбанкны авсан эсвэл баталгаа гаргаж өгсөн нэгээс доош жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус гадаад өр (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар).	0	0	0	0	0
Гадаад төлбөрийн шинэ өрийн хуримтлал (дээд хязгаар, хугацааны эцэс, сая ам.доллараар).	0	0	0	0	0
Меморандум үзүүлэлтүүд					
ОУВС-гийн хөтөлбөрийн суурь нөхцөлд тусгагдаагүй хоёр болон олон талт хөгжлийн түншүүдээс авсан төсвийн дэмжлэг (хугацааны эцсийн үлдэгдэл, өссөн дүнгээр, сая ам.доллар)	0	257	427	597	783
Хөтөлбөрийн суурь үзүүлэлтийн хүрээнд Засгийн газар (ХБ-ыг оролцуулан)-ын авсан хөнгөлөлттэй бус цэвэр зээл (хугацааны эцсийн үлдэгдэл, өссөн дүнгээр, сая ам.доллараар)	20	20	20	20	20
Хөтөлбөрийн валютын ханш					
Төгрөг / ам.доллар	2489.4	2489.4	2489.4	2489.4	2489.4
Ам.доллар / ЗТЭ	1.3	1.3	1.3	1.3	1.3
Мөнгөжүүлсэн алтны үнэ (ам.доллар/унци)	1,142	1,142	1,142	1,142	1,142
<p>1/ Хөтөлбөрийн валютын ханшаар тооцсон. 2/ Өссөн дүнгээр тооцсон зорилтот үзүүлэлтүүд нь үндсэн тэнцлийн 2018 оны 1дүгээр улирлаас бусад нь 2017 оны 12 дугаар сарын 31-нд суурьласан болно.</p>					

Хүснэгт А2. Монгол улс: Санал болгож буй урьдчилсан арга хэмжээ болон бүтцийн бэнчмаркууд

<p>Урьдчилсан арга хэмжээ</p> <p>Төсвийн</p> <p>Хөтөлбөрийн зорилтуудад нийцсэн 2017 оны төсвийн тодотгол, 2018-2020 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2017 оны зорилтуудыг хангах төсвийн бүхий л арга хэмжээг батлах</p> <p>Банкны талаар</p> <p>ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр банкуудад олон улсын нэр хүнд бүхий компаниудаар хийлгэх активын чанарын үнэлгээний худалдан авах ажиллагааг Монголбанкнаас эхлүүлэх.</p> <p>Мөнгөний бодлогын талаар</p> <p>Монголбанкны зүгээс орон сууцны хөтөлбөр болон аж ахуйн нэгжүүдэд зээл олгох зэргээр төсвийн шинжтэй бүхий л цэвэр санхүүжилтийг зогсоох талаар эрх баригчдын зүгээс ОУВС-гийн ажилнуудад мэдэгдэнэ.</p>	<p>Дуусгавар болгох огноо</p> <p>(шинэ хөтөлбөрийг Захирлын зөвлөлөөр батлуулахаас өмнө дуусгавар болсон байна)</p>
<p>Бүтцийн бенчмаркууд</p> <p>Төсвийн</p> <p>ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр орлого нэмэгдүүлэх, тогтолцооны төвөгтэй байдлыг энгийн хялбар болгох, хүн амын орлогын татварын өсөн нэмэгдэх зарчмыг нэвтрүүлэх үүднээс татварын тогтолцоог хянаж үзэн хөрөнгө оруулалт, нэмэгдсэн өртгийн албан татвар, хүн амын орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувьд үр ашигтай, татварын тэгш байдлыг хангах талаар зөвлөмж гаргах ажлын хэсэг байгуулах.</p>	<p>2017 оны 8 дугаар сарын эцэс</p>
<p>Гүйцэтгэлийн суурь арга хэмжээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний автомат тогтолцоог оролцуулсан том, дунд, жижиг болон бичил бизнес эрхлэгчдийн нийцлийг сайжруулах стратегийг Татварын ерөнхий газар (ТЕГ) болон татварын бусад байгууллагаас эцэслэн хэрэгжүүлж эхлэх.</p>	<p>2017 оны 4 дүгээр сарын эцэс</p>
<p>Бүх төрлийн татварт хамаарах захиргааны нийтлэг заалтуудыг нэгтгэн татварын тогтолцооны тогтвортой удирдлагыг дэмжих, болон татвар төлөгчийн ашиг сонирхлын болон татварын байгууллагын эрх мэдэл хоорондын зохистой тэнцвэрийг хангах зорилгоор шинэчилсэн Татварын ерөнхий хуулийн төслийг УИХ-д өргөн барих.</p>	<p>2017 оны 10 дугаар сарын эцэс</p>
<p>ОУВС-гийн техникийн туслалцааны зөвлөмжийн хүрээнд бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан хялбаршуулсан татварын тогтолцоо бий болгох тухай хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн барих.</p>	<p>2017 оны 10 дугаар сарын эцэс</p>
<p>2018 оны төсвийг хөтөлбөрийн төсвийн зорилтот үзүүлэлтэд нийцүүлэн батлах.</p>	<p>2017 оны 11 дүгээр сарын эцэс</p>
<p>Олон улсын шилдэг туршлага, ОУВС-гийн зөвлөмжид үндэслэн төсвийн холбогдох хууль тогтоомжийг хянан шинэчлэх, төсвийн зөвлөлийг байгуулах тухай шинэ хууль батлан хэрэгжүүлэх.</p>	<p>2017 оны 12 дугаар сарын эцэс</p>
<p>Нэгдсэн төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулснаар 2018 оноос эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөр Сангийн сайдын өргөн барьсан төсөвт тусгагдсан төсвийн зардлын нийт дүнг нэмэгдүүлэх УИХ-ын бүрэн эрхийг хязгаарлах тухай (НЭМЭЭД ХАС заалтыг оролцуулан) нэмэлт өөрчлөлт оруулах.</p>	<p>2017 оны 11 дүгээр сарын эцэс</p>
<p>Татварын ажлын хэсгийн тайланг Сангийн яаманд хүргүүлэх</p>	<p>2017 оны 12 дугаар сарын эцэс</p>

Хүснэгт А2. Монгол улс: Санал болгож буй урьдчилсан арга хэмжээ болон бүтцийн бэнчмаркууд (төгсгөл)

<p>Нийгмийн хамгаалал Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг Монгол улсын нийт өрхийн хамгийн ядуу 40 хувийг зорилтот бүлэг болгон өөрчилж, гарсан хэмнэлтийг чиглэсэн зорилтот хүнсний талоны хөтөлбөрт зориулна.</p>	<p>2017 оны 12 сарын эцэс</p>
<p>Мөнгөний Монголбанкны чиг үүргийг тодорхойлж, хараат бус байдал, засаглалыг бэрхүүлэн үйл ажиллагааг нь сайжруулах зорилгоор ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр Монголбанкны тухай шинэ хуулийг УИХ-д өргөн барих.</p>	<p>2017 оны 11 сарын эцэс</p>
<p>Монголбанкны тухай шинэ хуулийг батлах</p>	<p>2018 оны 3 сарын эцэс</p>
<p>Банкны ОУВС-гийн ажилтнуудын удирдлага дор банкны тухай болон Монголбанкны тухай хууль, холбогдох дүрэм дурамд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Албадлагын арга хэмжээг урьдтаж авах тогтолцоог боловсронгуй болгох 2. Сангийн яам, Хадгадамжийн даатгалын корпораци /ХДК/-тай хамтран банкныг татан буулгах тухай хууль тогтоомж болон санхүүжүүлтийн хийгээд хамтын ажиллагааны тогтолцоог олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх 3. Банкуудын оношлох судалгаа, бизнес төлөвлөгөөний шинжилгээний дүнд үндэслэн санхүүгийн хүч чадалаа нэмэгдүүлэх, эсвэл одоогийн болон ирээдүйн зээлийн алдагдлаа тооцож шингээх зорилгоор өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, эрсдийн сан байгуулахыг банкуудаас шаардах тухайд Монголбанкинд хангалттай эрх мэдэл олгох 4. Активын чанарын үнэлгээ зэрэг хяналт шалгалтын зардлыг санхүүжүүлэх шимтгэлийг банкуудаас гаргуулах бүрэн эрхийг Монголбанкинд олгох 5. Хувь нийлүүлэгч, ТУЗ-ын гишүүд болон дээд шатны удирдлагад тавих шаардлагыг чангатгах 6. Банкнудын холбоотой этгээдүүд болон эцсийн өмчлөгч нарт олгох зээлийн дээд хязгаарын талаарх дүрэм журмыг шинэчлэх 	<p>2017 оны 11 сарын эцэс</p>
<p>Хадгаламжийн даатгалын тухай хуульд Хадгаламжийн даатгагч нарын олон улсын холбооны “Хадгаламжийн даатгалын үр дүнтэй системийн үндсэн зарчим”-д нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	<p>2017 оны 11 дүгээр сарын эцэс</p>
<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /СТБЗ/ чанаргүй зээлийн асуудлыг шийдэх стратеги боловсруулна. Холбогдох бусад яам, тамгын газартай зөвшилцсөний үндсэн дээр СТБЗ дараах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажиллуулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> i. Өр барагдуулахад тулгарч буй асуудал, ялангуяа дампуурлын тухай болон шийдвэр гүйцэтгэх тухай хууль, татварын асуудал, чанаргүй зээлийг борлуулах, аутсорсинг хийхэд учирч буй хууль эрх зүйн болон зохицуулалтын холбоотой саад бэрхшээлийг тодорхойлж, задлан шинжилгээ хийх. ii. Тодорхойлсон саад бэрхшээлийг арилгах шат дараалсан ажлын төлөвлөгөө, хуваар бүхий Чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх стратеги боловсруулах 	<p>2018 оны 1 дүгээр сарын эцэс</p>
<p>Монголбанк, сайжруулсан хууль, тогтоомжид үндэслэн холбоотой талуудад олгосон зээлийн судалгаа хийнэ</p>	<p>2018 оны 9 дүгээр сарын эцэс</p>
<p>Монголбанк активын ангилал болон эрсдлийн сан байгуулах тухай журамдаа ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулна.</p>	<p>2017 оны 6 дугаар сарын эцэс</p>
<p>Засгийн газрын сангуудын ашиглалтын тухай хуулийг баталж хэрэгжүүлэх.</p>	<p>2017 оны 12 дугаар сарын эцэс</p>

Хавсралт II. Техникийн санамж бичиг

1. Энэхүү Техникийн санамж бичиг (ТСБ) Монгол улсын эрх баригчид болон ОУВС-гийн ажилтнуудын хооронд Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлох талаарх харилцан ойлголцлолыг тусгаж байгаа юм. Энд эрх баригчдын 2017 оны 4 дүгээр сарын 13 өдрийн Үүрэг, амлалтын захидал болон Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандумд тодорхойлсон ёсоор өргөтгөсөн хөтөлбөрийн хугацаанд хийгдэх гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлтийн тохируулга хийгээд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтоож байгаа юм. Түүнчлэн хөтөлбөрийн гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглах аргуудыг тодорхойлохын зэрэгцээ зорилтот үзүүлэлтийн хяналт шинжилгээг зохих ёсоор хийхэд ашиглах мэдээ, мэдээлэлд тавих шаардлагыг бас тодорхойлж байгаа юм.

I. Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлт болон зорилтот үзүүлэлтүүд: хувьсагчдын тодорхойлолт

Тестийн огноо

2. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг 2017 оны 4 дүгээр сарын эцэс, 2017 оны 6 дугаар сарын эцэс, 2017 оны 9 дүгээр сарын эцэс болон 2017 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар дараах үзүүлэлтийн хувьд тогтоосон болно. Үүнд:

- Монголбанкн дахь гадаад цэвэр активын өөрчлөлтийн доод хэмжээ;
- Монголбанкны Дотоод цэвэр активын дээд хэмжээ;
- Нэгдсэн төсвийн үндсэн тэнцлийн доод хэмжээ;
- Засгийн газар эсвэл Монголбанкны зүгээс нэг ба дээш жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус нөхцөл бүхий шинэ гадаад өрийн гэрээ байгуулах эсвэл баталгаа гаргах дээд хязгаар,
- Засгийн газар эсвэл Монголбанкны зүгээс баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдлийн дээд хязгаар.

3. Дараах үзүүлэлтийн хувьд байнга хангавал зохих гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт тогтоосон болно. Үүнд:

- Засгийн газар эсвэл Монголбанкны зүгээс нэг жилээс доош хугацаатай хөнгөлөлттэй бус нөхцөл бүхий гадаад өрийн шинэ гэрээ байгуулах эсвэл баталгаа гаргаж өгөх дээд хязгаар,
- Гадаад өр төлбөрийн шинэ хуримтлал;

4. Дараах үзүүлэлтийн хувьд 2017 оны 4 дүгээр сарын эцэс, 2017 оны 6 дугаар сарын эцэс, 2017 оны 9 дүгээр сарын эцэс болон 2017 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар зорилтот үзүүлэлт тогтоосон болно. Үүнд:

- Нөөц мөнгөний дүнгийн дээд хэмжээ.

Тодорхойлолт

5. Хөтөлбөрийн зорилгоор дараах тодорхойлолтыг ашиглана. Үүнд:

- Улсын нэгдсэн төсөвт төсвийн бүх байгууллага, нийгмийн даатгалын сан болон Засгийн газрын (тогтворжуулалтын сан, ирээдүйн хөгжлийн өв сан зэргийг оролцуулах боловч тэдгээрээр үл хязгаарлан) тусгай сангууд, орон нутгийн төсөв, Монгол улсын Хөгжлийн банкныг хамруулан ойлгоно. Эрх зүйн хувьд хараат бус төрийн өмчит бусад аж ахуйн нэгжүүд (ТӨҮГ), БНХАУ-ын Ардын банк (РВОС)-ны своп хэлцлийн шугам зэрэг Монголбанкны өр төлбөрийг төв засгийн газрын өрийн тодорхойлолтоос хасч ойлгоно.
- Нэгдсэн төсвийн үндсэн тэнцлийг нэгдсэн төсвийн санхүүгийн тэнцэл дээр төв Засгийн газрын зээлийн хүүгийн төлбөрийг нэмж тодорхойлно.
- Дотоодын банкны системийг Монголбанк болон Монгол улсад бүртгүүлсэн, Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан арилжааны банкуудыг хэлнэ.
- Төсвийн жил гэдэгт 1 дүгээр сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусгавар болдог календарийн жилийг хэлнэ.

- Хөтөлбөрийн зорилгоор, гадаад валюттай холбоотой актив, пассив, хөрөнгийн бүх урсгалын хувьд доор тодорхойлсон "хөтөлбөрийн нягтлан бодох бүртгэлийн валютын ханш"-ийг ашиглан тодорхойлох бөгөөд харин Засгийн газрын төсвийн тэнцлийг валютын урсгал ханшаар тооцно. Өөрөөр заагаагүй бол, Монголбанкны балансын ам.доллараар илэрхийлсэн зүйл ангиудыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Монголбанкнаас зарласан ам.доллар төгрөгийн харьцах 2489,4 гэсэн жишиг ханшаар үнэлж тооцно. Хөтөлбөрийн зорилгоор БНХАУ-ын юань (юань), зээлжих тусгай эрх (ЗТЭ), алтны нөөцийг 2016 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийн зарласан дараах кросс-ханшийг ашиглан ам.долларт хөрвүлж тооцно. Үүнд: юанийг 0,14389 ам.доллар, ЗТЭ-ийг 1,344330 ам.доллар, алтны албан нөөцийн нэг гурвалсан унцийг 1142,54 ам.доллар зэрэг болно.
- Хөтөлбөрийн зорилгоор хөнгөлөлттэй бус гадаад зээлийн дүнгээс дараах зүйлийг хасч тооцно. Үүнд: (i) ОУВС-гийн хөрөнгийн ашиглалт; (ii) Азийн хөгжлийн банк, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, болон Дэлхийн банкны группээс авсан зээл, (iii) Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Энэтхэгийн Экспорт-импортын банк, Солонгос, Турк, Германы Хөгжлийн банк зэрэг засгийн газрын болон засгийн газрын байгууллагын зээл, (iv) хөнгөлөлттэй өр; (v) Оршин суугч бус этгээдийн эзэмшилд байгаа төгрөгөөр нэрлэсэн засгийн газрын үнэт цаас зэргийг хасч ойлгоно.
- Хөтөлбөрийн зорилгоор, өрийн нийт дүнд дараах байдлаар тооцсон буцалтгүй тусламжийн агуулга, эзлэх хувийн жин багаар бодоход 35 хувийг агуулсан бол өрийг хөнгөлөлттэй гэж үзнэ. Үүнд: өрийн буцалтгүй тусламжийн агуулгыг өрийн өнөөгийн үнэ цэнэ (PV) болон түүний нэрлэсэн үнэ хоёрын зөрүүг өрийн нэрлэсэн үнэд харьцуулан эзлэх хувийн жингээр тооцно. Өрийн гэрээ байгуулах үеийн өнөөгийн үнэ цэнэ (PV)-ийг энэ өрийн улмаас хийгдэх өрийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийн ирээдүйн урсгал¹-ыг хорогдуулан тооцно.
- Жишиг хүүгийн хувь дээр тогтмол зөрөө нэмж тооцсон хувьсах хүүтэй өрийн хувьд өнөөгийн цэвэр өртгэлийг нь хөтөлбөрийн лавлагааны хүү дээр өрийн гэрээнд заасан (нэгж хувийн мянганы нэгээр илэрхийлэх) тогтмол зөрөөг нэмж тооцно. Хөтөлбөрийн лавлагааны хүү 6 сарын хугацаатай ам.долларын Лондонгийн банк хоорондын захын хүү /LIBOR/-гийн хувьд 3,18 байх бөгөөд хөтөлбөр хэрэгжих хугацаанд тогтмол байна. Зургаан сарын еврогийн LIBOR болон 6 сарын ам.долларын LIBOR-ын хоорондын зөрөө 0,308 нэгж хувь, Японы иены 6 сарын LIBOR болон 6 сарын ам.долларын LIBOR-ын хоорондын зөрөө 0,306 нэгж хувь, Их Британий фунт стерлингийн LIBOR болон 6 сарын ам.долларын LIBOR-ын хоорондын зөрөө 0,231 нэгж хувь болон евро, иен, фунт стерлингээс өөр бусад валютын LIBOR болон 6 сарын ам.долларын LIBOR-ын хоорондын зөрөөг 0 байхаар тооцсон болно.²

А. Монголбанкны гадаад цэвэр нөөц

6. Монголбанкны гадаад цэвэр нөөцийн өөрчлөлтөд доод хязгаар тогтоож өгнө. Монголбанкны гадаад цэвэр нөөцийн өөрчлөлтөд доод хязгаарыг ОУВС-гаас бусад хоёр талт болон олон талт хандивлагчдаас орж ирэх төсвийн дэмжлэгийн дүнгээс хамааруулан Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлтийн хүснэгтэд харуулсанчлан хөтөлбөрт заасан төвшнөөс илүү гарсан бол нэмэгдүүлэх /дутсан бол доошлуулах/ чиглэлд өөрчлөн тохируулна.
7. Гадаад цэвэр нөөцийг гадаад нийт нөөцөөс гадаад өр, төлбөрийг хасч тооцно. Хөтөлбөрийн хяналт шинжилгээний зорилгоор, Монголбанкны гадаад актив, гадаад пассивын үлдэгдлийг дээр 5 дугаар зүйлд заасан хөтөлбөрийн валютын ханш, алтны үнээр үнэлнэ. Монголбанкны нийт гадаад нөөцийг дараах зүйлийн нийлбэрээр тодорхойлно. Үүнд:
 - Монголбанкин дахь мөнгөжүүлсэн алтны нөөц;
 - Зээлжих тусгай эрхийн нөөц;
 - Монгол улсын ОУВС дахь нөөцийн позиц;

¹ Буцалтгүй тусламжийн агуулга тэгтэй тэнцүү буюу доош өрийн хувьд өнөөгийн цэвэр үнийг өрийн нэрлэсэн өртгөөр нь тогтооно. Энэ зорилгоор Захирлын зөвлөлийн 15248-(13/97) тоот шийдвэрээр тогтоосон 5 хувийн хямдруулалтын нэгдмэл хүүг ашиглана.

² Хувьсах хүү 6 сарын ам.долларын LIBOR-оос өөр бусад жишиг хүүтэй холбоотой байвал жишиг хүү болон 6 сарын ам.долларын LIBOR хоёрын хоорондын зөрөөг нэмж тооцно. Ингэхдээ хамгийн ойрын 0,05 нэгж хувь хүртэл бүхэлдүүлэн тооцно.

- Монголбанкны шууд, үр дүнтэй хяналт дор байдаг, гадаад валютын зах зээлд оролцох, эсвэл төлбөрийн тэнцэл тэнцвэрийн зөрөөг шууд санхүүжүүлэхэд бэлэн байдалд байлган гадаадад хадгалж байгаа гадаад валютын актив (нэмэх нь Монголбанкны зоорьт хадгалж байгаа бэлэн мөнгө).

Нийт нөөцийн тодорхойлолтоос дараах зүйлийг хасч тооцно. Үүнд: оршин суугчдаас авах гадаад валютын аливаа авлага, олон улсын байгууллагуудын дүрмийн сан дах оролцоо, болон гуравдагч этгээдийн өрийн барьцаа, баталгаа зэргийг оролцуулан тэдгээрээр үл хязгаарлах аливаа барьцаалсан, эсвэл баталгаа гаргасан нийт нөөцийг хасч тооцно.

Монголбанкны гадаад нөөцийн пассивын дүнг дараах зүйлийн нийлбэрээр тооцно. Үүнд:

- Монгол улсын ОУВС-гийн өмнө хүлээсэн өр, төлбөрийн бүх үүрэг
- Гадаадын банкуудаас хадгалуулсан аливаа алтыг оролцуулан нэг ба түүнээс доош жилийн хугацаатай Монголбанкнаас оршин суугч бус этгээдийн өмнө хүлээсэн гадаад валютын аливаа өр, төлбөр;
- Своп хэлцлээр БНХАУ-ын Ардын банкинд хүлээсэн өр төлбөр;
- Арилжааны банкууд дах харилцах, хадгаламжийг оролцуулсан оршин суугчдын гадаад валютын хугацаа хамаарахгүй аливаа өр, төлбөр. Своп хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудын өмнө хүлээсэн гадаад валютын хугацаа харгалзахгүй валютын нөөцийн өр төлбөр гэж үзнэ.

В. Нөөц мөнгө

8. Нөөц мөнгөний хэмжээнд баримжаа дээд хязгаар тогтоож өгнө. Энэ нь Монголбанкнаас гаргасан мөнгө болон арилжааны банкуудын Монголбанкн дахь хадгаламжаас WOM (Монголбанкн дахь бэлэн мөнгөний нөөцийг хасч) бүрдэнэ.

С. Монголбанкны Дотоод цэвэр актив

9. Монголбанкны дотоод цэвэр актив /ДЦА/-ын хэмжээнд дээд хязгаар тогтооно. ДЦА-ын дээд хязгаарыг хөтөлбөрөөр тохирсон хэмжээнээс хэтрүүлэн авсан гадаад зээллэгийн дүнгээр доошлуулж тохируулга хийж явна. Энэ нь хоёр талт болон олон талт хандивлагчдаас авах төсвийн дэмжлэгийн хийгээд төслийн санхүүжилтээс бусад хөнгөлөлттэй бус цэвэр зээлийн аль алинд хамаарна. Гадаад зээллэгийн (хоёр талт болон олон талт хандивлагчдаас авах төсвийн дэмжлэгийн хийгээд төслийн санхүүжилтээс бусад хөнгөлөлттэй бус цэвэр зээлийн аль алины хувьд) дүн хөтөлбөрөөр тохирсон төвшнөөс доош байх тохиолдолд зөрүүгийнх нь 50 хүртэл хувиар Монголбанкны ДЦА-ын хэмжээнд тавих дээд хязгаарыг нэмэгдүүлнэ.

- ДЦА-ын дүнг нөөц мөнгөний дүнгээс Монголбанкны гадаад цэвэр актив болон бусад гадаад цэвэр активын нийлбэрийг хасч тооцно.
- Бусад гадаад цэвэр активыг Монголбанкны нийт гадаад нөөцийн хуримтлагдсан хүүгийн авлага болон гадаад нөөцийн өр, төлбөрийн болон олон улсын санхүүгийн байгууллагуудын хадгаламжийн хуримтлагдсан хүүгийн төлбөрийн хоорондын зөрөөгөөр тодорхойлно.

Д. Нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл

10. Нэгдсэн төсвийн үндсэн тэнцлийн дүнд балансаас гадуур тооцох доод хязгаар тогтооно. Үүнийг жилийн туршид өсөн нэмэгдсэн байдлаар тооцно. Балансаас гадуурх санхүүгийн эх үүсвэрт дараах зүйлийг хамруулна. Үүнд:

- Засгийн газарт (түүний дотор Хөгжлийн банкинд) олгосон банкны цэвэр зээл— энд Монголбанк (урьдчилгаа, зээл, засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл, ОУВС-гийн зээлийн үлдэгдлийн дүнгээс хадгаламжийг хасч тооцно) болон арилжааны банкуудаас авсан (зээл, урьдчилгаа, засгийн газрын үнэт цаасны үлдэгдлийн дүнгээс хадгаламжийг хассан) цэвэр зээлийг оролцуулна.
- Гадаад цэвэр санхүүжилт— энд хөтөлбөрийн зээл, төслийн зээл, хөнгөлөлттэй бус зээллэг, эсвэл Засгийн газрын бонд болон арилжааны зээл мэтийн урт хугацаатай гадаад өр, болон Хөгжлийн банкны гадаад зээллэгийг хамруулж үзнэ.
- Өмч хувьчлалын орлого.

Е. Хөнгөлөлттэй бус нөхцөлтэй дунд болон урт хугацаатай гадаад өр

11. Засгийн газар, Монголбанк эсвэл Засгийн газрын нэрийн өмнөөс өөр бусад байгууллагын оршин суугч бус этгээдэдээс авах нэг буюу түүнээс дээш жилийн хугацаатай өр гэрээлэх ба / эсвэл баталгаа гаргахад дээд хязгаар тогтооно. Хараахан хүлээн аваагүй өр, төлбөрийн үүрэг, эсвэл гаргасан баталгааны үнийн дүнд ч дээд хязгаар тогтооно. Хөтөлбөрийн зорилгоор өрийн тодорхойлолтыг Захирлын зөвлөлийн 2000 оны наймдугаар сарын 24-ний байдлаар шинэчлэн найруулсан 12274 тоот шийдвэрийн 9-д зааснаар ойлгоно (Хавсралт I).

Ү. Баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдэл

12. Хөтөлбөрийн зорилгоор, өрийн баталгаа гэдэг бол хүлээн авагч төлбөр хийхгүй тохиолдолд зээлийн үйлчилгээний үүргийг Засгийн газар, Монголбанк, эсвэл Засгийн газрын нэрийн өмнөөс бусад байгууллагууд хүлээх эрх зүйн тодорхой үүрэг (бэлэн мөнгө эсвэл мөнгөн бус төлбөр оролцуулах)-ээс урган гарахыг хэлж байна. Баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар ойролцоогоор 1.385,00 сая ам.доллар байв.

Г. Богино хугацаатай гадаад өр

13. Засгийн газар, Монголбанк эсвэл Засгийн газрын нэрийн өмнөөс өөр бусад байгууллагын оршин суугч бус этгээдэдээс авах нэгээс доош жилийн хугацаатай өрийг шинээр гэрээлэх ба / эсвэл баталгаа гаргахад дээд хязгаар тогтооно. Хараахан хүлээн аваагүй өр, төлбөрийн үүрэг, эсвэл гаргасан баталгааны үнийн дүнд ч дээд хязгаар тогтооно. Энэ бол тасралтгүй байнгын гүйцэтгэлийн шалгуур юм.

14. Хөтөлбөрийн зорилгоор энэ өрийн тодорхойлолтыг Захирлын зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 5-ний байдлаар шинэчлэн найруулсан 15688 тоот шийдвэрийн 8-д зааснаар ойлгоно (Хавсралт I).

15. Дараах үзүүлэлтийн хувьд дээд хязгаараас чөлөөлнө. Үүнд: (i) Монголбанкны гадаад нөөцийн пассив гэж ангилсан өрийг, (ii) бүтцийн өөрчлөлт хийх, дахин санхүүжүүлэх, эсвэл урьдчилан төлөх өрийг; (iii) Оршин суугч бус этгээдийн эзэмшиж буй төгрөгөөр нэрлэсэн Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас; болон (iv) импортын хэвийн санхүүжилт зэрэг болно. Импортын зээл харилцан суугтаж /self-liquidating/ байгаа нөхцөлд импортын санхүүжилтийг "хэвийн" гэж гэж үздэг.

II. МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

16. Өөрөөр заагаагүй бол хөтөлбөрийн үйл ажиллагааны хяналт шинжилгээнд шаардлагатай (гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон зорилтот бүх үзүүлэлттэй холбоотой тоо мэдээг оролцуулан) мэдээ, мэдээлийг сар бүрийн 20-ны өдөр гэхэд ОУВС-гийн Суурин төлөөлөгчид цахим болон хэвлэмэл байдлаар хүргүүлнэ. Тайлан мэдээний жагсаалтыг доор харуулсан бөгөөд тайлагнах үүрэг хариуцлага хүлээх хуулийн этгээдийн нэрсийг хаалтанд заасан болно.

А. Мөнгөний үзүүлэлтүүд (Монголбанк)

- Мөнгөний тойм, Монголбанкны тайлан тэнцэл, арилжааны банкуудын нэгдсэн тайлан тэнцэл. Монголбанкны тайлан тэнцлийг долоо хоног тутам, тайлант долоо хоног өнгөрснөөс хойш ажлын таван хоногийн дотор хүргүүнэ. Дээр дурдсан бусад мэдээг сар тутам хүргүүлнэ.
- Монголбанкны гадаад цэвэр нөөцийн дүн болон гадаад валютын захд хийсэн интервенцийг өдөр тутам болон бүх интервенцийн талаарх дэлгэрэнгүй тайланг долоо хоног тутам хүргүүлнэ.
- Мөрдөж буй хэрэгслийн хүү болон дүн хэмжээг, зах зээл дэх үйл ажиллагааг долоон хоног тутам, холбогдох долоо хоног дуусгавар болсноос хойш ажлын таван хоногийн дотор тайлагнана
- Монголбанк болон арилжааны банкуудаас Засгийн газарт олгосон цэвэр зээлийн дэлгэрэнгүй задаргааг долоо хоног тутам тайлагнана. Үүнийг сар тутам Сангийн яамтай тооцоо нийлж, актыг сар тутам хүргүүлнэ.
- Мөнгөжүүлсэн алтны нөөц (актив)-ийн үлдэгдэл болон алтны пассивыг мянган гурвалсан унц болон ам.доллараар долоо хоног тутам. Монголбанк мөнгөжүүлсэн алтны гүйлгээ хийх буюу алтаар илэрхийлсэн хөрөнгийн үнэлгээ хийхэд шууд болон шууд бус байдлаар нягтлан бодох бүртгэлийн аливаа бусад ханш ашиглаж байгаа бол энэ тухай ОУВС-гийн ажилтнуудад мэдээлэх үүрэгтэй.

Дотоод эх үүсвэрээс худалдан авсан, эсвэл Монголбанк хадгалж байсан буюу худалдан авсан мөнгөжүүлээгүй алтаа цэвэршүүлсний дүнд мөнгөжүүлсэн алтны хэмжээнд бий болсон аливаа өсөлт (үнэ, тоо хэмжээний аль алийг)-ийг нь сар тутам тайлагнана. Алтаар баталгаажсан буюу бусад байдлаар алт ашиглан үүсгэсэн аливаа өр төлбөрийг ОУВС-гийн ажилтнуудад мэдээлэх үүрэгтэй.

- БНХАУ-ын юань болон ЗТЭ-ийн актив, пассивын дүнг долоо хоног тутам.
- Монголбанкны болон арилжааны банкуудын аль алиных нь хувьд “бусад зүйл, цэвэр” зүйл ангийн дэлгэрэнгүй задаргааг сар тутам мэдээнэ. Ингэхдээ, тухайлбал бусад зүйлсийн дотор, цэвэр гадаад нөөц, бусад цэвэр гадаад активын дүнд валютын ханшны өөрчлөлт болон алтны үнийн дахин үнэлгээнээс хамаарсан үнэлгээний бүх өөрчлөлтийг хамруулах ёстой.
- Заавал байлгах нөөцийн хэмжээ болон нөөцийн бодит үлдэгдлийг банк тус бүрээр хоёр долоо хоног тутам.
- Төв банкны үнэт цаасны дуудлагын худалдааны тайлан мэдээг дуудлага худалдаа явуулснаас ажлын таван хоногийн дотор. Үүнд нийт санал болгосон үнэт цаасны дүн, ирсэн саналын эрэлтийн дүн, банк тус бүрт худалдсан дүн болон зарласан болон арилжсан хүү зэргийг хамруулна.
- Оршин суугч болон оршин суугч бус банкуудтай Монголбанкны хийсэн своп хэлцлийн үлдэгдлийг улирал тутам;
- Засгийн газар болон өөр бусад гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс Монголбанкны гаргасан баталгааны үлдэгдэл, улирал тутам;
- Монголбанкны гадаад валютын пассив, урт болон богино хугацаат өрийг оролцуулан улирал тутам.

В. Төсвийн мэдээ (Сангийн яам)

- Төвлөрсөн, орон нутгийн болон нэгдсэн төсвийн сар тутмын нэгтгэсэн дүн мэдээ, үүний дотор татварын болон татварын бус хийгээд хөрөнгийн орлого, урсгал болон хөрөнгийн зардал, цэвэр зээл болон санхүүжилтийн дүн мэдээ. Санхүүжилтийн зүйл ангиудыг гадаад (бэлэн мөнгө, төслийн болон хөтөлбөрийн зээл) болон дотоод эх үүсвэр (банкны болон банк бус)-ийн задаргаатай тайлагнана.
- Нийгмийн даатгалын сан тус бүрийн нууцлал бүхий бүх гүйлгээ.
- Засгийн газрын үнэт цаасны дуудлага худалдааны мэдээг санал болгосон дүн, эрэлтийн дүн, банк болон банк бус байгууллага бүрт худалдсан хэмжээ, дундаж хүү зэргийг оролцуулан сар тутам.
- Монгол улсын Хөгжлийн банкны шинэ зээл, эргэн төлөлт болон зээлийн үлдэгдлийг бэлэн мөнгөний сууриар илэрхийлсэн сар тутмын тайлан.
- Төсвийн шинжтэй сангуудыг оролцуулан нэгдсэн төсвийн арилжааны банкууд дахь бүхий л шинэ харилцах болон хадгаламжийн үлдэгдэл, улирал тутам.
- Нэгдсэн төсвийн олон талт болон хоёр талын хандивлагчдаас хүлээн авсан зээл, буцалтгүй тусламжийн болон тэдгээрт харгалзах дотоод санхүүжилтийн хуучин дансдын зэрэгцээ шинээр нээсэн аливаа харилцах дансдын үлдэгдэл.
- Хөгжлийн банкныг оролцуулан дотоод, гадаад өр, облигаци, татварын урьдчилгаа төлбөр, баталгаа гаргасан өр зэргийг оролцуулан Хөгжлийн банк болон Засгийн газрын хоорондын тооцоог харилцан суутгасан байдлаар цэврээр тооцож гаргасан нэгдсэн төсвийн өрийн үлдэгдлийг, сар тутам.

С. Гадаад секторын мэдээ (Монголбанк болон Сангийн яам)

- Улсын хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зорилгоор гадаад, дотоодын аж ахуйн нэгж гэрээ байгуулсан эсвэл байгуулахаар хэлэлцээ хийж байгаа 10 сая ам.доллараас дээш дүн бүхий шинэ гэрээний дэлгэрэнгүй бүрэн жагсаалтыг Сангийн яам гаргаж өгнө. Жагсаалтад эдгээр гэрээний дүн хийгээд бий болсон болон ирээдүйд бий болох өрийн болон өрийн бус төлбөрийн үүргийн нөхцөлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байвал зохино.
- Засгийн газар буюу Монголбанкны авсан буюу баталгаа гаргасан богино хугацаатай гадаад өрийн зээлийн үлдэгдэл, ашиглалт, эргэн төлөлт болон хүүгийн төлбөрийг анх авсан валютаар болон ам. доллараар улирал тутам Монголбанк гаргаж өгнө.
- Засгийн газар буюу Монголбанкны авсан буюу баталгаа гаргасан дунд болон урт хугацаатай гадаад өрийн зээлийн үлдэгдэл, ашиглалт, эргэн төлөлт болон хүүгийн төлбөрийг анх авсан валютаар болон ам. доллараар улирал тутам Монголбанк гаргаж өгнө.

- Америк доллартай харьцах төгрөгийн өдөр тутмын валютын ханш: лавлагааны, банк хоорондын болон зэрэгцээ зах зээлийн ханшийг оролцуулан (Монголбанк).
- Засгийн газар буюу Монголбанкнаас авсан буюу баталгаа гаргасан хугацаа хэтэрсэн гадаад өрийн үлдэгдэл, зээлдэгчээр, анх авсан валютаар болон ам.доллараар илэрхийлсэн дүн (улирал тутам Монголбанк).

D. Бусад тоо мэдээ (Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ))

- Сар тутмын хэрэглээний үнийн индекс, хэрэглээний сагсанд орсон бараа, үйлчилгээний үндсэн ангиллаар нарийвчилсан задаргаатай.
- Сар тутмын экспорт, импортын мэдээг хамарсан ҮСХ-ны сар тутмын статистикийн мэдээ.

Хавсралт I. Гадаад өрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн заавар

Захирлын зөвлөлийн 2014 оны 12 сарын 5-ны өдрийн 15688 тоот шийдвэрээс:

8.

(a) Энэхүү зааврын зорилгоор "өр" гэдэгт гэрээ хэлцэлийн дагуу хөрөнгө (валют гэх мэт) эсвэл үйлчилгээний хэлбэрээр үнэ цэн хангах замаар бий болгосон гэж ойлгодог, мөн ирээдүйн тодохой тодорхой үед хөрөнгө (валют гэх мэт), үйлчилгээний хэлбэрээр нэг буюу хэд хэдэн удаагийн төлбөр хийх үүргийг зээлдэгчээс шаарддаг урсгал, өөрөөр хэлбэл болзошгүй бус, өр төлбөрийг хэлнэ. Эдгээр төлбөрийг гэрээний дагуу гарсан үндсэн өрийн болон / эсвэл хүүгийн өр төлбөрөөс хасалт хийж тооцно. Өр дараах хэд хэдэн үндсэн хэлбэртэй байх боломжтой. Үүнд:

- i. зээл, өөрөөр хэлбэл, (хадгаламж, бонд, үнэт цаасны, арилжааны зээл, худалдан авагчийн зээл гэх мэт) зээлдэгч нь ирээдүйд хөрөнгийг буцааж төлөх үүргийн үндсэн дээр зээлдүүлэгчийн олгосон мөнгөн урьдчилгаа болон зээлдэгч нь зээлсэн мөнгийг ирээдүйд ихэвчлэн хүүгийн хамт буцааж төлөх байдлаар худалдсан барьцаа хөрөнгөө худалдан авагчаас эргүүлэн худалдан авах (жишээ нь буцаан худалдан авах гэрээ, албан ёсны своп хэлцлийн гэх мэт) өөрөөр хэлбэл бүрэн барьцаалсан зээлийн эквивалент болох хөрөнгийн түр солилцоо;
- ii. нийлүүлэгчийн зээл, өөрөөр хэлбэл, бараа, үйлчилгээг нийлүүлсэн өдрөөс хойш хэсэг хугацаанд төлбөр хийх огноог хойшлуулахыг нийлүүлэгч зээлдэгчид зөвшөөрсөн гэрээ; болон
- iii. лизинг, өөрөөр хэлбэл, гэрээний үндсэн дээр хөрөнгө түрээслүүлэгчийн өмчлөлд үлдсэн байхад түрээслэгч, эд хөрөнгийн нийт хүлээгдэж буй ашиглалтын хугацаанаас ихэвчлэн богино хугацааны нэг буюу түүнээс дээш үеүүдэд ашиглах эрхийг эдлэх тохиролцоог хэлнэ. Энэхүү зааврын зорилгоор өр гэдэг бол гэрээний хугацаанд хийгдэх эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг хассан түрээсийн бүх төлбөрийн (түрээсийн эхэнд) өнөөгийн үнэ цэнэ юм.

(b) Өр гэж тооцсон гэрээний үүргийн дагуу төлбөр хийж чадаагүйгээс үүссэн хохирлыг өр гэнэ. Энэ тодорхойлолтын дагуу өр гэж үзээгүй төлбөрийн (жишээ нь, нийлүүлэлтийн төлбөрийн) үүргийг биелүүлээгүй бол өр үүсгэхгүй байх болно.



МОНГОЛ УЛС

2017 оны 4
дүгээр сарын 13

ОУВС-ГИЙН ДҮРМИЙН IV ЗААЛТЫН 2017 ОНЫ ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ӨРГӨДЛИЙН ТУХАЙ АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН ИЛТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАВСРАЛТ

Боловсруулсан

Ази, Номхон далайн газар (бусад газар, хэлтэтэй
хамтран)

АГУУЛГА

ОУВС-ТАЙ ХАРЬЦАХ ХАРИЛЦАА	2
ДЭЛХИЙН БАНК, ОУВС-ГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА	6
АХБ-ТАЙ ХАРЬЦАХ ХАРИЛЦАА	8
СТАТИСТИКИЙН АСУУДЛУУД	10
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД	13
ҮНДСЭН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ ХУУДСУУД	14

ОУВС-тай харьцах харилцаа

(2017 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар)

Гишүүнчлэлийн байдал: Элссэн: 1991 оны 2 дугаар сарын 14; Дүрмийн VIII заалт

Ерөнхий нөөцийн данс:	Сая ЗТЭ	Квотод эзлэх хувь
Квот	72.30	100.00
ОУВС-д хадгалуулсан нөөц	66.87	92.49
ОУВС дах нөөцийн позиц	5.44	7.52
ЗТЭ-ийн газар:	Сая ЗТЭ	Зарцуулсан хувь
Цэвэр өсөн нэмэгдсэн зарцуулалт	48.76	100.00
Нөөц	42.91	88.01
Худалдан авалт болон зээлийн үлдэгдэл:	Сая ЗТЭ	Квотод эзлэх хувь
Байхгүй		

Сүүлд авсан санхүүгийн дэмжлэг:

Хөтөлбөр	Баталсан огноо	Дуусгавар болсон огноо	Баталсан дүн (Сая ЗТЭ)	Ашигласан дүн (Сая ЗТЭ)
Стэндбай	04/01/2009	10/01/2010	153.30	122.64
ECF ¹	09/28/2001	07/31/2005	28.49	12.21
ECF ¹	07/30/1997	07/29/2000	33.39	17.44

ОУВС-д төлөх хугацаа хэтэрсэн төлбөрийн үүрэг болон өр төлбөрийн урьдчилсан тооцоо
(Сая ЗТЭ; нөөцийн өнөөгийн ашиглалт болон зээлжих тусгай эрхийн өнөөгийн нөөцөд суурилсан):

	Ирээдүйн				
	2017	2018	2019	2020	2021
Үндсэн өр					
хураамж / зээлийн хүү	0.02	0.03	0.03	0.03	0.03
Дүн	0.02	0.03	0.03	0.03	0.03

Эрсдэлийн үнэлгээ: Монголбанкны эрсдэлийн үнэлгээг 2002, 2003 болон 2009 онуудад хийсэн болно. Монголбанкны 2009 оны үнэлгээгээр санхүүгийн тайлагнал, аудитын практик ерөнхийдөө олон улсын стандартад нийцсэн болохыг тогтоосон байна. Төв банкны касс, зоорь зэрэгт нэвтрэх эрхийг аудиторуудад олгох замаар хөндлөнгийн аудитын механизмыг сайжруулах, Төв банкны тухай хуулийг боловсронгуй болгох, хяналтын зөвлөлийн үүргийг бэхжүүлэх зөвлөмж өгсөн байна. Монголбанкны эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийж байгаа бөгөөд хөтөлбөрийн эхний үнэлгээний үеэр дуусгавар болох төлөвтэй байна. Эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг гуравдугаар сарын эцэс, дөрөвдүгээр сарын эхээр ажилласан. Монголбанк нэр хүнд бүхий компаниудаар үргэлжлүүлэн аудит хийлгэж, санхүүгийн тайлангаа хэвлэн нийтлэж байна. Шинэчилсэн үнэлгээгээр төв банкны хяналт, засаглал, эрх зүйн орчин тэргүүн туршлага, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тавигдах шаардлагад хэр нийцэж байгааг үнэлэх болно.

^{1/} хуучнаар Ядуурлыг бууруулах, өсөлтийг дэмжих /PRGF/ хөтөлбөр.

Валютын зохицуулалт:

Валютын ханш зах зээлийн жамаар тогтох боломжийг бий болгох зорилгоор Монголбанкнаас гадаад валютын дуудлага худалдааг 2009 оны гуравдугаар сарын 24-нд анх зохион байгуулж нэвтрүүлсэн. Де факто болон де юре ханшийн зохицуулалт аль аль нь чөлөөт хөвөх гэсэн ангилалд багтаж байна.

Монгол улс Дүрмийн VIII заалтын 2, 3, 4-т дурдсан үүргийг 1996 оны хоёрдугаар сарын 1-нд хүлээн зөвшөөрсөн. ОУВС-гийн дүрэм журмын дагуу Монгол улс олон валютын хоёр ч системийг дагаж мөрдөж байна.

Нэгдүгээрт, олон үнийн дуудлага худалдааны тогтолцоо дуудлага худалдаагаар валютын худалдан авах ханш 2-оос дээш хувиар хэлбэлзэхгүй байхыг баталгаажуулах ямар ч механизм байдаггүй учраас олон валютын системийг үүсгэсэн байна. Захирлын зөвлөл 2010 оны зургадугаар сарын 22 хүртэл олон үнийн дуудлага худалдааны олон валютын системийг баталсан (2009 оны зургадугаар сарын 23-ны өдрийн 14365 тоот шийдвэр) бөгөөд цаашид сунгах асуудлыг 2012 оны гуравдугаар сарын 15 буюу эсвэл дараагийн Дүрмийн IV заалтын зөвлөлдөх уулзалтын аль түрүүлж болох хүртэл шийдсэн билээ (2010 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 14669 тоот шийдвэр болон 2011 оны гуравдугаар сарын 16-ны өдрийн 14365 тоот шийдвэр). Хэдий тийм ч, валютын олон ханшны тогтолцоог 2012 оны гуравдугаар сарын 15 гэхэд шийдэж чадаагүй бөгөөд олон үнийн олон валютын дуудлага худалдааны механизм байгаа цагт үргэлжлэн оршин тогтносоор байна. Тийм учраас, валютын олон ханшны тогтолцоог халаагүй бөгөөд энэхүү тогтолцоог батлах шалгуур үзүүлэлт ч байхгүй учраас ажлын хэсэг Захирлын зөвлөлөөс дээрх арга хэмжээг батлах талаар зөвлөмж гаргаагүй. Үүний зэрэгцээ, Монгол улс валютын албан ханш (reference rate)-тай бөгөөд үүнийг засгийн газрын гүйлгээнд албан журмаар ашигладаг. Тийм учраас, албан ёсны дуудлага худалдаагаар эрх баригчид зах зээлийн сегментчлэлийг бий болгосон байна.

Монголбанкны ерөнхийлөгчийн 2010 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 699 тоот тушаалаар тухайн өдрийн албан ханшийг өмнөх өдрийн 1600 цагаас тухайн өдрийн 1600 цаг хүртэл ашигласан зах зээлийн жигнэсэн дундаж ханш дээр үндэслэсэн тодорхойлно гэж заасан боловч, энэ тушаалаар зах зээлийн сегментчилэл болон түүнээс үүдэх үйлчилж буй ханшны олон төрөлт байдлыг арилгахгүй гэж ажлын хэсэг үзэж байна.

Ийм учраас, арилжааны ханш болон албан ханшны хоорондын зөрөө 2-оос дээш хувиар хэлбэлзэхгүй байхыг хангах механизм байхгүй байгаа тул энэхүү албан ханшийг Засгийн газрын ажил гүйлгээнд ашиглаж байгаа нь валютын олон ханшны тогтолцоог бий болгож байгаа учраас ОУВС-гийн зөвшөөрөл шаардлагатай байна. Энэхүү валютын олон ханшны тогтолцоог батлах шалгуур үзүүлэлт байхгүй байгаа учраас түүнийг баталсан, зөвшөөрсөн шийдвэр гаргах боломжгүй хэвээр байна.

Монгол улс аюулгүй байдлын шалтгаанаар ОУВС-гийн 144 (11/4/94) тоот шийдвэр ёсоор мэдэгдэл хүргүүлсэн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Югославын Холбооны Бүгд Найрамдах Улс (Серби ба Монтенегро)-тай хийх зарим гүйлгээний тухай тогтоол № 92/757-ын дагуу валютын гүйлгээний хязгаарлалт ногдуулдаг.

Монголбанк өнөөг хүртэл олон үнийг дуудлага худалдааны ханш 2-оос дээш хувиас давж хэлбэлзсэн ямар ч тохиолдол гарч байгаагүй болохыг мэдэгдсэн бөгөөд бас мөн цаашид ч ийм тохиолдол гаргуулахгүй байх механизм нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа цохон тэмдэглэсэн. Монголбанк бас жишиг /indicative/ спот ханшийг боловсруулах чиглэлээр ажиллаж байна.

Дүрмийн IV заалтын зөвшилцөх уулзалт:

Захирлын зөвлөл 2015 оны Дүрмийн IV заалтын зөвшилцөх уулзалтыг 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөр дуусгавар болголоо (ОУВС-гийн улсын тайлан No. 15/109). Монгол улстай 12 сард нэг удаа зөвшилцөх уулзалт хийдэг.

Ажиглалтын стандарт, дүрмийн үнэлгээ

Ажиглалтын стандарт, дүрмийн тайлан / **ROSC** /-гийн дараах үнэлгээ хийсэн байна. Үүнд: Мэдээлэл түгээх (2001 оны 5 дугаар сар), Төсвийн ил тод байдлын модуль (2001 оны арваннэгдүгээр сарын), Төсвийн шинэчлэлийн (2005 оны тавдугаар), Мэдээлэл түгээх (2008 оны дөрөвдүгээр сар), Мөнгөний болон Төсвийн бодлого Ил тод байдал (2008 оны 9 дүгээр сар), Банкны хяналт шалгалт (2008 оны 9 дүгээр сар).

Сүүлд хэрэгжүүлсэн санхүүгийн хөтөлбөрүүд:

18 сарын хугацаатай, 153,3 сая ЗТЭ (квотын 300 хувь)-тэй тэнцэх хэмжээний Стэндбай хөтөлбөрийг 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр баталсан. Хөтөлбөрийн эцсийн үнэлгээг Захирлын зөвлөлөөр 2010 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр амжилттай баталсан.

Санхүүгийн секторын үнэлгээний хөтөлбөр дэх оролцоо:

Монгол улс Санхүүгийн секторын үнэлгээний хөтөлбөр /ССҮХ/-т оролцож байгаа. ССҮХ-ийн эхний, хоёр дахь болон гурав дахь ажлын хэсэг 2007 оны тав, ес болон арван нэгдүгээр сард тус тус ирж ажилласан болно. Хамгийн сүүлчийн тайлан (ОУВС-гийн улсын тайлан No. 11/107)-г 2011 оны 5 дугаар сард хэвлэн нийтлэсэн болно.

2015-2017 онд хэрэгжүүлсэн техник туслалцаа: Ажлын хэсгүүд:

- Дунд хугацааны төсвийн хүрээ, (Төсвийн удирдлагын газар), 2015 оны 1 дүгээр сар
- Системийн хяналт ба хямралд бэлтгэгдсэн байдал (Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн газар), 2015 оны 1-2 дүгээр сар
- Банкны хяналт шалгалт (Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн газар), 2015 оны 1-2 дүгээр сар
- Гадаад секторын статистик (Статистикийн хэлтэс), 2015 оны 2 дугаар сар
- Үндэсний тооцоо (Статистикийн хэлтэс), 2015 оны 3 дугаар сар
- Засгийн газрын санхүүгийн статистик (Төсвийн удирдлагын газар), 2015 оны 3 дугаар сар
- Дунд хугацааны төсвийн хүрээ, (Төсвийн удирдлагын газар), 2015 оны 3-4 дүгээр сар
- Уул уурхайн орлогын туршилтын судалгаа (Төсвийн удирдлагын газар), 2015 оны 3 дугаар сар
- Татварын удирдлага (Төсвийн удирдлагын газар), 2015 оны 3 дугаар сар
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (Хуулийн хэлтэс), 2015 оны 9 дүгээр сар
- Засгийн газрын үнэт цаасны хоёр дахь зах зээлийн хөгжил (Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн газар), 2015 оны 9-10 дугаар сар
- Үндэсний баялгийн сан байгуулах (Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн газар), 2015 оны 9-10 дугаар сар
- Банкны хяналт шалгалт ба зохицуулалт (Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн газар), 2015 оны 9-10 дугаар сар
- Засгийн газрын санхүүгийн статистик (Төсвийн удирдлагын газар/Статистикийн хэлтэс), 2015 оны 10-11 дүгээр сар
- Гадаад секторын статистик (Статистикийн хэлтэс), 2015 оны 11 дүгээр сар
- Макро-төсвийн асуудлууд (Төсвийн удирдлагын газар), 2015 оны 11-12 дугаар сар
- Үндэсний тооцоо (Статистикийн хэлтэс), 2015 оны 12 дугаар сар
- Макро-төсвийн асуудлууд (Төсвийн удирдлагын газар), 2016 оны 3-4 дүгээр сар
- Засгийн газрын нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн тайлагналыг сайжруулах (Статистикийн хэлтэс, Төсвийн удирдлагын газар), 2016 оны 4 дүгээр сар
- Татварын удирдлага (Төсвийн удирдлагын газар), 2016 оны 4 дүгээр сар
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (Хуулийн хэлтэс), 2016 оны 4 дүгээр сар
- Үндэсний тооцоо (Статистикийн хэлтэс), 2016 оны 9 дүгээр сар

- Улсын секторын нягтлан бодох бүртгэл, 2016 оны 11-12 дугаар сар
- Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ /PIMA/-ний ажлын хэсэг (Төсвийн удирдлагын газар), 2016 оны 11-12 дугаар сар
- Макро-төсвийн асуудлууд (Төсвийн удирдлагын газар), 2016 оны 11-12 дугаар сар
- Мөнгөний болон гадаад валютын гүйлгээ (Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн газар), 2017 оны 2 дугаар сар
- Орлого дайчлах тусгай сан /RMTF/-ийн төсөл хөгжүүлэх ажиллагааны хүрээнд хийсэн НӨАТ-ын зөрүүний шинжилгээ (Төсвийн удирдлагын газар), 2017 оны 2 дугаар сар
- RMTF төсөл хөгжүүлэх ажиллагаа (Төсвийн удирдлагын газар), 2017 оны 2 дугаар сар
- RMTF төсөл хөгжүүлэх ажиллагааны хүрээнд хийсэн НӨАТ-ын зөрүүний шинжилгээ (Төсвийн удирдлагын газар), 2017 оны 2 дугаар сар
- Зарим асуудал болон НӨАТ-ын хэрэгжилт (Төсвийн удирдлагын газар), 2017 оны 3 дугаар сар
- Санхүүгийн зохистой байдлын үзүүлэлтүүдийг тооцохуй (Статистикийн хэлтэс), 2017 оны 3 дугаар сар

Суурин төлөөлөгч:

Ноён Нэйл Сэйкер 2015 оны 4 дүгээр сараас Улаанбаатарт суух суурин төлөөлөгчөөр ажиллаж байна.

ДЭЛХИЙН БАНК, ОУВС-ГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. **Дэлхийн банк, ОУВС-гийн Монгол улсыг хариуцсан ажлын хэсгүүд нягт уялдаа холбоотой хамтран ажилладаг.** Ноён Жон Литвак (Дэлхийн банкны Макро эдийн засаг, төсвийн удирдлагын дэлхийн практикийн газар /GMFDR/-ын ерөнхий эдийн засагч) болон ноён Коши Матай (Ажлын хэсгийн ахлагч Ази, Номхон далайн газарт харъяалагддаг) нарын удирдсан ажлын хэсгүүд макро эдийн засгийн болон бүтцийн асуудлуудын хүрээнд хамтран ажиллаж байна.
2. **Хамтын ажиллагаа, зохицуулалт үлгэр жишээч хэрэгжиж байна.** Энд дараах зүйлийг хамруулж болох байна. Үүнд:
 - **ОУВС-гийн тандан хяналт.** Дэлхийн банкны ажилтнууд ОУВС-гийн боловсруулсан баримт бичигт тайлбар өгөх, эрх баригчидтай хийх Дүрмийн IV заалтын зарим зөвшилцөх уулзалт болон хөтөлбөрийн ажлын хэсгийн зарим уулзалтанд оролцдог. Улмаар хоёр байгууллагын сонирхол давхацсан банкны бүтцийн өөрчлөлт, нийгмийн хамгааллын шинэчлэл, болон төсвийн бодлого зэрэг асуудлаар бодлогын хэлэлцүүлгийг хийхэд дөхөмтэй байдаг.
 - **Хөгжлийн бодлогын санхүүжилт болон Түншлэлийн стратеги.** Үүний зэрэгцээ, ОУВС-гийн мэргэжилтнүүд Дэлхийн банкны Хөгжлийн бодлогын санхүүжилтийн төсөл боловсруулах, хянах ажиллагаанд оролцож, 2013-17 оны Банкны Монгол улстай хамтран ажиллах Түншлэлийн стратегийн талаар мэдээллээр хангагдаж ирсэн билээ.
 - **Банкны системийн асуудлууд.** Энэ чиглэлээр 2 байгууллагын Монголыг хариуцсан багийнхан техникийн туслалцааны ажлын хэсэг томилж ажиллуулах зэргээр идэвхтэй ажиллаж байна. Багууд аливаа давхардалаас зайлсхийхийн зэрэгцээ эрх баригчдад харилцан уялдаатай зөвлөгөө өгөх тал дээр нягт хамтран ажиллаж байна. Хоёр байгууллага шинэчлэлийн хөтөлбөрт шаардлагатай улс төрийн дэмжлэгийг дайчлах хүчин чармайлтынхаа хүрээнд банкны салбарын асуудлаар олон нийт болон УИХ-д сургалт явуулах ажиллагаагаа үргэлжлүүлнэ.
 - **Бүтцийн өөрчлөлт.** Зарлагын удирдлагын асуудлаар, тухайлбал Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, ашигт малтмалын салбарын татварын тогтолцоо, болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн талаар техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр ОУВС, Дэлхийн банкны ажилтнууд амжилттай хамтран ажилласан. Мөн түүнчлэн, Монгол улсын санхүүгийн удирдлагын системийн цуврал үнэлгээний түүний дотор Төсвийн зардал, санхүүгийн хариуцлага (PEFA)-ын тогтолцоо болон Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ тайлан дээр идэвхтэй хамтран ажилласан юм.
3. **Энэ нягт хамтын ажиллагаандаа үндэслэн Монгол улсын макро эдийн засгийн болон бүтцийн шинэчлэлийн тэргүүлэх чиглэлийн талаар Дэлхийн банк болон ОУВС хоёр ижил үзэл бодолтой байна.** Эдгээрт, эдийн засгийг тогтворжуулж, тэлэлт, агшилтын мөчлөгөөс зайлсхийхийн тулд макро эдийн засгийн бодлогыг чангатгах, эдийн засгийг төрөлжүүлэн дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангах үүднээс бүтцийн өөрчлөлт хийх, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах замаар ядуусыг хамгаалж, банкны салбарыг бэхжүүлэх зэрэг бодлогын тухайд нийтлэг байр суурьтай байна.
4. **Ажлын хэсгүүд цаашид ч нягт хамтран ажиллахаар тохиролцов.** Хоёр байгууллагын Монгол улсыг хариуцсан багуудын төлөвлөсөн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлийн хуваарийн хамт Хүснэгт 1-ээр харуулсан болно. Энэ нь хамтын ажиллагааны цаашдын нарийн ширийн зүйлийг ажлын шугамаар тухай тухай үед нь зөвшилцөөд явахаар тохиролцсон.

Хүснэгт 1. Монгол улс: Макро болон бүтцийн өөрчлөлтийн шинэчлэлийн амин чухал чиглэлээр Дэлхийн банк болон ОУВС-гаас төлөвлөж буй арга хэмжээний төлөвлөгөө

	Бүтээгдэхүүн	Хүлээгдэж буй хугацаа
<p>Дэлхийн банкны хөтөлбөр</p>	<p><u>Задлан шинжлэх болон зөвлөх үйлчилгээ</u></p> <p>Эдийн засгийн хагас жил тутмын тойм</p> <p>Эдийн засгийн сэдвээр хийх бодлогын тэмдэглэлүүд</p> <p>Санхүүгийн секторын хяналт үнэлгээ, бодлогын хэлэлцүүлэг (банкны хяналт шалгалт, хадгаламжийн даатгал, орон сууцны санхүүжилт, төлбөрийн систем, санхүүгийн чадвар болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зэрэг сэдвээр)</p> <p>Хөрөнгийн зах зээлийг бэхжүүлж, хөгжүүлэх техник туслалцаа</p> <p>Улсын зардлын тойм судалгаа</p> <p>Өрийн удирдлагыг сайжруулах техник туслалцаа</p> <p><u>Үйл ажиллагааны</u></p> <p>Хяналт шалгалтын ажлын хэсгүүд, олон салбар (төсвийн бодлого болон улсын зардлын систем, банк, нийгмийн халамж)-ын техник туслалцааны зээл</p> <p>Хөгжлийн бодлогын зээлийн бэлтгэл ажил</p> <p>Олон салбарын техник туслалцааны зээлийн 2 дахь үе шатны бэлтгэл ажил</p>	<ul style="list-style-type: none"> • Хэрэгжиж байгаа • Хэрэгжиж байгаа • Хэрэгжиж байгаа • Хэрэгжиж байгаа • 2017 оны 8 дугаар сар • Хэрэгжиж байгаа • Хэрэгжиж байгаа • Хэрэгжиж байгаа • Хэрэгжиж байгаа
<p>ОУВС-гийн ажлын хөтөлбөр</p>	<p>Дүрмийн IV заалтын зөвшилцөх уулзалтууд – Захирлын зөвлөлийн хурал</p> <p>Ажлын хэсэг</p>	<p>2013 оны 11 дүгээр сар, 2015 оны 4 дүгээр сар</p> <p>2014: 4, 6, 9, 12 дугаар сар 2015: 2, 6, 10 дугаар сар; 2016: 8 ба 10 дугаар сар; 2017: 2 дугаар сар</p>

АХБ-ТАЙ ХАРЬЦАХ ХАРИЛЦАА¹

Монгол улс 1991 оны 2 дугаар сард Азийн хөгжлийн банкны гишүүн улс болсон. АХБ хорь гаруй жилийн туршид тус улсын олон талт хөгжлийн санхүүгийн хамгийн том хандивлагч байсан бөгөөд Монгол улс АХБ-ны гишүүн улс болсноос хойш Японы Ядуурлыг бууруулах сан болон бусад тусгай сангуудыг оролцуулан тус банкнаас нийтдээ 1,7 тэрбум ам.долларын зээл, 177 сая ам.долларын буцалтгүй тусламж авсан байна. Энэ хугацаанд мөн 147,7 сая ам.долларын техник туслалцааны төсөл хэрэгжүүлсэн байна. АХБ Худалдааны санхүүжилтийн хөтөлбөрөөрөө дамжуулан 185 сая ам.долларын ЖДҮ-ийн худалдааны дэмжлэг үзүүлсэн байна. Үүний зэрэгцээ, жижиг дунд үйлдвэрт дамжуулан зээлдэх засгийн газрын бус ажиллагаанд 100 орчим сая ам.долларын дэмжлэг үзүүлсэн байна.

Монгол улс АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн зэрэгцээгээр 2011 оноос тус банкны энгийн хөрөнгийн эх үүсвэрээс зээлжих эрхтэй болсон билээ. Хэдий тийм ч, үүнээс хойш Монгол улс Азийн хөгжлийн сангаас буцалтгүй тусламж авах эрхгүй болсон. Энгийн хөрөнгийн эх үүсвэрээс зээлжих эрхтэй болсноор Монгол улс дахь АХБ-ны үйл ажиллагааны цар хүрээг мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлж төрөл бүрийн салбар дахь хөгжлийн хэрэгцээг илүү хангах боломжийг олгосон юм. Үүний дотор, санхүүгийн салбарын шинэчлэл, хотын дэд бүтэц, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд, улсын санхүү, нийгмийн хамгаалал, тээвэр, бүс нутгийн хамтын ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчныг хамгаалах зэрэг олон салбарт техникийн болон бодлогын дэмжлэг авах боломж олгосон юм.

Монгол улстай 2012-2016 хамтран ажиллах Түншлэлийн стратегиа АХБ-ны Захирлын зөвлөл 2012 оны дөрөвдүгээр сард баталсан юм. Энэхүү түншлэлийн стратегид дараах салбарт тэргүүлэх ач холбогдол өгсөн байна. Үүнд: тээвэр, эрчим хүч, усан хангамжийн дэд бүтэц; боловсрол, эрүүл мэндийн хүртээмж; тогтвортой, оролцоотой өсөлтийг дэмжихэд шаардлагатай бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг болно. Засгийн газрын тэргүүлэх чиглэлд гарсан 2014 оны өөрчлөлтийг тусгал болж хоёр төрлийн стратегийн зохицуулалтыг 2014-2016 оны Түншлэлийн түр стратегид хийсэн болно. Үүнд; (i) хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн болон хөдөө орон нутгийн хөгжил хийгээд санхүүгийн гэсэн хоёр салбарыг нэмж оруулах; ба (ii) хөгжлийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах үүднээс энгийн хөрөнгийн эх үүсвэрийн санхүүжилтийг жилийн 50 сая ам.доллараас жилийн 200 сая ам.доллар хүртэл нэмэгдүүлэх. Монгол улсын 2017-2020 оны Түншлэлийн стратеги боловсруулалтын шатандаа байна. Засгийн газрын тэргүүлэх чиглэл болон АХБ-ны байгууллагын стратегид нийцүүлэн Түншлэлийн стратегийн хамгийн чухал зорилго бол эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд Монгол улсад хүртээмжтэй өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх явдал болно. Үүний тулд, АХБ-ны үйл ажиллагаа эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг дэмжих; эдийн засгийн төрөлжилтийг дэмжих дэд бүтэц бий болгох; болон байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэх болно.

Түншлэлийн шинэ стратегийнхаа хүрээнд улс орныхоо эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, өсөлт болон ажил эрхлэлтийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ. Ур чадварыг хөгжүүлэх, уул уурхайн бус ажиллах хүчний оролцоо шаардсан салбарын ялангуяа хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй жижиг дунд үйлдвэрийн өсөлтийг урамшуулах чиглэлээр АХБ туслалцаа үзүүлнэ. Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийн салбарт их үнээр олдсон ахиц дэвшлээ эдийн засгийн мөчлөг дагасан хүндрэл бэрхшээл болон дотоодын хурдацтай шилжих хөдөлгөөнөөс хамгаалахын тулд АХБ-аас нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн энэ чиглэлийн бодлого, арга хэмжээ боловсруулах, удирдах засгийн газрын чадавхийг нэмэгдүүлнэ. Энд нийгмийн хамгааллын сүлжээг бэхжүүлэх, нийгмийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтыг хамруулж байгаа юм. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үүднээс санхүүгийн секторын тогтвортой байдлыг хангах тусгайлсан зорилго бүхий бүтцийн өөрчлөлтийн хурд, нөлөөллийг нэмэгдүүлэхэд мөн дэмжлэг үзүүлнэ.

8 ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН

¹ Мэдээ, мэдээллийг АХБ-ны ажлын хэсгээс гаргаж өгсөн болно.

Үүний зэрэгцээ, АХБ-ны үйл ажиллагаа нь Монгол улсын бүс нутгийн хамтын ажиллагаа, илүү гүн гүнзгий интеграцад зам харилцааг сайжруулах замаар нэгтгэж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, үйл ажиллагааг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

АХБ-ны дэмжлэгийн ерөнхий зорилго бол Зүүн хойд Азийн тээвэр, гадаад худалдааны эргэлтэнд Монгол улсын эзлэх байр суурийг бататгахад оршино. Хотжилтын асуудалд илүү цогцоор хандсанаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох замаар орон нутгийн эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэн амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх болно.

Эдийн засгийн өсөлтийг байгаль орчны хувьд илүү тогтвортой болгохын тулд АХБ-наас байгаль орчныг хамгаалах, нөөцийн зохистой ашиглалтыг дэмжих замаар байгалийн нөөцийн менежментийг сайжруулах арга замыг эрэлхийлж; техник туслалцаа үзүүлэх, холбогдох төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх болон дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх замаар, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өөрчлөлтийг бууруулах болон Парисын гэрээний хүрээнд авсан үндэсний үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд нь Монгол улсад дэмжлэг үзүүлнэ.

Монгол улс байгалийн гамшигт нэрвэмтгий учраас гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх хүчин чармайлтыг эрчимжүүлэх болно.

СТАТИСТИКИЙН АСУУДЛУУД

(2017 оны 3 дугаар сарын 29-ны байдлаар)

I. Тандан хяналтын тоо мэдээний нийцлийн үнэлгээ
<p>Ерөнхий: Гаргаж өгч байгаа мэдээлэл ОУВС-гийн тандан хяналтын хэрэгцээг ерөнхийд нь хангаж байгаа боловч ДНБ-ий тооцоолол болон үнийн индексийн зарим дутуу тоон мэдээллийг нөхөх арга учир дутагдалтай байна. Сайжруулбал зохих тэргүүлэх чиглэлд үндэсний тооцоо болон үнийн статистик, мөн түүнчлэн засгийн газрын санхүүгийн статистикийг шинэ аргачлалд шилжүүлэх зэрэг ажлууд орж байна.</p>
<p>Үндэсний тооцоо: Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь одоогийн байдлаар жил, улирлын ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон зардлын аргаар тооцон гаргаж байна. 2008 оны Үндэсний тооцооны системийг Монгол улс нэвтрүүлсэн бөгөөд энэ хүрээнд нөөц ашиглалтын хүснэгтийг жил бүр нэгтгэн гаргаж байгаа нь чанарын нэлээд ахиц дэвшил гарсны илэрхийлэл мөн. Үндэсний тооцоонд байгалийн баялгийн мэдээллийг эмхэтгэж ашигласан эх сурвалжийг сайжруулах зөвлөмжийг саяхан (2016 оны 9 дүгээр сар) томиллолтоор ажилласан ажлын хэсгээс өгсөн байна.</p>
<p>Үнийн статистик: ХҮИ-ийн тооцоонд 2010 оны өрхийн судалгааг ашиглан 2010 оны суурь он болгон ашигладаг. ҮСХ үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI)-ийг тооцож гаргадаг ба үнийн мэдээллийн цоорхойг импутацийн аргаар нөхдөг байна. Мөн, ҮСХ Улаанбаатар хотын Орон сууцны үнийн индексийг зэрэглэлээр ангилах аргазүй ашиглан холимог тохируулга хийж тооцож байна.</p>
<p>Засгийн газрын санхүүгийн статистик: Одоогийн байдлаар, Ази, Номхон далайн газар ашиглаж буй нэгдсэн төсвийн хагас жилийн болон жилийн санхүүгийн статистикийн тоо мэдээг нэгтгэхэд ашиглаж буй ойлголт, ангилал ба тодорхойлолт ерөнхийдөө 1986 оны Засгийн газрын санхүүгийн статистикийн газрын авлага /ЗГССГА/-ын удирдамжуудыг баримталж байгаа юм. Эрх баригчид ЗГССГА-ын 2001/2014 оны аргачлалд шилжих зорилготой байгаагаа илэрхийлсэн. 2001/2014 оны ЗГССГА-д суурилсан бэлэн мөнгөний эх үүсвэр, ашиглалтын тайлан (орлого, зарлага, актив, пассивын гүйлгээ)-ийн (бэлэн мөнгөний суурь ашиглан) нэгдсэн төсвийн сар, жил тутмын тоо мэдээг нэгтгэн түгээхэд нь ОУВС-гийн Статистикийн газар эрх баригчдад тусалдаг. Засгийн газрын санхүүгийн статистикийн техникийн туслалцааны хүрээнд 2015 онд ажилласан ажлын хэсэг Сангийн яамны хөтөлдөг аккруэл (Олон улсын улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт дээр суурилсан) дансдыг ашиглан засгийн газрын нэгдсэн тайлан тэнцэл болон улсын нэгдсэн төсвийн үлдэгдэл, урсгалын нэгдсэн толилуулгыг боловсруулж өгсөн юм. Ажлын хэсгээс мөн Улсын салбарын өрийн статистикийн Дэлхийн банкны цахим хуудсанд мэдээлэл өгдөггүй байсан учраас Улсын салбарын өрийн статистикийг тайлагнаж байх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн билээ. ОУВС-гийн Статистикийн газраас 2017 оны 3 дугаар сард Засгийн газрын санхүүгийн статистикийн семинар зохион байгуулсан бөгөөд эрх бүхий байгууллагад нэмэлт техникийн туслалцаа үзүүлсэн.</p>
<p>Мөнгө, санхүүгийн статистик: Эрх баригчид Мөнгө санхүүгийн статистикийн сүүлийн үеийн ажлын хэсгүүдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа учраас Монголбанкны мөнгө, санхүүгийн статистик <i>Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага</i> болон түүний <i>Тооцооллын удирдамж</i>-ид заасан нэр томьёо, тодорхойлолттой нийцэж байна. Тухайлбал, Монголбанкны зүгээс дахин худалдан авах гэрээ, хуримтлагдсан хүү, болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн зохистой ангиллыг бий болгох замаар мөнгөний мэдээний чанарыг сайжруулсан байна. Монголбанкны сар тутмын статистикийн товхимолд хадгаламж татан төвлөрүүлдэг хадгаламж, зээлийн хоршоодын мэдээллийг 2010 оны 2 дугаар сараас эхлэн, бас мөн зарим санхүүгийн бусад корпорациудын тоо мэдээг 2010 оны 5 дугаар сараас эхлэн хэвлэн түгээдэг болсноор мөнгөний статистикийн хамрах хүрээ нэлээд өргөжив. 2011 оны 7, 8 дугаар сард ажилласан ажлын хэсэг Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнадаг банк бус санхүүгийн байгууллага, даатгалын болон үнэт цаасны компаниудын тоо мэдээний чанарын асуудлыг авч хэлэлцэн эдгээр байгууллагуудын мэдээллийг агуулсан Санхүүгийн бусад байгууллагуудын тойм судалгаа хийж байх зөвлөмж өгсөн юм. Гэсэн хэдий ч, эрх бүхий байгууллагуудын хоорондын зохицуулалт хангалтгүй байсны улмаас энэ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Мөнгө, санхүүгийн статистикийн 2016 оны гарын авлага болон түүнийг тооцоолох зааврыг шинээр нэвтрүүлж байгаа энэ үед энэхүү зөвлөмж онцгой хамааралтай байна.</p>

<p>Санхүүгийн салбарын тандан хяналт: Санхүүгийн зохистой байдлын үзүүлэлтүүдийн хувьд одоогийн байдлаар Монгол улс ОУВС-гийн цахим хуудсаар түгээн дэлгэрүүлэх зорилгоор ямар нэгэн мэдээ хүргүүлдэггүй юм. Санхүүгийн зохистой байдлын үзүүлэлтүүдийг тооцож нэгтгэх тал дээр Монголбанк нэлээд туршлага хуримтлуулсан боловч мэдээ болон метамэдээллээ ОУВС-д хүргүүлж, http://fsi.imf.org цахим хуудсанд хэвлэн нийтлэх эрхийг олгох асуудлыг ажлын төлөвлөгөөндөө оруулж батлах шаардлагатай байгаа юм. ОУВС-гийн Статистикийн газраас 2017 оны 3 дугаар сард хадгаламж авагч байгууллагуудын Санхүүгийн зохистой байдлын үзүүлэлтүүдийн техник туслалцааны ажлын хэсэг томилж ажиллуулсан.</p>	
<p>Гадаад секторын статистик: Гадаад секторын статистикийн мэдээг нэгтгэхдээ Монголбанк 2016 оны Төлбөрийн тэнцэл болон гадаад хөрөнгө оруулалтын позицийн гарын авлагын 6 дахь хэвлэлд заасан статистикийн аргазүйг дагаж мөрддөг. 2015 оноос өмнөх мэдээллийг Төлбөрийн тэнцлийн гарын авлагын 5 дахь хэвлэл (BPM5)-д үндэслэн нэгтгэсэн. Гадаад гүйлгээний тайлагналын систем (ITRS)-ийг банк бус санхүүгийн байгууллагууд дагаж мөрдөх болсон, мөн шууд тайлагнадаг хувийн хэвшлийн байгууллагуудын тоог нэмэгдүүлснээр төлбөрийн тэнцлийн статистикийн хамрах хүрээг өргөтгөж чадсан юм. Монголбанк 2014 оны 5 дугаар сараас эхлэн 2012 оны гадаад хөрөнгө оруулалтын позицын мэдээг нэгтгэн ОУВС-гийн Статистикийн газарт хүргүүлдэг болсон байна. Цаашид сайжруулах дараах асуудлууд байна. Үүнд: (1) Сангийн яамтай хамтран гадаад өрийн улирал тутмын статистик мэдээг Дэлхийн банкны Гадаад өрийн улирал тутмын статистик мэдээ (QEDS)-ний цахим хуудсанд хэвлэн нийтлүүлэхээр хүргүүлж байх; болон (2) Улсын бүртгэлийн албаны аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн баазад тулгуурлан Монгол улсад бүртгэлтэй гадаадын шууд хөрөнгө оруулалттай бүх аж ахуйн нэгжүүдийг Монголбанкнаас гаргадаг Гадаад секторын статистик судалгаанд хамруулж чадаж байгаа эсэхийг тодорхойлох.</p>	
<p>II. Мэдээний стандарт ба чанар</p>	
<p>Монгол улс Мэдээлэл түгээх ерөнхий систем (GDDS)-д оролцдог.</p>	<p>Мэдээллийн Ажиглалтын стандарт болон журмын тайлан /ROSC/-гийн ажлын хэсэг 2000 оны 5 дугаар сард хийсэн макро эдийн засгийн статистикийн үнэлгээг шинэчлэхээр 2007 оны 9 дүгээр сард Монгол улсад ирж ажилласан. Тайланг 2008 оны 4 дүгээр сард хэвлэн нийтлэсэн болно.</p>

Монгол улс—Хүснэгт 2. Тандан судалгаанд шаардлагатай ерөнхий үзүүлэлтүүд

(2017 оны 3 дугаар сарын 29-ны байдлаар)

	Сүүлийн ажиглалтын огноо	Хүлээн авсан огноо	Мэдээний давтамж ⁶	Тайлагналтын давтамж ⁶	Нийтлэлийн давтамж ⁶	Меморандум үзүүлэлтүүд:	
						Мэдээний чанар-арга зүйн зохистой байдал ⁷	Мэдээний чанар – нарийвчлал ба найдвартай байдал ⁸
Валютын ханш	02/28/17	02/28/17	Ө	Ө	Ө		
Төв банкны гадаад нөөцийн актив, пассив ¹	02/21/17	02/21/17	Д	Д	Д		
Нөөц/суурь мөнгө	12/31/16	12/31/16	Д	Д	Д	БМ, ББМ, ББМ, ББМ	БМ, БМ, БМ, БМ, ОМГ
Мөнгөний нийлүүлэлт	12/31/16	12/31/16	Д	Д	Д		
Төв банкны тайлан тэнцэл	12/31/16	12/31/16	С	С	С		
Банкны системийн нэгдсэн тайлан тэнцэл	12/31/16	12/31/16	С	С	С		
Зээлийн хүү ²	02/21/17	02/21/17	Д	Д	Д		
Хэрэглээний үнийн индекс	12/31/17	12/31/17	С	С	С	БМ, ББМ, БМ, БМ	ББМ, ББМ, ББМ, БМ, БМ
Нэгдсэн төсөв ⁴ -ийн орлого, зарлага, тэнцэл болон санхүүжилтийн эх үүсвэрийн бүтэц ³	12/31/16	1/16/17	С	С	С	ББМ, БМГ, ББМ, БМ	ББМ, БМ, ББМ, ББМ, БМГ
Засгийн газрын өрийн болон Засгийн газрын баталгаа гаргасан өрийн үлдэгдэл ⁵	12/31/16	12/31/16	У	У	У		
Гадаад урсгал дансны тэнцэл	02/28/17	03/15/17	С	С	С	БМ, БМ, БМ, ББМ	ББМ, БМ, ББМ, ББМ, ББМ
Бараа, таваарын экспорт, импорт	02/28/17	03/15/17	С	С	С		
ДНБ/ҮНО	2016-IV	02/15/17	У	У	У	БМ, БМГ, БМ, ББМ	БМ, ББМ, ББМ, ББМ, БМГ
Нийт гадаад өр	2016-IV	01/31/17	У	У	У		

¹ Барьцаалсан эсвэл өөр бусад байдлаар битүүмжлэгдсэн нөөц хөрөнгө, түүнчлэн үүсмэл хэрэгслийн цэвэр позицийг хамруулна.

² Хямдруулалтын хувь хэмжээ, мөнгөний зах зээлийн болон Засгийн газрын үнэт цаас, бондын хүү зэргийг оролцуулан зах зээлийн болон албан ёсоор тогтоосон аль алиныг хамарна.

³ Гадаад, дотоодын банкны болон дотоодын банк бус байгууллагын санхүүжилт.

⁴ Улсын нэгдсэн төсөв, төвлөрсөн төсөв (төсвийн сангууд, төсвийн шинжтэй сангууд болон нийгмийн даатгалын сангууд) болон орон нутгийн төсвөөс бүрдэнэ.

⁵ Валютын болон хугацааны бүтцийг оролцуулан.

⁶ Өдөр тутмын (Ө), долоо хоног тутмын (Д), сар тутмын (С), улирлын (У), жилийн (Ж), тогтмол бус (ТБ), мэдээ байхгүй (МБ).

⁷ Мэдээний Ажиглалтын стандарт, журмын тайлан /ROSC or the Substantive Update/ эсвэл түүний шинэчилсэн хувилбар (2008 оны дөрөвдүгээр сард хэвлэгдсэн ба есдүгээр сарын 1-28-ны өдрүүдэд ажилласан ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн)-ын дагуу хийж гүйцэтгэсэн үнэлгээний тусгал болон мөр тус бүрийн хувьсагчид харгалзах мэдээний санд зориулсан заасан үнэлгээг харуулж байна. Үнэлгээ ойлголт, тодорхойлолт, цар хүрээ, ангилал / салбарын ангилал болон бүртгэлийн суурийн хувьд олон улсын стандарт бүрэн мөрдөгдөж байгааг (БМ); бараг бүрэн мөрдөгдөж байгааг (ББМ); бараг мөрдөгдөөгүй (БМГ), огт мөрдөгдөөгүй (ОМГ); болон мөрдөж байгаа нь тодорхойгүй (ТГ) тэмдэглэлээр тус тус харуулна.

⁸ Тус бүрийн эх сурвалжийн өгөгдөл, мэдээллийн эх үүсвэр, статистикийн арга техник, үнэлгээ, завсрын мэдээ, статистик арга техник, шалгалт судалгааны баталгаажуулалтын үнэлгээний талаарх олон улсын стандартад зааснаас бусдаар бол 7 дугаар зүүлтэд заасантай адил.

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД^{1/}

	2004	2014	2015
Зорилго 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах 2/			
15-24 насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн харьцаа, хувиар (үндэсний тооцоолол)
15-с дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн харьцаа, хувиар (үндэсний тооцоолол)	56.50
Хөдөлмөр эрхэлж буй хүнд ногдох ДНБ (2011 оны худалдан авах чадварын паритет (ХАЧП), ам.доллараар)	12,222.86	22,450.35	...
Хүн амын доод 20 хувийн орлогын хувь хэмжээ	...	8.08	...
5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь	4.80
Ядуурлын түвшин буюу өдрийн 1.90 ам.доллараас доош орлоготой иргэдийн хүн амд эзлэх хувь (2011 ХАЧП)	...	0.22	...
Ядуурлын гүнзгийрэлт, хувиар (2011 оны ХАЧП)	...	0.03	...
Хувиараа хөдөлмөр эрхэлж буй эрчүүдийн харьцаа (нийт хөдөлмөр эрхэлж буй эрчүүдэд эзлэх хувиар)
Зорилго 2: Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших 3/			
Бичиг үсэг тайлагдалтын хувь, залуу эмэгтэй (15-24 насны эмэгтэйчүүдийн эзлэх %)	98.98
Бичиг үсэг тайлагдалтын хувь, залуу эрэгтэй (15-24 насны эрэгтэйчүүдийн эзлэх %)	98.05
Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь
Бага сургууль дүүргэлтийн хувь, нийт (холбогдох насны бүлгийн %)	97.78	109.85	...
Бага сургуульд хамрагдсан охидын цэвэр харьцаа (бага сургуулийн насны хүүхдэд эзлэх %)	92.86	94.99	...
Бага сургуульд хамрагдсан хөвгүүдийн цэвэр харьцаа (бага сургуулийн насны хүүхдэд эзлэх %)	92.82	96.24	...
Зорилго 3: Хүйсийн тэгш байдлыг дэмжих, шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн оролцоог			
УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	6.80	14.90	14.50
Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь	51.20
Эмэгтэй, эрэгтэй хөдөлмөр эрхлэгчдийн харьцаа, хувиар (үндэсний тооцоолол)	96.31
Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах 5/			
Улаан бурхны эсрэг вакцинжуулалтанд хамрагдсан 12-23 сартай хүүхдийн хувь	99	98	98
Нялхсын эндэгдэл (1,000 амьд төрөлтөд)	37.30	19.90	19.00
5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл (1,000 амьд төрөлтөд)	46.80	23.50	22.40
Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах 6/			
Өсвөр насныхны нөхөн үржихүйн түвшин (15-19 насны эмэгтэйчүүд, 1,000 төрөлтөд)	20.54	16.34	15.00
Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь (%)	99.70	98.90	...
Жирэмслэлтээс сэргийлж буй 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь хэмжээ	...	54.60	...
Эхийн эндэгдлийн түвшин /100,000 амьд төрөлт тутамд/	105	46	44
Төрөлтийн өмнөх эрүүл мэндийн үйлчилгээ авсан жирэмсэн эхчүүдийн хувь	...	98.70	...
Жирэмслэлтээс сэргийлэх хэрэгцээ хангагдаагүй (15-49 насны гэр бүлтэй эмэгтэйчүүдэд эзлэх хувийн жин)
Зорилго 6: Бэлгийн замын халдварт өвчин, Хүний дархлал хомсдлын вирус /ХДХВ/, Дархлалын олдмол хомсдол /ДОХ/, Сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах 7/			
Бэлгэвчний хэрэглээ (15-24 насны эмэгтэйчүүдийн эзлэх %)
Бэлгэвчний хэрэглээ (15-24 насны эрэгтэйчүүдийн эзлэх %)
Сүрьеэ өвчний тархалт /100,000 хүн тутамд/	428	428	428
Сүрьеэ өвчний илрүүлэлтийн түвшин (бүх төрлийн, хувиар)	42	36	37
15-49 насны хүн амын дунд ДОХ өвчний тархалт, хувиар	0.10	0.10	0.10
15-24 насны эмэгтэйчүүдийн дунд ДОХ өвчний тархалт, хувиар	0.10	0.10	0.10
15-24 насны эрэгтэйчүүдийн дунд ДОХ өвчний тархалт, хувиар	0.10	0.10	0.10
Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах 8/			
Нүүрс хүчлийн хийн хэмжээ (кг, 2011 оны ДНБ-ий ХАЧП)	0.60
Нүүрс хүчлийн хийн хэмжээ (нэг хүнд ногдох метр тон)	3.43
Ойт нутгийн эзлэх хувь	7.33	8.14	8.08
Ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх (нийт хүн амд эзлэх хувиар)	51.90	59.10	59.70
Усны хангамжийг нэмэгдүүлэх (нийт хүн амд эзлэх хувиар)	59.60	64.20	64.40
Нэг хүнд ногдох ХАЭТ (тухайн оны ам.долл.)	103.32	108.13	...
Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх 9/			
Өрийн үйлчилгээ (бараа, үйлчилгээ, орлогын экспортод эзлэх хувиар)	2.93
Үүрэн утас хэрэглэгчдийн тоо /1000 хүн тутамд/	17.17	105.06	104.96
Суурин утасны тоо /1000 хүн тутамд/	5.85	7.92	8.75
Интернет хэрэглэгчдийн тоо /100 хүн тутамд/	...	19.94	21.44
Бусад			
Нөхөн үржихүйн харьцаа (нэг эмэгтэйд ногдох төрөлтийн хэмжээ)	2.12	2.66	...
Нэг хүнд ногдох ҮНБ, Атласын арга (тухайн оны ам.долл.)	760	4260	3870
ҮНБ, Атласын арга (тухайн оны тэрбум ам.долл.)	1.89	12.39	11.46
Хөрөнгийн нийт хуримтлал (ДНБ-д эзлэх хувиар)	31.18	35.18	27.02
Дундаж наслалт (жилээр)	64.73	69.46	...
15 наснаас дээш хүн амын бичиг үсэг тайлагдалтын хувь (%)	98.37
Нийт хүн ам (сая)	2.50	2.91	2.96
Худалдаа (ДНБ-д эзлэх хувиар)	131.33	109.32	90.35

Эх үүсвэр: Дэлхийн Банк, *Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд 2014* (2015 оны 10 сарын хувилбар) ба Энэтхэгийн Статистик, Хөтөлбөрийн Хэрэгжилтийн яам.

1/ Ихэнх үзүүлэлтүүдийн хувьд тоон мэдээлэл гарах боломжтой онуудыг хүснэгтэнд тусгасан болно.

2/ Ядуурлын шугамаас доогуур орлоготой хүмүүсийн эзлэх хувь хэмжээг 1990-2015 оны хооронд 2 дахин бууруулах.

3/ 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох.

4/ 2005 оноос өмнө бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 оноос өмнө боловсролын бүх шатанд хүйсийн эрх тэгш байдлыг хангах.

5/ Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн хувийг 1990-2015 оны хооронд 2/3 -р бууруулах.

6/ Эхийн эндэгдлийн хувийг 1990-2015 оны хооронд 3/4-р бууруулах.

7/ ХДХВ/ДОХ өвчний тархалтыг 2015 он гэхэд зогсоох, бууруулах. Хумхаа өвчин болон бусад өвчний дэгдэлтийг 2015 он гэхэд зогсоох, бууруулах.

8/ Тогтвортой хөгжлийн зарчмуудыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, байгаль орчинд учрах хохирлыг бууруулах. Баталгаат ундны ус хүртэх боломжгүй хүн амын хувь хэмжээг 2015 он гэхэд 2 дахин бууруулах. Орон гэргүй 100 сая хүмүүсийн амьжиргааны түвшинг 2020 он гэхэд үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх.

9/ Нээлттэй, хууль дүрэмд суурилсан, таамаглахуйц, үл ялгаварласан худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх. Буурай хөгжилтэй, далайд гарцгүй, жижиг арлын орнуудын онцлог хэрэгцээг тусган шийдэх. Өрийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор хөгжиж буй орнуудын өрийн асуудлыг үндэсний болон олон улсад хэрэглэдэг арга хэмжээг авах замаар шийдвэрлэх. Хөгжиж буй орнуудтай хамтран залуучуудад хандсан бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратегийг хэрэгжүүлэх. Эм хангамжийн байгууллагуудтай хамтран хөгжиж буй орнуудын иргэдийг үнийн хувьд боломжийн, нийтлэг хэрэгцээний эм, эмийн бэлдмэлээр хангах. Хувийн хэвшилтэй хамтран технологийн дэвшлийг нэвтрүүлэх.

ҮНДСЭН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ ХУУДСУУД

Үндэсний Статистикийн Хороо (www.nso.mn)

- Үндэсний тооцоо
- Хэрэглээний үнийн инфляци
- Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн
- Газрын тосны импорт
- Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ
- Нүүрсний үйлдвэрлэл
- Жижиглэнгийн үнэ
- Хөдөлмөр эрхлэлт
- Экспорт, импорт

Монголбанк (www.mongolbank.mn)

- Мөнгөний тойм
- Арилжааны банкуудын нэгдсэн тайлан тэнцэл
- Засгийн газрын бус секторт олгосон банкны зээл
- Засгийн газарт өгсөн цэвэр зээл
- Зээлийн хүү
- Төлбөрийн тэнцэл
- Үйлчилгээ, орлогын дансууд
- Монголбанкны гадаад албан нөөц
- Арилжааны банкны валютын гүйлгээний зарим үзүүлэлтүүд
- Валютын нэрлэсэн ба бодит ханш
- Үнэт цаасны зах зээлийн мэдээ
- Улсын төсвийн дансд

Сангийн яам (www.mof.gov.mn)

- Улсын төсвийн гүйлгээ

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (www.ndic.gov.mn)

- Урт болон дунд хугацааны хөгжлийн стратеги
- Эдийн засаг, нийгмийн бодлого
- Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалт
- Монгол улсын Хөгжлийн банк

Санхүүгийн зохицуулах хороо (www.frc.mn)

- СЗХ-ны шийдвэрүүд
- Хянан шалгадаг байгууллагуудын нийт актив (даатгалын компаниуд, үнэт цаасны компани, брокерийн пүүс, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод)
- Хянан шалгадаг байгууллагуудын орлогын нэгдсэн тайлан (даатгалын компаниуд, үнэт цаасны компани, брокерийн пүүс, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод)



МОНГОЛ УЛС

2017 оны 5-р
сарын 18

ОУВС-ГИЙН ДҮРМИЙН IV ЗААЛТЫН 2017 ОНЫ ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН БОЛОН ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ХҮСЭЛТ— НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ БА НЭМЭЛТ ҮҮРЭГ, АМЛАЛТЫН ЗАХИДАЛ

Баталсан:

Маркус Родлауер (Ази,
Номхон далайн газар) болон
Дарья Захарова (Стратеги,
бодлого хяналтын газар)

Ази, Номхон далайн газраас боловсруулав.

Энд ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийн ажлын хэсгийн 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн тайлан илтгэл (EBS/17/30) болон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтээс хойш гарсан өөрчлөлтийн талаар нэмэлт мэдээлэл өгч байгаа юм. Энэхүү нэмэлт мэдээлэл ажлын хэсгийн үнэлгээний чиглэлийг өөрчлөхгүй.

Эдийн засагт гарсан сүүлийн үеийн өөрчлөлтүүд

1. Үйл ажиллагаа сэргэж эхэлснээр энэ жилийн эдийн засгийн төлөвт өсөлтийн боломжит ашигтай байдлыг харуулж байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт Засгийн газрын хэрэглээний агшилтыг нөхөн илүү өсөлттэй гарснаар ДНБ-ий жилийн өсөлт эхний улиралд 4.2 хувь болж бүртгэгдсэн байна. Инфляци, үйл ажиллагааны сааралт (болон валютын ханшны уналтыг үл харгалзан)-аас улбаалан 2016 оны эцсээр бараг тэг хувь хүртэл унасан бол, дөрөвдүгээр сард хүнсний үнийн өсөлтийн улмаас жилийн 3½ хувь хүртэл өсчээ. Гадаад валютын нийт нөөцийн төвшин одоо ч сул дорой байгаа боловч, түүхий эдийн үнэ өссөн хийгээд экспорт хүлээгдэж байснаас хүчтэй гарсан учир бага зэрэг өссөн байна. Эцэст нь, төсвийн гүйцэтгэл хяналтад байна. Төсвийн алдагдал гуравдугаар сарын гүйцэтгэлээр ДНБ-ий 1 орчим хувьтай байна. Энэ жилийн зорилт 10½ хувьд барих ёстой юм.

ГШХО-ын валютын гүйлгээнд нөлөөлөх арга хэмжээ

2. ГШХО-ын төслүүдийн валютын гүйлгээг дотоодын банкуудаар дамжуулах зохицуулалтын арга хэмжээ хөтөлбөрийн макро эдийн засгийн тогтолцоог ганхуулах эрсдэлд оруулаа. Эрх баригчдын хөтөлбөрийн гол хэсгийг хэрэгжүүлэх чиглэлээр энэ оны дөрөвдүгээр сарын 20-нд баталсан УИХ-ын тогтоолын нэгэн заалтад гадаадын томоохон шууд хөрөнгө оруулалтын төслүүдийн борлуулалтын валютын орлогыг дотоодын банкны системээр дамжуулахыг шаардсан байна. Энэхүү заалт хөрөнгө оруулалтын орчинд сэргөөр нөлөөлж, хөтөлбөрийг макро эдийн засгийн тулгуур тооцоо, ялангуяа гадаадын шууд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн болон төлбөрийн тэнцлийн төлөвт сэргөөр нөлөөлөх ноцтой асуудал гэж үзсэн. Тийм учраас, Дүрмийн IV заалтын зөвлөлдөх хэлэлцүүлэг болон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах Монгол улсын хүсэлтийг анхлан 4 дүгээр сарын 28-нд Захирлуудын зөвлөлөөр авч хэлэлцэх байсныг энэхүү

асуудлыг шийдэх хүртэл хойшлуулсан болно. Монгол Улсын Их хурал 5 сарын 4-ний өдөр тогтоолынхоо шинэ хувилбарыг энэхүү заалтыг хасч баталснаар Монголын хөтөлбөрийг Захирлуудын зөвлөлөөр батлуулах замаа засч өгсөн билээ.

3. **Захирлуудын зөвлөлөөр асуудлыг авч хэлэлцэхийг хойшлуулсан явдал хөтөлбөрийн хяналт шинжилгээнд зарим зохицуулалт хийхэд хүргэв.** Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хянах огноог 4 дүгээр сарын эцсээс 6 дугаар сарын эцэс болгон, бас мөн дараа дараагийн хяналт үнэлгээын огноог харгалзах өөрчлөлт оруулж, зээлийн ашиглалын хуваарьт ч мөн холбогдох өөрчлөлтийг оруулав. (Хүснэгт 1-3-ыг үзнэ үү.) Эрх баригчдын зүгээс эдгээр нэмэлт өөрчлөлтийг оруулахыг хүссэн Нэмэлт үүрэг, амлалтын захидал (LOI)-ыг ажлын хэсгийн тайлангийн шинэчилсэн хүснэгтүүдийн хамт хавсаргав. Татварын хууль, тогтоомжийн мөрдөлтийг сайжруулах стратегийг хэрэгжүүлэх нь 4 дүгээр сарын эцсээр хангах ёстой байсан бүтцийн бэнчмарк шалгуур бөгөөд хугацаанд нь нэгэнт хангасан учраас хөтөлбөрийн бүтцийн хэлэлцэх асуудлаас хассан болно.

Ажлын хэсгийн үнэлгээ

4. **Ажлын хэсгийн үнэлгээ өөрчлөгдөөгүй.** Монгол улсын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт амин чухал ач холбогдолтой учраас хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах хүчин чармайлт үргэлжлүүлэн авах явдал түлхүүр тэргүүлэх чиглэл байх болно.

**Хүснэгт 1. Монгол Улс: Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлт
(Ажлын хэсгийн тайлангийн шинэчилсэн Хүснэгт 10)**

	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/30/2018
				Зорилтот үзүүлэлт
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт 1/ 2/				
Монголбанкны гадаад цэвэр албан нөөцийн өөрчлөлт/ГЦАН/ (доод хязгаар, өссөн дүнгээр, хугацааны эцсийн үлдэгдлийн өөрчлөлт, сая ам.доллараар, хөтөлбөрийн валютын ханшаар)	0	100	250	550
Монголбанкны дотоод цэвэр актив /ДЦА/ (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр, хөтөлбөрийн валютын ханшаар)	5,100	4,900	4,600	4,000
Нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл (доод хязгаар, төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр, тэрбум төгрөгөөр)	-850	-1,050	-1,500	-350
Засгийн газрын эсвэл Монголбанкны авсан эсвэл баталгаа гаргаж өгсөн нэг ба түүнээс дээш жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус шинэ гадаад өр (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар).	1,800	1,800	1,800	1,800
Засгийн газрын эсвэл МБ-ны баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдэл (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар)	850	850	750	750
Зорилтот үзүүлэлт (IT)				
Нөөц мөнгө (дээд хязгаар, тэрбум төгрөгөөр)	3,500	3,900	4,000	4,200
Гүйцэтгэлийн байнгын шалгуур үзүүлэлт				
Засгийн газрын эсвэл Монголбанкны авсан эсвэл баталгаа гаргаж өгсөн нэгээс доош жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус гадаад өр (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар).	0	0	0	0
Гадаад төлбөрийн төлөгдөөгүй шинэ өрийн хуримтлал (дээд хязгаар, хугацааны эцэс, сая ам.доллараар).	0	0	0	0
Меморандум үзүүлэлтүүд				
ОУВС-гийн хөтөлбөрийн суурь нөхцөлд тусгагдаагүй хоёр болон олон талт түншүүдээс авсан төсвийн дэмжлэг (хугацааны эцсийн үлдэгдэл, өссөн дүнгээр, сая ам.доллар)	257	427	597	783
Хөтөлбөрийн суурь үзүүлэлтийн хүрээнд Засгийн газрын (ХБ-ыг оролцуулан) авсан хөнгөлөлттэй бус цэвэр зээл (хугацааны эцсийн үлдэгдэл, өссөн дүнгээр, сая ам.доллараар)	20	20	20	20
Хөтөлбөрийн валютын ханш				
Төгрөг / ам.доллар	2489.4	2489.4	2489.4	2489.4
Ам.доллар / ЗТЭ	1.3	1.3	1.3	1.3
	1,142	1,142	1,142	1,142
Мөнгөжүүлсэн алтны үнэ (ам.доллар/унци)				
1/ Хөтөлбөрийн валютын ханшаар тооцсон.				
2/ Үндсэн тэнцлийн 2018 оны 1-р улирлаас бусад өсөөн дүнгээр тооцоолсон үзүүлэлтүүд нь 2016 оны 12-р сарын 31-ны тоонд суурьласан болно.				

Хүснэгт 2. Монгол улс: Өргөтгөсөн санхүүжилтийн эрх нээх хуваарь
(Ажлын хэсгийн тайлангийн шинэчилсэн Хүснэгт 9)

Богноо		Худалдан авалт		
		сая ЗТЭ	сая ам.долл.	Квотод эзлэх хувь
2017 оны 5 сарын 24	Өргөтгөсөн хөтөлбөрийг Захирлуудын зөвлөл батлах	27.956	37.82	38.67
2017 оны 9 сарын 15	2017 оны 6 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - эхний үнэлгээ	27.956	37.82	38.67
2017 оны 12 сарын 15	2017 оны 9 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - II үнэлгээ	27.956	37.82	38.67
2018 оны 3 сарын 15	2017 оны 12 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - III үнэлгээ	20.9598	28.35	28.99
2018 оны 6 сарын 15	2018 оны 3 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - IV үнэлгээ	26.2088	35.45	36.25
2018 оны 9 сарын 15	2018 оны 6 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - V үнэлгээ	26.2088	35.45	36.25
2018 оны 12 сарын 15	2018 оны 9 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - VI үнэлгээ	26.2088	35.45	36.25
2019 оны 3 сарын 15	2018 оны 12 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - VII үнэлгээ	26.2088	35.45	36.25
2019 оны 6 сарын 15	2019 оны 3 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - VIII үнэлгээ	26.2106	35.46	36.25
2019 оны 9 сарын 15	2019 оны 6 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - IX үнэлгээ	26.2106	35.46	36.25
2019 оны 12 сарын 15	2019 оны 9 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - X үнэлгээ	26.2106	35.46	36.25
2020 оны 3 сарын 15	2019 оны 12 сарын эцсийн байдлаар шалгуур үзүүлэлтийг хангах - XI үнэлгээ	26.2106	35.46	36.25
		314.5054	425.44	435.00

Хүснэгт 3 Монгол улс: Хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарь
(Ажлын хэсгийн тайлангийн шинэчилсэн хүснэгт) (сая ам.доллар)

	2017 оны II улирал	2017 оны III улирал	2017 оны IV улирал	2018 оны I улирал
Санхүүжилт	295	208	258	278
ОУВС	38	38	38	28
Олон улсын санхүүгийн бусад байгууллага, хоёр талын хандивлагчид	257	170	220	249

Сурвалж: ОУВС-гийн шинжээчдийн хэтийн тооцоо

Хүснэгт 4. Монгол Улс: ОУВС-гийн зээлийн үзүүлэлтүүд, 2017-22 (Ажлын хэсгийн тайлангийн шинэчилсэн Хүснэгт 8) (Сая ЗТЭ, өөрөөр заагаагүй бол)						
	Төсөөлөл					
	2017	2018	2019	2020	2021	2022
ОУВС-гийн үйлчилж буй болон ирээдүйн хөтөлбөрүүд						
Зээлийн ашиглалт	83.87	99.59	104.84	26.21		
Үлдэгдэл 1/	83.87	183.45	288.29	314.51	312.18	294.27
Төлбөрийн үүрэг 2/					10.72	26.09
Үндсэн өр (эргэн төлбөр/ дахин худалдан авалт)					2.33	17.91
Шимтгэл ба хүү	0.68	2.21	5.25	8.07	8.39	8.18
ОУВС-гийн үйлчилж буй болон ирээдүйн зээлийн үлдэгдэл 1/						
Квотод эзлэх хувиар	116.00	253.74	398.75	435.00	431.78	407.01
ДНБ-д эзлэх хувийн жингээр	1.10	2.34	3.37	3.44	3.17	2.72
Бараа, үйлчилгээний экспортод эзлэх хувийн жингээр	1.98	4.28	6.14	6.28	5.76	5.09
Нийт ашиглах боломжтой гадаад нөөцөд эзлэх хувийн жингээр	4.96	7.29	8.05	7.80	7.33	6.84
ОУВС-гийн үйлчилж буй болон ирээдүйн зээлийн төлбөрийн үүрэг						
Квотод эзлэх хувиар	0.94	3.06	7.26	11.16	14.83	36.09
ДНБ-д эзлэх хувийн жингээр	0.01	0.03	0.06	0.09	0.11	0.24
Бараа, үйлчилгээний экспортод эзлэх хувийн жингээр	0.02	0.05	0.11	0.16	0.20	0.45
Нийт ашиглах боломжтой гадаад нөөцөд эзлэх хувийн жингээр	0.04	0.09	0.15	0.20	0.25	0.61
Сурвалж: ОУВС-гийн Санхүүгийн газар болон ОУВС-гийн шинжээчдийн тооцоо, таамаглал. 1/ Хугацааны эцэст. 2/ Эргэн төлөх хуваарь нь өрийн үйлчилгээний төлбөрийн үүргийн хуваарийн дагуу хийгдсэн болно.						

Хүснэгт 5. Монгол Улс: Эргүүлэн төлөх чадварын үзүүлэлт, 2017–22 (Ажлын хэсгийн тайлангийн шинэчилсэн Хүснэгт 7) (Сая ЗТЭ, өөрөөр заагаагүй бол)						
	Төсөөлөл					
	2017	2018	2019	2020	2021	2022
ОУВС-гийн үйлчилж буй болон ирээдүйн хөтөлбөрийн зээл болон эргэн төлөлт						
Монгол улсад олгосон Ерөнхий нөөцийн данс /GRA/-ны зээл	83.87	183.45	288.29	314.51	312.18	294.27
Квотод эзлэх хувьгээр	116.00	253.74	398.75	435.00	431.78	407.01
Ерөнхий нөөцийн данс /GRA/-ны зээлийн өрийн үйлчилгээ	0.68	2.21	5.25	8.07	10.72	26.09
Үндсэн өр (эргэн төлөлт/ дахин худалдан авалт)					2.33	17.91
Шимтгэл ба хүү	0.68	2.21	5.25	8.07	8.39	8.18
Өр ба өрийн үйлчилгээний харьцаанууд (ДНБ-д эзлэх хувийн жин)						
Засгийн газрын болон ЗГ-ын баталгаа гаргасан өр	94.86	101.34	100.00	97.46	92.31	84.70
Санал болгож буй ОУВС-гийн зээлийг хассан дүн	93.77	99.00	96.63	94.02	89.14	81.98
Монгол улсад олгосон Ерөнхий нөөцийн данс /GRA/-ны зээл	1.10	2.34	3.37	3.44	3.17	2.72
Засгийн газрын болон ЗГ-ын баталгаа гаргасан өрийн үйлчилгээ	17.69	19.20	18.17	14.67	15.89	19.08
Санал болгож буй ОУВС-гийн зээлийг хассан дүн	17.68	19.17	18.11	14.58	15.78	18.84
Ерөнхий нөөцийн данс /GRA/-ны зээлийн өрийн үйлчилгээ	0.01	0.03	0.06	0.09	0.11	0.24
Өр ба өрийн үйлчилгээний харьцаанууд (Бараа, үйлчилгээний экспортод эзлэх хувийн жин)						
Засгийн газрын болон ЗГ-ын баталгаа гаргасан өр	171.01	185.46	182.44	178.13	167.39	158.51
Санал болгож буй ОУВС-гийн зээлийг хассан дүн	169.03	181.18	176.30	171.84	161.64	153.43
Монгол улсад олгосон Ерөнхий нөөцийн данс /GRA/-ны зээл	1.98	4.28	6.14	6.28	5.76	5.09
Засгийн газрын болон ЗГ-ын баталгаа гаргасан өрийн үйлчилгээ	31.89	35.13	33.14	26.81	28.81	35.70
Санал болгож буй ОУВС-гийн зээлийг хассан дүн	31.87	35.08	33.03	26.65	28.61	35.25
Ерөнхий нөөцийн данс /GRA/-ны зээлийн өрийн үйлчилгээ	0.02	0.05	0.11	0.16	0.20	0.45
Сурвалж: ОУВС-гийн Санхүүгийн газар болон ОУВС-гийн шинжээчдийн тооцоо, таамаглал.						

Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай албан хүсэлтийн захидал

2017 оны 5 дугаар сарын 17
Улаанбаатар

Хатагтай Кристин Лагард
Тэргүүн
Олон Улсын Валютын Сан
Вашингтон хот, К.Т. 20431

Хүндэт хатагтай Лагард,

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах Монгол улсын хүсэлтийг Захирлуудын зөвлөлөөр авч хэлэлцэх асуудлыг гадаадын шууд хөрөнгө оруулалттай төслүүдийн валютын орлогын гүйлгээг дотоодын банкуудаар дамжуулах тухай саяхан авсан арга хэмжээг цуцлах хүртэл хойшлуулсан болохыг бид ойлгож байна. Асуудлыг сайтар нягталж үзсэний үндсэн дээр УИХ энэхүү арга хэмжээг цуцлах тухай шийдвэрийг 5 сарын 4-ний өдөр гаргасан учраас Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах манай хүсэлтийг Захирлуудын зөвлөл 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа авч хэлэлцэнэ гэдэгт найдаж байна.

Хүсэлтийг хэлэлцэх хугацаа хойшлогдсонтой холбогдуулж үзүүлэлт шалгах огноо, хөтөлбөрийн үнэлгээний хуваарьт зарим өөрчлөлт оруулах шаардлага үүссэн. Тухайлбал, хөтөлбөрийн гүйцэтгэлийн үнэлгээ болон зээл ашиглалтын хуваарьт бид Хүснэгт А1 болон А2-т зааснаар өөрчлөлт оруулахыг санал болгож байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх эхний хоёр үнэлгээг бид 2017 оны 9 дүгээр сарын 30 болон 2017 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө тус тус хийхийг санал болгож байна. Өмнө нь 4 дүгээр сарын эцсийн бүтцийн бэнчмарк шалгуур байсан Татварын хууль, тогтоомжийн мөрдөлтийг сайжруулах стратегийн арга хэмжээг хугацаанд нь авч хэрэгжүүлж дуусгавар болсон тухай тайлагнахдаа бид баяртай байна.

Эдгээр нэмэлт өөрчлөлтийг эс тооцвол манай 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хөтөлбөр хэрэгжүүлэх тухай албан хүсэлтийн захидал, Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандум болон Техникийн санамж бичгийн агуулга хүчин төгөлдөр хэвээр байна. Эдгээр баримт бичигт тусгасан бодлогын арга хэмжээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай гэж бид үзэж байгаа хэдий ч хэрвээ шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ авахад бид бэлэн байна. Манай Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандумд заасан арга хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл хөтөлбөрийн зорилгоос зайлсхийсэн аливаа арга хэмжээ шинээр авах бол ОУВС-гийн бүх хөтөлбөрийн стандарт жишгийн дагуу бид ОУВС-тай урьдчилан зөвшилцөхөө үүгээр батлан илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,

/гарын үсэг зурсан/
Б.Чойжилсүрэн
Сангийн сайд

/гарын үсэг зурсан/
Н.Баяртсайхан
Монголбанкны ерөнхийлөгч

Хавсралтууд

Шинэчилсэн – Хүснэгт А1. Монгол Улс. Гүйцэтгэлийн тоон шалгуур үзүүлэлт

	6/30/2017	9/30/2017	12/31/2017	3/30/2018
			Зорилтот үзүүлэлт	
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт 1/ 2/				
Монголбанкны гадаад цэвэр албан нөөцийн өөрчлөлт/ГЦАН/ (доод хязгаар, өссөн дүнгээр, хугацааны эцсийн үлдэгдлийн өөрчлөлт, сая ам.доллараар, хөтөлбөрийн валютын ханшаар)	0	100	250	550
Монголбанкны дотоод цэвэр актив /ДЦА/ (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр, хөтөлбөрийн валютын ханшаар)	5,100	4,900	4,600	4,000
Нэгдсэн төсвийн үндсэн тэнцэл (доод хязгаар, төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр, тэрбум төгрөгөөр)	-850	-1,050	-1,500	-350
Засгийн газрын эсвэл Монголбанкны авсан эсвэл баталгаа гаргаж өгсөн нэг ба түүнээс дээш жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус шинэ гадаад өр (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар).	1,800	1,800	1,800	1,800
Засгийн газрын эсвэл МБ-ны баталгаа гаргасан гадаад өрийн үлдэгдэл (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар)	850	850	750	750
Зорилтот үзүүлэлт (IT)				
Нөөц мөнгө (дээд хязгаар, тэрбум төгрөгөөр)	3,500	3,900	4,000	4,200
Гүйцэтгэлийн байнгын шалгуур үзүүлэлт				
Засгийн газрын эсвэл Монголбанкны авсан эсвэл баталгаа гаргаж өгсөн нэгээс доош жилийн хугацаатай хөнгөлөлттэй бус гадаад өр (дээд хязгаар, хугацааны эцсийн үлдэгдэл, сая ам.доллараар).	0	0	0	0
Гадаад төлбөрийн төлөгдөөгүй шинэ өрийн хуримтлал (дээд хязгаар, хугацааны эцэс, сая ам.доллараар).	0	0	0	0
Меморандум үзүүлэлтүүд				
ОУВС-гийн хөтөлбөрийн суурь нөхцөлд тусгагдаагүй хоёр болон олон талт түншүүдээс авсан төсвийн дэмжлэг (хугацааны эцсийн үлдэгдэл, өссөн дүнгээр, сая ам.доллар)	257	427	597	783
Хөтөлбөрийн суурь үзүүлэлтийн хүрээнд Засгийн газрын (ХБ-ыг оролцуулан) авсан хөнгөлөлттэй бус цэвэр зээл (хугацааны эцсийн үлдэгдэл, өссөн дүнгээр, сая ам.доллараар)	20	20	20	20
Хөтөлбөрийн валютын ханш				
Төгрөг / ам.доллар	2489.4	2489.4	2489.4	2489.4
Ам.доллар / ЗТЭ	1.3	1.3	1.3	1.3
	1,142	1,142	1,142	1,142
Мөнгөжүүлсэн алтны үнэ (ам.доллар/унци)				
1/ Хөтөлбөрийн валютын ханшаар тооцсон.				
2/ Үндсэн тэнцлийн 2018 оны 1-р улирлаас бусад өсөөн дүнгээр тооцоолсон үзүүлэлтүүд нь 2016 оны 12-р сарын 31-ны тоонд суурьласан болно.				

Шинэчилсэн Хүснэгт А2. Монгол улс: Санал болгож буй урьдчилсан арга хэмжээ болон бүтцийн бэнчмаркууд

<p>Урьдчилсан арга хэмжээ</p> <p><i>Төсвийн талаар</i></p> <p>Хөтөлбөрийн зорилтуудад нийцсэн 2017 оны төсвийн тодотгол болон 2018-2020 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2017 оны зорилтуудыг хангах төсвийн бүхий л арга хэмжээг батлах</p> <p><i>Банкны талаар</i></p> <p>ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр банкуудад олон улсын нэр хүнд бүхий компаниудаар активын чанарын үнэлгээний худалдан авах ажиллагааг Монголбанкнаас эхлүүлэх.</p> <p><i>Мөнгөний бодлогын талаар</i></p> <p>Монголбанкны зүгээс орон сууцны хөтөлбөр болон аж ахуйн нэгжүүдэд зээл олгох зэргээр төсвийн шинжтэй бүхий л цэвэр санхүүжилтийг зогсоох талаар эрх баригчдын зүгээс ОУВС-гийн ажилтнуудад мэдэгдэнэ.</p>	<p>Дуусгавар болгох огноо</p> <p>(шинэ хөтөлбөрийг Захирлуудын зөвлөлөөр батлуулахаас өмнө дуусгавар болсон байна)</p>
<p>Бүтцийн бэнчмаркууд</p> <p><i>Төсвийн талаар</i></p> <p>ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр орлого нэмэгдүүлэх, тогтолцооны төвөгтэй байдлыг энгийн хялбар болгох, хүн амын орлогын татварын өсөн нэмэгдэх зарчмыг нэвтрүүлэх үүднээс татварын тогтолцоог хянаж үзэн хөрөнгө оруулалт, нэмэгдсэн өртгийн албан татвар, хүн амын орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувьд үр ашигтай, татварын тэгш байдлыг хангах талаар зөвлөмж гаргах ажлын хэсэг байгуулах.</p>	<p>2017 оны 8 дугаар сарын эцэс</p>
<p>Бүх төрлийн татварт хамаарах нийтлэг татварын удирдлагын зарчмыг нэгтгэсэн, татварын тогтолцооны уялдааг дэмжсэн, татвар төлөгчийн ашиг сонирхол болон татварын байгууллагын эрх мэдэл хоорондын зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн төслийг УИХ-д өргөн барих.</p>	<p>2017 оны 10 дугаар сарын эцэс</p>
<p>ОУВС-гийн техникийн туслалцаа зөвлөмжийн хүрээнд бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан хялбаршуулсан татварын тогтолцоо бий болгох тухай хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн барих.</p>	<p>2017 оны 10 дугаар сарын эцэс</p>
<p>2018 оны нэгдсэн төсвийг хөтөлбөрийн төсвийн зорилтот үзүүлэлтэд нийцүүлэн батлах.</p>	<p>2017 оны 11 дүгээр сарын эцэс</p>
<p>Олон улсын шилдэг туршлага, ОУВС-гийн зөвлөмжид үндэслэн төсвийн холбогдох хууль тогтоомжийг хянан шинэчлэх, төсвийн зөвлөлийг байгуулах тухай шинэ хууль батлан хэрэгжүүлэх.</p>	<p>2017 оны 12 дугаар сарын эцэс</p>
<p>Нэгдсэн төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулснаар 2018 оноос эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөр Сангийн сайдын өргөн барьсан төсөвт тусгагдсан төсвийн зардлын нийт дүнг нэмэгдүүлэх УИХ-ын бүрэн эрхийг хязгаарлах тухай (“нэмбэл хас” заалтыг оролцуулан) нэмэлт өөрчлөлт оруулах.</p>	<p>2017 оны 11 дүгээр сарын эцэс</p>
<p>Татварын ажлын хэсгийн тайланг Сангийн яаманд хүргүүлэх</p>	<p>2017 оны 12 дугаар сарын эцэс</p>

Шинэчилсэн Хүснэгт А2. Монгол улс: Санал болгож буй урьдчилсан арга хэмжээ болон бүтцийн бэнчмаркууд (төгсгөл)

<p>Нийгмийн хамгаалал Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг Монгол улсын нийт өрхийн хамгийн ядуу 40 хувийг зорилтот бүлэг болгон өөрчилж, гарсан хэмнэлтийг илүү чиглэсэн зорилтот хүнсний талоны хөтөлбөрт зориулна.</p>	2017 оны 12 сарын эцэс
<p>Мөнгөний бодлогын талаар Монголбанкны чиг үүргийг тодорхойлж, хараат бус байдал, засаглалыг бэхжүүлэн үйл ажиллагааг нь сайжруулах зорилгоор ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр Монголбанкны тухай шинэ хуулийг УИХ-д өргөн барих.</p>	2017 оны 11 сарын эцэс
<p>Монголбанкны тухай шинэ хуулийг батлах</p>	2018 оны 3 сарын эцэс
<p>Банкны салбарт ОУВС-гийн зөвлөмжийн дагуу Банкны тухай болон Монголбанкны тухай хууль, холбогдох дүрэм журамд дараахь нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Албадлагын арга хэмжээг урьдчилан авах тогтолцоог боловсронгуй болгох 2. Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци /ХДК/-тай хамтран банкныг татан буулгах хууль тогтоомж болон санхүүжилтийн хийгээд хамтын ажиллагааны тогтолцоог олон улсын шилдэг туршлагад нийцүүлэх 3. Банкуудын оношлох судалгаа, бизнес төлөвлөгөөний дүн шинжилгээний хариунд үндэслэн санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх, эсвэл одоогийн болон ирээдүйн зээлийн алдагдлаа тооцож шингээх зорилгоор өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, эрсдэлийн сан байгуулахыг банкуудаас шаардах тухайд Монголбанкинд хангалттай эрх мэдэл олгох 4. Активын чанарын үнэлгээ зэрэг хяналт шалгалтын зардлыг санхүүжүүлэх мөнгийг банкуудаас гаргуулах бүрэн эрхийг Монголбанкинд олгох 5. Хувь нийлүүлэгч, ТУЗ-ын гишүүд болон дээд шатны удирдлагад тавих ёс суртахууны шаардлагыг чангатгах 6. Банкнудын холбогдох этгээдүүд болон эцсийн үр өгөөж хүртэгч өмчлөгч нарт олгох зээлийн дээд хязгаарын талаарх дүрэм журмыг шинэчлэх 	2017 оны 11 сарын эцэс
<p>Хадгаламжийн даатгалын тухай хуульд Хадгаламжийн даатгагч нарын олон улсын холбооны “Хадгаламжийн даатгалын үр дүнтэй системийн үндсэн зарчим”-д нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	2017 оны 11 дүгээр сарын эцэс
<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /СТБЗ/ чанаргүй зээлийн асуудлыг шийдэх стратеги боловсруулна. Холбогдох бусад яам, тамгын газартай зөвшилцсөний үндсэн дээр СТБЗ дараах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажиллуулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> i. Өр барагдуулахад тулгарч буй асуудал, ялангуяа дампуурлын тухай болон шийдвэр гүйцэтгэх тухай хууль, татварын асуудал, чанаргүй зээлийг борлуулах, аутсорсинг хийхэд учирч буй хууль эрх зүйн болон зохицуулалтын холбоотой саад бэрхшээлийг тодорхойлж, задлан шинжилгээ хийх. ii. Тодорхойлсон саад бэрхшээлийг арилгах шат дараалсан ажлын төлөвлөгөө, хуваарь бүхий чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх стратеги боловсруулах 	2018 оны 1 дүгээр сарын эцэс
<p>Монголбанк, шинэчлэн сайжруулсан хууль, тогтоомжид үндэслэн холбогдох этгээдүүдэд олгосон зээлд үнэлгээ хийнэ</p>	2018 оны 9 дүгээр сарын эцэс
<p>Монголбанк активын ангилал болон эрсдлийн сан байгуулах тухай журамандаа ОУВС-гийн ажилтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулна.</p>	2017 оны 6 дугаар сарын эцэс
<p>Засгийн газрын сангуудын ашиглалтын тухай хуулийг батална.</p>	2017 оны 12 дугаар сарын эцэс

Монголыг хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч Кристин Баррон, Гүйцэтгэх захирлын ахлах зөвлөх Ил Янг Парк, Гүйцэтгэх захирлын зөвлөх Хүрэлбаатарын Ганцогт нарын 2017 оны 5 сарын 24-ны өдрийн мэдэгдэл

Монгол улс байгалийн асар их баялагтай, хүн ам нь залуу бөгөөд эрч хүчтэй учраас эдийн засгийн өсөлтийн ихээхэн нөөц боломжтой юм. Харин 2011 оноос түүхий эдийн үнэ ихээр унаж, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширсан, төсвийн сахилга бат суларсан зэргээс шалтгаалан 2011 онд 17 хувьтай байсан эдийн засгийн өсөлт 2016 онд 1 хувь хүртэл буурч, төсвийн алдагдал ДНБ-ний 17 хувь болж нэмэгдэн ажилгүйдэл хоёр оронтой тоонд хүрч, гадаад валютын нөөц шавхагдан улсын өр өсөхөд хүрлээ.

Энэ бол 2016 оны долдугаар сард ажлаа хүлээж авсан шинэ Засгийн газарт тулгарч буй эдийн засгийн нөхцөл байдал юм. Эрх баригчид Монгол улсын эдийн засгийн эдгээр хүндрэл бэрхшээлийг шийдэхийн тулд ОУВС-тай маш ажил хэрэгч яриа хэлэлцээ өрнүүлсний үндсэн дээр асар өндөр шаардлага бүхий Эдийн засгийг сэргээх хөтөлбөр боловсруулаад байна. Монгол улсын эрх баригчид ОУВС-гийн ажлын хэсгийнхэнд хөтөлбөрийн хэлэлцээний үеэр ажил хэрэгч иж бүрэн яриа хэлэлцээ өрнүүлсэнд гүнээ талархлаа илэрхийлсэн. Мөн эрх баригчид ОУВС-гийн ажлын хэсгийнхний эдийн засгийн нөхцөл байдал, хэтийн төлөвт хийсэн тэнцвэртэй үнэлгээний дүнтэй ерөнхийдөө санал нийлж байгаа бөгөөд бодлогын зөвлөмжийг нь тууштай хэрэгжүүлэх санаа зориг дүүрэн байна.

Эдийн засгийн сүүлийн үеийн өөрчлөлтүүд, цаашдын төлөв

Эдийн засаг 2017 оноос хойш өсөлтийн эрч хүчээ эргүүлж авна. Монгол улсын эдийн засгийн өсөлт 2017 онд багахан хэмжээгээр унах бөгөөд цаашдын уул уурхайн хөрөнгө оруулалтаар 2018 онд 1,8 хувиар өсөх бөгөөд 2019 он гэхэд 8.1 хувиар дорвитой өсөх болно. Эрх баригчид эдийн засгийн өсөлтийн төлөв байдлын талаарх ОУВС-гийн шинжээчдийн энэхүү үнэлгээтэй ерөнхийдөө санал нийлж байгаа боловч уул уурхайн салбараас үүдэлтэй эдийн засгийн илүү хурдтай өсөлтийн эрсдэл байгаа гэж үзэж байна. Эдийн засгийн өсөлт 2017 оны 1 дүгээр улиралд 1,3 хувьтай гарлаа. Хөдөө аж ахуй болон аялал жуулчлалын салбар эдийн засагт илүү ач холбогдол бүхий үүрэг гүйцэтгэх боломжтой боловч томоохон ордуудыг ашиглах өргөн дэлгэх нөөц боломж байгаа учраас Монгол улсын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай хэвээр байх болно гэсэн ОУВС-гийн ажлын хэсгийн дүгнэлттэй бид санал нэг байна.

Монгол улс зэс, коксжих нүүрс, алт болон бусад эрдэс баялгийн арвин их нөөцтэй юм. Дэлхийн хамгийн том зэс, алтны ордны нэг болох Оюу толгойн бүтээн байгуулалтын 6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт бүхий 2 дахь үе шат эхэлснээр, мөн 2018 оноос эхэлж Таван толгойн коксжих нүүрсний олборлолт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц нэмэгдэх юм.

Дэлхийн зах зээл дээрх зэс, алтны үнийн урт хугацааны төлөв тогтвортой байна. Коксжих нүүрсний зах зээлийн үнэ өнгөрсөн жилтэй харьцуулахад гурав дахин нэмэгдсэн явдал ойрын хугацааны эдийн засгийн өсөлтийн төлөвийг илүү эерэг болгож байна. Эрдэс түүхий эдийн үнэ өссөнөөр худалдааны тэнцлийн сэргэлтэд дэмжлэг үзүүлж, төсвийн хатуу байр суурьт хувь нэмэр оруулах боловч инфляцийн төвшин хөтөлбөрийн зорилтот хязгаарт түвшинд хэвээр байх төлөвтэй байна.

Монгол улс гадаад өрийн дефолтоос зайлсхийж чадсан нь ойрын болон дунд хугацааны төлөвт мэдэгдэхүйц эерэг хувь нэмэр орууллаа. Гадаад нөөцийн хэмжээ бага болсон, нийтдээ 1,2 тэрбум орчим ам.долларын богино хугацаат бондын төлбөрийн хугацаа 2017, 2018 болон 2019 онуудад дуусч буй нь Монгол улс олон улсын зээлдэгч нарын өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүж чадахгүйд хүрч, гадаад өрийн дефолт зарлах эрсдэл нүүрлэж байсан. Гэсэн хэдий ч, 2017 оны 2 дугаар сарын 16-ны өдөр эрх баригчид ОУВС-тай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх тухай ойлголцолд ажлын хэсгийн төвшинд хүрснийг зарласнаар 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдөр хугацаа нь дуусгавар болж байсан 580 сая ам.долларын евро бондоо Засгийн газар амжилттай дахин санхүүжүүллээ. ОУВС-гаас тавьсан шаардлагын хүрээнд Монгол улс энэхүү

өрийн 79 хувийг хуучин зээлдүүлэгчиддээ 7 жилийн хугацаатай шинэ бондоор солилцож, үлдэх хэсгийг нь хувийн хэвшлийн шинэ хөрөнгө оруулагч нараас босгосон байна. 2018 болон 2019 оны нэгдүгээр сард хугацаа нь дуусч байгаа бондын төлбөрийг зах зээлээс дахин санхүүжүүлэх болно.

Төсвийн бодлого

Дунд хугацааны төсвийн хүрээний үндсэн зорилго бол улсын өрийг тогтворжуулах явдал мөн. Монгол улсын төсвийн алдагдлыг гол төлөв гадаад, дотоодын зээлээр санхүүжүүлж ирснээс их хэмжээний улсын өр бий болсон байна. Өнгөрсөн дөрвөн жилийн туршид Засгийн газар дотоод зах зээлд бонд гаргах замаар их хэмжээний зээл авсан байна. Өрийн санхүүжилтийн зардал төсвийн тавны нэгд хүрч, Засгийн газрын 1 жил хүртэлх хугацаатай үнэт цаасны хүү дунджаар жилийн 15 орчим хувь байна. Засгийн газар орлогын дутагдлаас үүссэн төсвийн цоорхойг нөхөхийн тулд 1 хүртэлх жилийн хугацаатай үнэт цааснаас ихээхэн хэмжээнд хамааралтай байгаа учраас хандивлагчдаас ирэх төсвийн дэмжлэгийн зээлийг улсын өр болон өрийн санхүүжилтийн зардлыг бууруулахад ашиглана. Хөтөлбөрийн эхний жилд боломжтой санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлснээр Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас гаргах дарамтыг ихээхэн багасгаж, төсвөөс гарах өрийн санхүүжилтийн зардлыг бууруулж улмаар бага хүүтэй үе эхэлж байгаа дохиог дотоодын зах зээлд үр дүнтэй хүргэх юм. Төсвийн алдагдлыг бууруулж, улсын өрийн үр ашиг бүхий удирдлагыг хэрэгжүүлснээр улсын өрийг багасгах байр суурь дээр эрх баригчид тууштай байгаа юм.

Төсвийн алдагдал мэдэгдэхүйц хэмжээгээр буурна гэсэн хүлээлттэй байна. Өнгөрсөн дөрвөн жилд төсвийн тэлэлт болон төсвийн шинжтэй ажиллагааны зардлууд төсвийн алдагдлыг ихээхэн хэмжээгээр өсөн нэмэгдэхэд хувь нэмэр оруулсан байна. Монгол улсын Хөгжлийн банк болон Монголбанкны төсвийн шинжтэй үйл ажиллагааг оролцуулан төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ний 17 хувьд хүрсэн байна. Эрх баригчид төсвийн алдагдлыг багасгах, төсвийн шинжтэй үйл ажиллагааг зогсоох асуудалд өндөр ач холбогдол өгч байна. Төсвийн зардлыг мэдэгдэхүйц хэмжээгээр багасгаснаар Засгийн газар төсвийн алдагдлыг 2017 онд ДНБ-ний 7 орчим хувиар бууруулж, ДНБ-ний 10,4 хувьд хүргэхээр байна. Хөтөлбөрийн зорилтот үзүүлэлт ёсоор 2010 он гэхэд төсвийн алдагдлыг ДНБ-ний 2 хувиас доош хүртэл бууруулах юм.

Засгийн газар энэхүү зорилтот үзүүлэлтийг хангах дорвитой арга хэмжээ аваад байгаа юм.

Зардал тал дээр хийгдэх ажлуудын тухайд гэвэл эрх баригчид нийтийг хамарсан нийгмийн халамжийн зардлаас татгалзаж, хамгийн эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн зорилтот хөтөлбөрүүдэд шилжиж байгаа юм. Ингэснээр ирэх гурван жилийн хугацаанд ДНБ-ний 1,5 хувьтай тэнцэх хэмжээний зардал хэмнэх юм. Хөрөнгийн зардлыг ч ирэх жилүүдэд ихээхэн танах бөгөөд хэрвээ төсвийн орлогын байдал боломж олговол нэн шаардлагатай байгаа дэд бүтцийн хэрэгцээнд зориулах болно.

Олон нийтийн зүгээс ихээхэн эсэргүүцсэн боловч **4 дүгээр сарын 14-ний өдөр УИХ улс төрийн хувьд ихээхэн сорил дагуулсан татвар нэмэх шийдвэр гаргасан юм.** Ингэхдээ түүхий эдийн үнийн орчилоос хамаарсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулахын тулд эрх баригчид татварын бодлогын багц арга хэмжээ авсан юм. Үүнд шатахууны онцгой албан татвар, тээврийн хэрэгслийн татвар болон согтууруулах ундаа болон тамхины онцгой албан татвар, гаалийн татвар, хүн амын орлогын албан татварыг өсөн нэмэгдүүлэх горимд шилжүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэн банкны хадгаламжийн хүүгийн татварын босгыг арилгах зэрэг арга хэмжээ авсан байна. Эдгээр арга хэмжээ төсвийн орлогын тогтвортой урсгалыг бий болгох юм. Улс төрийн хувьд хүнд хэцүү байдалд, олон нийтэд таалагдахгүй татвар нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлснээр Засгийн газар эдийн засгийн реформ хийх болон ОУВС-гийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тууштай санаа зоригтой болохоо батлан илэрхийлж байгаа юм.

Мөнгөний болон ханшны бодлого

Үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлого хатуу хэвээр үргэлжлэх болно. Монголбанк валютын ханшийг макро эдийн засгийн суурь үзүүлэлттэй уялдуулан чөлөөтэй хөвөх байдлыг хэвээр хадгалж, гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх бүхий л аргыг эрэлхийлэх болно.

ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийн ажлын хэсгийн тайланд

дурьдсанчлан, урсгал дансны алдагдал их байгаагаас 2017 болон 2018 онуудад төлбөрийн тэнцлийн хэтийн тооцоо нэлээд дарамтад байхаар гарч байна.

Хэдий тийм ч, нүүрсний экспорт огцом өсөлт жилийн туршид хэвээр үргэлжлэх төлөвтэй байгаа учраас урсгал дансны тэнцэл хүлээгдэж байснаас арай хурдан сайжрах сүүлийн үеийн хандлага гарч ирж байна. Үүний зэрэгцээ, Монгол улсын Засгийн газар Таван толгой /коксжих нүүрсний уурхай/ болон Гацуурт /алтны уурхай/ зэрэг уул уурхайн томоохон төслүүдийг ойрын хугацаанд эхлүүлэх зорилго тавьж байна. Тийм учраас, төлбөрийн тэнцлийн төлөв байдал ОУВС-гийн Дүрмийн IV заалтын 2017 оны зөвлөлдөх хэлэлцүүлэгийн ажлын хэсгийн тайланд хийсэн урьдчилсан тооцооноос арай илүү эерэг гарч болзошгүй юм.

Өмнө хэрэгжүүлсэн тэлэх мөнгөний бодлого хийгээд Монголбанкны төсвийн шинжтэй үйл ажиллагааны улмаас гадаад нөөц 2012 онд 4,5 тэрбум ам.доллар байснаа 2016 оны эцсээр 1,3 тэрбум ам.доллар хүртлээ буурсан байна. Өмнөх алдааг давтахгүйн тулд төв банкны чиг үүргийг тодорхой болгож, хараат бус байдлыг нь бэхжүүлэн хамгийн гол нь бодлогын асуудлаар хамтын шийдвэр гаргадаг зарчмыг нэвтрүүлэх төв банкны тухай шинэ хуулийг батлах явдал амин чухал ач холбогдолтой юм. Санал болгож буй төв банкны тухай шинэ хуулийн төслийг энэ оны 11 дүгээр сард УИХ-д өргөн барьж, ирэх оны 3 дугаар сараас дагаж мөрдөх юм.

Санхүүгийн салбарын бодлого

Санхүүгийн салбарыг эрүүл мэднийн үзлэгт оруулж, үнэлгээ хийнэ. Санхүүгийн салбарын тогтвортой байдал нь эдийн засгийн ирээдүйн тогтвортой өсөлтийн тулгын чулуу билээ. Сүүлийн хэдхэн жилүүдэд банкуудын тэнцэл хурдацтай муудсан. Үндсэн шалтгаан нь гол төлөв ам.доллараар олгосон зээлийн багцад төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн уналт хийгээд түүхий эдийн үнийн уналтаас улбаатай эдийн засгийн ерөнхий доройтол сөрөг нөлөө үзүүлсэн байна. Чанаргүй зээлийн харьцаа өнөөгийн байдлаар 8.2 хувь байгаа бөгөөд банкуудын санхүүгийн байдалд нарийвчилсан иж бүрэн үзлэг хийх шаардлагатай байна. Эдийн засаг, санхүүгийн бодлогын меморандумд тодорхойлсон урьдчилсан арга хэмжээний нэг болохын хувьд ОУВС-ийн ажилтнуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Монголбанкнаас банкуудын активын чанарын үнэлгээ хийх олон улсын нэр хүнд бүхий компаниудыг хөлслөн авах шалгаруулалтыг Монголбанкнаас эхлүүлээд байна. Боломжит зөвлөх үйлчилгээний компаниудад активын чанарын үнэлгээ хийх сонирхлоо илэрхийлэх урилгыг Монголбанкнаас зарлаад байгаа ба хүсэлтийг 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл хүлээн авахаа зарлаад байна. Нэр дэвшигч компаниудыг сонгон шалгаруулах үйл явц 2017 оны 6 дугаар сарын эцсээр дуусгавар болох төлөвтэй байна. Активын чанарын үнэлгээний дүнгээс хамааран банкуудаас илэрсэн дутагдлаа засч залруулах, хамгийн гол нь өөрийн хөрөнгийн дутагдал илэрсэн бол түүнийгээ нөхөх дахин хөрөнгөжүүлэхийг банкуудаас шаардах юм. Санхүүгийн секторыг бүхэлд нь хамрах системийн эрсдэл тулгараагүй нөхцөлд эрх баригчид оролцохгүй юм.

ОУВС болон Монголбанкны ажилтнууд 2017 оны 6 дугаар сарын эцэс гэхэд активын ангилал болон эрсдлийн сан байгуулах тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулан батлах талаар тохирсон юм. Энэхүү журмыг ОУВС-гийн түрүүчийн техник туслалцааны төслийн хүрээнд өгсөн зөвлөмжийн үндсэн дээр аль хэдийн шинэчилсэн бөгөөд шинэчилсэн байдлаараа 2017 оны 12 дугаар сараас хойш хэрэгжиж байгаа юм. Эдгээр нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх тал дээр Монголбанк тууштай хатуу байр суурьтай байгаа боловч активын чанарын үнэлгээгээр гарч ирэх өөр бусад нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүртэл хойшлуулж байгаа юм. Хэдхэн сарын өмнө нэвтрүүлсэн журамд нэмэлт өөрчлөлт оруулах нь банкуудын хувьд хүндхэн байж болох талтай ч банкуудтай харьцах Монголбанкны харьцаанд итгэл эвдсэн асуудал ч үүсч болзошгүй гэж Монголбанк үзэж байна.

Дүгнэлт

Монгол улс байгалийн асар их нөөцтэй учраас эдийн засгийн урт хугацааны нөөц бололцоо ихтэй юм. Монгол улсын Засгийн газар хөтөлбөрт тусгасан урьдчилсан бүх арга хэмжээг авсан байна. Тухайлбал, төсвийн шинжтэй үйл ажиллагаагаа зогсоож, хөтөлбөрийн зорилтот үзүүлэлтэд нийцүүлэн төсвийн тодотголоо баталж, банкны секторын активын чанарын үнэлгээ хийх

компануудыг шалгаруулах ажиллагааг эхлүүллээ. Өргөгдсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн хэтийн төлөвийг сайжруулах, макро эдийн засгийн зохистой бодлого хэрэгжүүлснээр эерэг үр дүнд хүрч, улсын эдийн засаг удахгүй сэргэнэ гэдэгт Монгол улсын Засгийн газар итгэл дүүрэн байна. Түүхий эдийн үнийн ирээдүйн циклийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх төрөлжсөн олон салбар бүхий эрсдэл даах чадвартай эдийн засгийг бий болгох бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь гол сорил байх юм. Юун түрүүн Засгийн газар хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болохын хувьд төсвийн сахилга батыг хангаж, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлэх санаа зориг дүүрэн байгаа юм.

ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ, зорилгод тууштай зүтгэхээ эрх баригчид дахин нотолж байна.